МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

2019

УЛААНБААТАР ХОТ

ӨМНӨХ ҮГ

Засгийн газраас эдийн засгийг сэргээж, төсвийн сахилга батыг сайжруулж, төрийн үргүй зардлыг багасгаж, улсын өмчийн үр ашгийг дээшлүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар ард иргэдийнхээ бодит орлогыг өсгөх амлалтаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувьтай байсан бол 2017 онд 5.3 хувь, 2018 оны эхний хагас жилд 6.3 хувьд хүрч сайжирсан бөгөөд 2019 онд 8 хувьд хүргэх болно.

Төсвийн сахилга батыг чангатгаж, төрийн үргүй зардлыг багасгаж, улсын өмчийн үр ашгийг дээшлүүлэн өрийн дарамтыг бууруулна гэж Ерөнхий сайдаар томилогдохдоо амласан. Манай Засгийн газар өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 их наяд 698 тэрбум төгрөгийн өр, зээлийг төлж барагдууллаа. Мөн улсын төсөвт ихээхэн дарамт учруулж байсан өндөр хүүтэй үнэт цаас гаргахыг зогсоож зээлийн хүүгийн дарамтыг 285 тэрбум төгрөгөөр бууруулж чадлаа.

Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг 80 хувьд хүргэх, тэтгэвэр, тэтгэмжийг 2018 оны 2 дугаар сарын 1-ээс нэмэгдүүлэх, 2014 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан төрийн албан хаагчийн цалинг 2018 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн 8-30 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүллээ. Цаашид ч төрийн албан хаагчдын цалин, хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг жил бүр нэмэгдүүлнэ.

Ирэх онд Засгийн газар эдийн засгийг тогтвортой өсөлтөөр хангаж төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн **“Цахим, ил тод, үр ашигтай”** төсвийн бодлогыг авч хэрэгжүүлнэ. Энэ бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал, өрийн дарамтыг багасгах, бизнесийн орчинг дэмжсэн татварын шинэчлэлийг хэрэгжүүлэх, гаалийн шинэчлэлийн хүрээнд байгалийн баялгаасаа татвараа бүрэн авдаг болно.

Төсвийн зарлагын реформыг хэрэгжүүлж төсвийн тэгш бус хуваарилалтыг арилгаж ил тод болгох, агаарын бохирдлыг бууруулах бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эмнэлгийн бие даасан байдлыг хангаж санхүүжилтийн тогтолцоог зөв болгох, өрх, сумын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулах, малыг эрүүлжүүлж махны экспортыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг нэмэгдүүлэх, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутаг бүрэн хариуцдаг болгох, төрийн албан хаагчдын орон тоо, цалин хөлсний бүртгэлийг цахимжуулах замаар цалингийн зардлыг үр ашигтай зарцуулах, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах, гадаадын хөнгөлөлттэй зээлийг эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Засгийн газар Хүний хөгжил сангаас дамжин ирсэн 1,071.9 тэрбум төгрөгийн өрийг Ирээдүйн өв сангийн орлогоос барагдуулж дуусгана. Улмаар Ирээдүйн өв санд 2019 онд 553.1 тэрбум төгрөгийг хуримтлуулна. Ингэснээр Монгол Улс анх удаа байгалийн баялгийн орлогоосоо хуримтлал үүсгэж ирээдүй хойч үедээ өвлүүлж эхэлж байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 9,676.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.4 хувь, нийт зарлагыг 11,589.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.8 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг -1,913.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -5.4 хувь байхаар тооцлоо. Ийнхүү Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг төслийг боловсруулан танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2018.09.27 № 4-1/6161

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн төслүүдийн үзэл баримтлал, өргөн мэдүүлэх зөвшөөрөл болон холбогдох бусад материалын хамт хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасны дагуу хуулийн төслийг өргөн мэдүүлж өгнө үү.

Ч.ХҮРЭЛБААТАР

0 1476

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2018.09.27 № 4-1/6162

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төслийг холбогдох бусад материалын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Ч.ХҮРЭЛБААТАР

0 1/7

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.05.27 № 1-1/4724

танай 2018.05.24-ны № 4-1/6045-т

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Ш.НЯМДОРЖ

08 3072
Doc.yam a5.2018

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНГИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙГ
ӨРГӨН МЭДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬЁГ

1. **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

   1.1. Монгол улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

   1.2. Монгол улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

   1.3. Монгол улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

2. **МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

   2.1. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

   2.2. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл

   2.3. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн хавсралт

      2.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт

      2.3.2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

      2.3.3. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

      2.3.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2019 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг

   2.4. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

   2.5. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдан гарах хууль, тогтоомжийн төслүүд

3. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

   3.1. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
   3.2. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл
   3.3. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга
   3.4. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдан гарах хууль, тогтоомжийн төслүүд

4. **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

   4.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
   4.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл
   4.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

5. **ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД**

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт "Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ." гэж заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан дараахь тусгай шаардлагуудыг хангасан төсвийн үзүүлэлтийг ирэх оны төсөвт тусгах шаардлагатай юм. Үүнд:

1.Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх;

2.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2019 онд тухайн жилийн ДНБ-ий 6.9 хувиас илүүгүй байх;

3.Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь 2019 онд ДНБ-ий 75.0 хувиас хэтрэхгүй байх.

Эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт сэргэж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давахаар байгаатай уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тоон үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төслийг баталснаар Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн тохирсон зарим арга хэмжээ, 2018 оны төсөв батлагдсанаас хойш хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

--- oOo ---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ... -ны өдөр

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2019 он	2020 он	2021 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.0	6.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	8.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	9,676.5	10,713.5	11,844.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27.4	26.4	26.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	11,589.8	12,393.6	12,901.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.8	30.6	28.7
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,938.2	803.8	507.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.5	2.0	1.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,913.3	-1,680.1	-1,056.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-5.4	-4.1	-2.4
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,214.8	3,100.2	2,927.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.1	7.6	6.5
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	19,551.6	19,390.8	18,383.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.3	47.8	41.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	694.5	750.0	810.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	1.9	1.8

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль Улсын Их Хурлын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. Уг хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 8,888.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 25.6 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 10,993.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.7 хувь байхаар тус тус тооцож нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,105.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 6.1 хувийн алдагдалтай байхаар баталсан.

Гадаад дотоод эдийн засгийн нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний төлөв болон ирэх 2019 онд Засгаас газраас авч хэрэгжүүлэх Гааль, татварын шинэчлэлийн бодлогын хүрээнд татварын бааз суурийг нэмэгдүүлэн, төсвийн орлого бүрдүүлэлтийн бүхий л боломжийг бүрэн дайчилснаар төсвийн орлого нэмэгдэхээр тооцож байна.

Түүнчлэн, эдийн засгийн идэвхжилийг дэмжих, эрэлтийг тэлэх зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг сайжруулан өрхийн бодит орлогыг дээшлүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагын улмаас төсвийн нийт зарлага ч өсөхөөр байна.

Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх нөхцлийг бий болголоо.

Үүний дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаснаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ **9,676.5 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **27.4 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ **11,589.8 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 32.8 хувь**, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **-1,913.3 тэрбум төгрөг**ийн алдагдалтай буюу **ДНБ-ий –5.4** хувьтай байхаар байна.

--- oOo ---

2. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад "Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах" гэж тус тус заасны дагуу Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэгт заасан төсвийн жилд Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын гаргах баталгааны дээд хязгаар, төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлт, улсын төсвийн байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны санхүүжилт, улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх хэмжээ, хязгаар зэргийг тухайн жилийн төсвийн хуулиар тогтоон батлуулах хууль зүйн шаардлага үүссэн болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Монгол Улсын 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарлагын хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, төсвийн тогтворжуулалтын сан болон ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлттэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөл нь 4 бүлэг, 22 зүйл, 4 хавсралттай байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2018

оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын доод хэмжээ, зарцуулах зарлагын дээд хэмжээг, мөн төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг, 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2019 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, тус сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, Засгийн газрын 2019 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газрын өрийн хязгаарт багтаан өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвшөөрөх тухай;

Гуравдугаар бүлэгт: Орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээний тухай;

Дөрөвдүгээр бүлэгт: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар батлах тухай, улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2019 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг болон хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар тусгана.

Мөн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох тусгай шаардлагыг баримтлан, уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө төсвийн орлогод ихээхэн нөлөө үзүүлдэг гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг олон жилийн дундаж үнэ болох тэнцвэржүүлсэн үнээр тооцож, тэнцвэржүүлсэн үнээс давсан хэсгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх болон төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг жигд санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зарчмыг баримтална.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар 2019 оны төсвийн жилд Засгийн газраас чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр бий болж, зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Монгол Улсын төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд төсөв, татварын орлогыг тогтвортой байлгах, төсвийн санхүүжилтийг найдвартай эх үүсвэрээр хангахын тулд 2019 оны төсвийн төсөлд улсын төсвийн орлогыг бодитой төлөвлөх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг бий болгох, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай”, “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

--- oOo ---

<u>төсөл</u>

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	**Монгол Улсын Их Хурлын дарга**	**100.0**
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0
2	**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга**	**60.0**
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	60.0
3	**Санхүүгийн зохицуулах хорооны дарга**	**1,022.0**
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,022.0
4	**Монгол Улсын Ерөнхий сайд**	**317,400.4**
	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	3,000.0
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	310,800.0
	үүнээс: Ирээдүйн өв санд	300,870.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,600.4
5	**Монгол Улсын Шадар сайд**	**12,126.8**
	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	3,600.0
	Стандарт, хэмжил зүйн газар	3,600.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,926.8
6	**Засгийн газрын хэрэг эрхлэх газар**	**175.0**
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175.0
7	**Байгаль орчин, аялал жуулчлалын сайд**	**295.5**
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	295.5
8	**Гадаад харилцааны сайд**	**21,550.0**
	Дипломат төлөөлөгчийн газрууд	20,000.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,550.0
9	**Сангийн сайд**	**7,393,160.8**
	Татварын ерөнхий газар	4,117,000.0
	үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	322,000.0
	үүнээс: Ирээдүйн өв санд	767,650.0
	Гаалийн ерөнхий газар	2,949,695.1
	Сангийн яам	50,737.4
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	123,764.2
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	146,000.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,964.2
10	**Хууль зүй, дотоод хэргийн сайд**	**68,775.0**
	Улсын бүртгэлийн ерөнхий газар	19,800.0
	Цагдаагийн ерөнхий газар	3,100.0
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	20,600.7
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	8,175.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	17,099.3
11	**Батлан хамгаалахын сайд**	**48,206.9**
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	7,577.4
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	40,629.5
12	**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд**	**10,963.0**
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	5,000.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,963.0
13	**Зам, тээврийн хөгжлийн сайд**	**158,360.0**

	Иргэний нисэхийн ерөнхий газар	156,000.0
	Зам, тээврийн хөгжлийн яам	210.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,150.0
14	**Барилга, хот байгуулалтын сайд**	**1,850.0**
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1,850.0
15	**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд**	**406,678.3**
	Ашигт малтмал, газрын тосны газар	404,050.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,628.3
16	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд**	**184,821.4**
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	142,257.7
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	42,563.7
17	**Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд**	**46,755.2**
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	580.0
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	631.1
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	45,544.1
18	**Эрүүл мэндийн сайд**	**232,879.9**
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	205,904.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	26,975.5

4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 7,303,575.7 сая төгрөгөөр баталсугай.

5 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга**	**4,624.6**
	Урсгал зардал	4,624.6
2	**Монгол Улсын Их Хурлын дарга**	**35,306.5**
	Урсгал зардал	35,306.5
3	**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга**	**2,214.0**
	Урсгал зардал	2,214.0
4	**Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч**	**9,967.1**
	Урсгал зардал	5,967.1
	Хөрөнгийн зардал	4,000.0
5	**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга**	**51,072.7**
	Урсгал зардал	50,272.7
	Хөрөнгийн зардал	800.0
6	**Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга**	**989.4**
	Урсгал зардал	989.4
7	**Улсын ерөнхий прокурор**	**31,377.8**
	Урсгал зардал	29,977.4
	Хөрөнгийн зардал	1,400.4
8	**Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга**	**2,363.8**
	Урсгал зардал	2,363.8
9	**Монгол Улсын Ерөнхий аудитор**	**15,537.7**
	Урсгал зардал	14,037.7
	Хөрөнгийн зардал	1,500.0
10	**Авлигатай тэмцэх газрын дарга**	**13,624.4**
	Урсгал зардал	12,804.4
	Хөрөнгийн зардал	820.0
11	**Санхүүгийн зохицуулах хорооны дарга**	**3,762.2**
	Урсгал зардал	3,762.2
12	**Төрийн албаны зөвлөлийн дарга**	**1,322.2**
	Урсгал зардал	1,322.2
13	**Үндэсний статистикийн хорооны дарга**	**8,414.8**
	Урсгал зардал	8,414.8
14	**Сонгуулийн ерөнхий хорооны дарга**	**1,130.5**
	Урсгал зардал	1,130.5
15	**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга**	**553.4**
	Урсгал зардал	553.4
16	**Монгол Улсын Ерөнхий сайд**	**293,764.9**
	Урсгал зардал	94,223.4
	Хөрөнгийн зардал	199,541.5
17	**Монгол Улсын Шадар сайд**	**145,238.6**
	Урсгал зардал	132,595.3
	Хөрөнгийн зардал	12,643.3
18	**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга**	**49,950.1**
	Урсгал зардал	22,489.2
	Хөрөнгийн зардал	27,460.9
19	**Байгаль орчин, аялал жуулчлалын сайд**	**215,485.2**
	Урсгал зардал	132,457.2
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	70,000.0
	Хөрөнгийн зардал	13,028.0

20	**Гадаад харилцааны сайд**	**76,272.8**
	Урсгал зардал	73,397.8
	Хөрөнгийн зардал	2,875.0
21	**Сангийн сайд**	**4,675,767.0**
	Урсгал зардал	1,470,593.7
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	119,428.0
	Хөрөнгийн зардал	146,386.3
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,371,500.0
	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт	716,059.0
	Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт	851,800.0
22	**Хууль зүй, дотоод хэргийн сайд**	**533,992.3**
	Урсгал зардал	493,153.6
	Хөрөнгийн зардал	40,838.7
23	**Зам, тээврийн хөгжлийн сайд**	**179,842.2**
	Урсгал зардал	9,517.1
	Хөрөнгийн зардал	170,325.1
24	**Батлан хамгаалахын сайд**	**261,271.3**
	Урсгал зардал	245,771.6
	Хөрөнгийн зардал	15,499.7
25	**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд**	**1,763,708.9**
	Урсгал зардал	1,190,110.2
	үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	346,623.5
	Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	651,533.3
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	96,800.0
	Хөрөнгийн зардал	476,798.7
26	**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд**	**38,917.2**
	Урсгал зардал	12,295.3
	Хөрөнгийн зардал	26,621.9
27	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд**	**182,477.5**
	Урсгал зардал	129,840.5
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	23,500.0
	Хөрөнгийн зардал	29,137.0
28	**Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд**	**1,595,659.9**
	Урсгал зардал	1,571,902.1
	үүнээс: Хүүхдийн хөгжил хамгаллын тусгай зориулалтын шилжүүлэг	7,822.9
	Хөрөнгийн зардал	23,757.8
29	**Эрүүл мэндийн сайд**	**794,461.0**
	Урсгал зардал	713,444.8
	үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	129,845.5
	Хөрөнгийн зардал	81,016.2
30	**Эрчим хүчний сайд**	**114,706.6**
	Урсгал зардал	18,887.3
	Хөрөнгийн зардал	95,819.2
31	**Барилга, хот байгуулалтын сайд**	**112,855.6**
	Урсгал зардал	17,034.6
	үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	11,923.5
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	5,000.0
	Хөрөнгийн зардал	90,821.0

6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2019 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 9,357,150.7 сая төгрөгөөр баталсугай.

7 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг 1,217,550.8 сая төгрөгөөр баталсугай.

8 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүнг 144,699.2 сая төгрөгөөр баталсугай.

9 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2019 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 322,000.0 сая төгрөгөөр баталсугай.

10 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2019 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 1,068,520.0 сая төгрөгөөр баталсугай.

11 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс улсын төсөвт олгох шилжүүлгийн хэмжээг 50,000.0 сая төгрөгөөр баталсугай.

12 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээг 465,424.3 сая төгрөгөөр баталсугай.

13 дугаар зүйл.Засгийн газрын 2019 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 2,169,099.9 сая төгрөгөөр баталсугай.

14 дүгээр зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан Засгийн газрын өрийн хязгаарт багтаан өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

15 дугаар зүйл.Монгол Улсын 2019 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	19,752.9
2	Баян-Өлгий	16,798.2
3	Баянхонгор	24,858.0
4	Булган	9,310.4
5	Говь-Алтай	19,705.9
6	Дорноговь	8,689.7
7	Дорнод	4,783.1
8	Дундговь	17,344.5
9	Завхан	23,482.4
10	Өвөрхангай	22,438.6
11	Сүхбаатар	15,918.5
12	Сэлэнгэ	15,461.8
13	Төв	15,786.5
14	Увс	21,383.1
15	Ховд	17,989.0
16	Хөвсгөл	26,775.3
17	Хэнтий	18,687.7
18	Дархан-Уул	2,474.5
19	Говьсүмбэр	9,309.3
Нийт дүн		**310,949.5**

16 дугаар зүйл.2019 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Өмнөговь	45,201.1
2	Улаанбаатар	289,146.9
3	Орхон	6,090.3
Нийт дүн		**340,438.3**

17 дугаар зүйл.2019 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	5,469.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	540.0
2	Баян-Өлгий	7,281.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	365.6
3	Баянхонгор	6,485.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	638.5
4	Булган	3,570.1
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	524.3
5	Говь-Алтай	6,253.5
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	479.4
6	Дорноговь	6,795.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	184.5
7	Дорнод	6,104.7
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	500.0
8	Дундговь	3,627.5
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	305.4
9	Завхан	5,334.1
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	297.4
10	Өвөрхангай	6,680.4
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	482.9
11	Өмнөговь	6,402.0
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	376.8
12	Сүхбаатар	5,304.8
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	494.8
13	Сэлэнгэ	5,825.4
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	482.5
14	Төв	5,094.7
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	538.7
15	Увс	6,446.2
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	439.9

16	Ховд	6,667.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	607.4
17	Хөвсгөл	8,407.4
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	962.4
18	Хэнтий	5,052.7
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	558.4
19	Дархан-Уул	4,661.9
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	1,026.1
20	Улаанбаатар	26,509.2
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	297.0
21	Орхон	4,972.5
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	301.1
22	Говьсүмбэр	926.3
	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	60.3
Нийт дүн		**143,874.7**

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл."Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаархи чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

19 дүгээр зүйл."Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

20 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

21 дүгээр зүйл.Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2019 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэгийг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

22 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2019 оны зорилтот түвшин
1	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**			
	1.1	**Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа**		
		1.1.1	Төрийн байгуулал, улс орны удирдлагын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүх эрх мэдлийн байгууллагуудтай хамтарч ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		1.1.2	Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах чиглэлд хэрэгжиж байгаа хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санаачилга гарган ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		1.1.3	Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		1.1.4	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
2	**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**			
	2.1	**Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих**		
		2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	100-аас доошгүй ажлын өдөр хуралдаж хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах
		2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох	10-аас доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох
		2.1.3	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	хуульд заасны дагуу хангагдсан байх
3	**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА**			
	3.1	**Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих**		
		3.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн барагдуулалт	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх
		3.1.2	Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх
		3.1.3	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн дунд, их суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх
4	**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**			
	4.1	**Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа**		
		4.1.1	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх эрүүгийн хэргийн тоо	772
		4.1.2	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх иргэний хэргийн тоо	1440

		4.1.3	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх захиргааны хэргийн тоо	518
5	**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**			
	5.1	**Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах**		
		5.1.1	Хуулийн хугацаанд шийдвэрлэх хэрэг /хувиар/	93.0
6	**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА**			
	6.1	**Хүний эрхийн хэрэгжилтийг хангах**		
		6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл	1
		6.1.2	Хяналт шалгалт, судалгаа, дүн шинжилгээ	Хяналт шалгалт-20, судалгаа мониторинг-6, хууль тогтоомжийн дүн шинжилгээ, санал гаргах 30
		6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх	Гомдол шалгаж шийдвэрлэх-600, хууль зүйн зөвлөгөө-3000
		6.1.4	Хүний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл-2, шаардлага-20, зөвлөмж-25
		6.1.5	Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар боловсрол, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлууд зохион байгуулах	400 цагийн сургалтыг 6000 хүнд
7	**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР**			
	7.1	**Прокурорын хяналт**		
		7.1.1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих /хувиар/	100.0
		7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаанд буюу хорих анги, цагдан хорих байрнуудын үйл ажиллагаанд хяналт тавих тоо	6845
		7.1.3	Улсын хэмжээнд шийдвэрлэсэн зөрчлийн тоо	850000
8	**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**			
	8.1	**Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах**		
		8.1.1	Бодлогын зөвлөгөө /тоогоор/	80
		8.1.2	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	90
9	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР**			
	9.1	**Төрийн аудитын үйлчилгээ**		
		9.1.1	Санхүүгийн тайлангийн аудит /тоогоор/	6523
		9.1.2	Гүйцэтгэлийн аудит /тоогоор/	59
		9.1.3	Нийцлийн аудит /тоогоор/	33
10	**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА**			
	10.1	**Авлигатай тэмцэх**		
		10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо	3200
		10.1.2	Авлигын эсрэг сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	11000
		10.1.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх судалгаа, дүн шинжилгээ	15
		10.1.4	Иргэд, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	98.0
		10.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц ажил арга хэмжээ	15
11	**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА**			
	11.1	**Санхүүгийн зах зээлийн зохицуулалт**		
		11.1.1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах /шинээр боловсруулах хуулийн төсөл/	8
		11.1.2	Шинээр буюу шинэчлэгдэн боловсруулагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэн банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгдөх дүрэм журамд өөрчлөлт оруулах	170
		11.1.3	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан	250

			хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын тоо/	
		11.1.4	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	8
		11.1.5	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		11.1.6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хэрэгжилтийг хангах, Монгол Улсын тогтолцооны үнэлгээг сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		11.1.7	Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	6
12	**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**			
	12.1	**Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт**		
		12.1.1	2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, дагалдах хуулиудын хэрэгжилтийг хангасан байх	Төрийн албаны тухай хууль түүнийг дагаж гарсан 46 орчим дүрэм журам, зохицуулалтууд төрийн албаны шаардлагад нийцсэн байх
		12.1.2	Төрийн албан тушаалын тодорхойлолт тухайн ажлын байрны чиг үүргийг хэрэгжүүлэхүйц байдлаар нэгдсэн журмаар Төрийн албаны зөвлөлийн хяналт дор батлагдаж, төрийн албан тушаалыг хаших адил тэгш боломжоор хангагдсан байх	Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн удирдлагын төлөвлөгөөнөөс урган гарсан албан тушаалын тодорхойлолттой болсон байх
		12.1.3	Төрийн албаны чадахуйн зарчимд тулгуурласан, албан тушаалд шатлан дэвших боломжийг хадгалсан төрийн албан тушаалын ангилал зэрэглэлийг буй болгох	Албан хаагчдын албан тушаал ахих чадахуйн зарчмыг дээдлэх, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байх
		12.1.4	Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх сургалт, арга зүйг буй болгох
		12.1.5	Гүйцэтгэлийн үнэлгээний стандарт, дүрэм журам шинэчлэгдсэн, хяналт үнэлгээ хийгдсэн байна	Гүйцэтгэлийн үнэлгээний дүрэм журмыг олон улсын жишигт нийцсэн байдлаар боловсруулах
		12.1.6	Хариуцлагын тогтолцоог сайжруулах	Хариуцлага алдсан албан хаагчийн ногдуулах сахилгын шийтгэлийн хэлбэрийг нарийсгах
13	**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА**			

	13.1	**Албан ёсны статистикийг хөгжүүлэх**		
		13.1.1	Албан ёсоор гаргах статистикийн мэдээ, тайлангийн нэр төрөл	290
		13.1.2	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тоо /мянгаар/	112.1
		13.1.3	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт	47
		13.1.4	Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилж эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	20
		13.1.5	Статистикийн тухай хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний судалгааны тоо	16
14	**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА**			
	14.1	**Бүх шатны сонгууль зохион байгуулах**		
		14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт	20
		14.1.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	3
		14.1.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсөх хувь/	5.0
		14.1.4	Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	10 удаа
		14.1.5	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах /тоогоор/	5000
		14.1.6	Програм хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх
15	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**			
	15.1	**Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт**		
		15.1.1	Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаар цаг үеэ олсон шуурхай лавлагаа, зөвлөмж боловсруулж, Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллах	тухай бүрд
		15.1.2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон улсын хөрөнгө оруулалтын статистикийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/	100.0
		15.1.3	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах /богино болон дунд хугацааны/	3
		15.1.4	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан, аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/	100.0
		15.1.5	Хөгжлийн томоохон төслүүдийн санал, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбарыг боловсруулж, батлуулах, саналыг нэгтгэн судалгааг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, хянах, батлуулах	1
	15.2	**Дотоод, гадаад шуурхайн мэдээллийн үйл ажиллагаа**		
		15.2.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/	240.4
		15.2.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/	209.3
		15.2.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх /хувиар/	3.0
		15.2.4	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувиар/	5.0
	15.3	**Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөр**		
		15.3.1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /төрийн албан хаагчийн тоо, мянгаар/	3.0
		15.3.2	Монгол Улсын иргэн бүрд цахим гарын үсэг олгох /мянган хүн/	100.0
		15.3.3	Төрөөс цахим хэлбэрээр шинээр хүргэх үйлчилгээний тоо	50
		15.3.4	Орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах сумдын тоо	3
		15.3.5	Хөдөө орон нутгийн алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх багийн тоо	10-15
		15.3.6	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт шилэн кабелийн сүлжээнд холбох сумдын тоо	5
		15.3.7	ХУР системд холбогдох төрийн байгууллагын тоо	15
		15.3.8	ХУР системээр дамжуулан хүргэх цахим үйлчилгээний тоо	50
		15.3.9	ХУР системийг ашиглах байгууллагын тоо	40
	15.4	**Ангилагдаагүй бусад хөтөлбөр**		
		15.4.1	Монгол Улсын ОҮИТБС-ын 2017 оны нэгдсэн тайлан гарсан байх /хамрагдах хуулийн этгээдийн тоо/	220
		15.4.2	Цөмийн энергийн салбарт баримтлах бодлого, хууль тогтоомжийг	100.0

			хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах /хувиар/	
		15.4.3	Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх /тоогоор/	180
	15.5	**Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх**		
		15.5.1	Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу хугацаанд нь зохион байгуулах	тухай бүр хугацаанд нь зохион байгуулах
		15.5.2	Иргэн, хуулийн этгээдэд цахим худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах /тоогоор/	80
		15.5.3	Захиалагч байгууллагад цахим худалдан авах ажиллагааны сургалт явуулах /тоогоор/	250
		15.5.4	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтын тоо	35
		15.5.5	Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын тоо	35
		15.5.6	Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт /өмч эзэмшлийн гэрээний дүгнэлтийн хувь/	100.0
		15.5.7	Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулж, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх	орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх
		15.5.8	Өмч хувьчлалын үйл ажиллагааг цаг тухай бүрт нь зохион байгуулж, орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх
	15.6	**Жендерийн эрх тэгш байдлыг хангах**		
		15.6.1	Яамд /салбар/-ын жендерийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн тоо	яам 7, аймаг, дүүрэг 20
		15.6.2	Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ хийсэн яам /салбар/, аймаг, дүүрэг	яам 7, аймаг, дүүрэг 20
		15.6.3	Жендерийн үндэсний сургагч багшийн тоо	135
	8	Орхон сум	15,915.1	11,217.3	27,132.4
	9	Орхонтуул сум	32,104.9	22,434.1	54,539.0
	10	Сайхан сум	44,763.1	31,693.3	76,456.4
	11	Сант сум	15,767.5	10,631.9	26,399.5
	12	Сүхбаатар сум	49,007.7	34,552.7	83,560.4
	13	Түшиг сум	18,269.9	11,203.7	29,473.5
	14	Хушаат сум	15,025.1		15,025.1
	15	Хүдэр сум	22,407.0		22,407.0
	16	Цагааннуур сум	32,575.4	22,520.4	55,095.8
	17	Шаамар сум	12,185.7	8,816.7	21,002.3
	Төв		**489,394.9**	**231,359.9**	**720,754.8**
	1	Алтанбулаг сум	19,988.4	13,126.0	33,114.4
	2	Аргалант сум	8,365.2	5,827.9	14,193.1
	3	Архуст сум	6,202.7	4,108.1	10,310.8
	4	Батсүмбэр сум	30,197.6		30,197.6

Д/д		Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
14	5	Баян сум	12,402.8	8,266.9	20,669.7
	6	Баяндэлгэр сум	9,330.4		9,330.4
	7	Баянжаргалан сум	11,047.6	7,296.0	18,343.6
	8	Баян-Өнжүүл сум	17,667.1	11,643.7	29,310.8
	9	Баянхангай сум	7,888.4	5,382.1	13,270.6
	10	Баянцагаан сум	19,297.1	12,887.2	32,184.4
	11	Баянцогт сум	10,131.1	6,751.6	16,882.7
	12	Баянчандмань сум	15,657.0		15,657.0
	13	Борнуур сум	22,190.2	15,169.1	37,359.3
	14	Бүрэн сум	21,324.7	14,178.4	35,503.1
	15	Дэлгэрхаан сум	13,284.2	8,716.3	22,000.4
	16	Жаргалант сум	31,621.7		31,621.7
	17	Заамар сум	33,730.2	22,055.9	55,786.0
	18	Зуунмод сум	35,163.1	23,538.7	58,701.8
	19	Лүн сум	15,994.4	10,728.2	26,722.6
	20	Мөнгөнморьт сум	22,527.9	15,006.6	37,534.5
	21	Өндөрширээт сум	15,363.6	10,058.9	25,422.5
	22	Сүмбэр сум	9,066.1	6,555.2	15,621.3
	23	Сэргэлэн сум	12,215.2		12,215.2
	24	Угтаалцайдам сум	15,310.3		15,310.3
	25	Цээл сум	15,853.3	10,437.4	26,290.7
	26	Эрдэнэ сум	28,145.6		28,145.6
	27	Эрдэнэсант сум	29,429.2	19,625.6	49,054.8
15	**Увс**		**598,197.2**	**199,442.2**	**797,639.4**
	1	Баруунтуруун сум	28,835.3		28,835.3
	2	Бөхмөрөн сум	25,692.1	18,738.7	44,430.8
	3	Давст сум	26,730.0	19,411.9	46,141.9
	4	Завхан сум	29,987.3		29,987.3
	5	Зүүнговь сум	27,625.7		27,625.7
	6	Зүүнхангай сум	33,131.3	24,550.4	57,681.7
	7	Малчин сум	23,460.7		23,460.7
	8	Наранбулаг сум	35,233.6		35,233.6
	9	Өлгий сум	19,485.4		19,485.4
	10	Өмнөговь сум	33,751.7	23,119.1	56,870.8
	11	Өндөрхангай сум	43,664.7	31,376.9	75,041.6
	12	Сагил сум	20,535.0	15,040.3	35,575.3
	13	Тариалан сум	24,340.8	17,616.9	41,957.7
	14	Түргэн сум	14,013.7	10,490.2	24,504.0
	15	Тэс сум	42,883.7		42,883.7
	16	Улаангом сум	89,718.6		89,718.6
	17	Ховд сум	25,281.5	18,752.0	44,033.5
	18	Хяргас сум	26,365.5		26,365.5
	19	Цагаанхайрхан сум	27,460.6	20,345.7	47,806.3
	Ховд		**635,540.1**	**45,576.2**	**681,116.3**
	1	Алтай сум	59,414.6		59,414.6
	2	Булган сум	122,659.3		122,659.3
	3	Буянт сум	21,406.9	15,294.2	36,701.1
	4	Дарви сум	33,350.1		33,350.1

Д/д		Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
16	5	Дуут сум	14,050.6		14,050.6
	6	Дөргөн сум	24,838.7		24,838.7
	7	Зэрэг сум	22,998.2	16,584.2	39,582.4
	8	Манхан сум	29,339.5		29,339.5
	9	Мянгад сум	21,528.8		21,528.8
	10	Мөст сум	28,689.9		28,689.9
	11	Мөнххайрхан сум	18,736.2	13,697.8	32,434.0
	12	Үенч сум	54,481.7		54,481.7
	13	Ховд сум	19,361.9		19,361.9
	14	Цэцэг сум	29,917.5		29,917.5
	15	Чандмань сум	31,530.6		31,530.6
	16	Эрдэнэбүрэн сум	16,338.1		16,338.1
	17	Жаргалант сум	86,897.5		86,897.5
17	**Хөвсгөл**		**803,614.0**	**488,722.7**	**1,292,336.7**
	1	Алаг-Эрдэнэ сум	34,376.4	23,458.8	57,835.2
	2	Арбулаг сум	23,351.0	-	23,351.0
	3	Баянзүрх сум	29,302.9	20,497.3	49,800.2
	4	Бүрэнтогтох сум	23,993.8	16,407.0	40,400.8
	5	Галт сум	38,750.6	26,425.3	65,175.8
	6	Жаргалант сум	36,630.8	25,412.6	62,043.4
	7	Их-Уул сум	23,294.9	16,094.6	39,389.4
	8	Рашаант сум	24,514.5	16,982.2	41,496.8
	9	Рэнчинлхүмбэ сум	54,473.6	38,050.9	92,524.5
	10	Тариалан сум	41,320.9	27,972.7	69,293.6
	11	Тосонцэнгэл сум	20,513.0	14,035.4	34,548.4
	12	Төмөрбулаг сум	22,459.2		22,459.2
	13	Түнэл сум	22,349.8		22,349.8
	14	Улаан-Уул сум	48,246.5	33,668.2	81,914.6
	15	Ханх сум	34,157.4	23,527.0	57,684.3
	16	Цагаан-Уул сум	42,131.2	28,946.9	71,078.1
	17	Цагааннуур сум	27,345.1		27,345.1
	18	Цагаан-Үүр сум	35,720.3	24,651.8	60,372.1
	19	Цэцэрлэг сум	46,131.9	32,327.7	78,459.6
	20	Чандмань-Өндөр сум	25,919.3	18,144.2	44,063.5
	21	Шинэ-Идэр сум	21,232.1	14,715.6	35,947.6
	22	Эрдэнэбулган сум	31,548.5	21,311.7	52,860.2
	23	Мөрөн сум	95,850.4	66,093.0	161,943.4
18	**Хэнтий**		**459,503.3**	**214,588.1**	**674,091.4**
	1	Батноров сум	32,442.6	13,602.2	46,044.8
	2	Батширээт сум	26,398.7	16,031.2	42,429.9
	3	Баян-Адрага сум	18,566.2	12,039.9	30,606.1
	4	Баянмөнх сум	11,599.8	7,813.5	19,413.3
	5	Баян-Овоо сум	14,633.0	9,463.4	24,096.4
	6	Баянхутаг сум	17,549.5		17,549.5
	7	Биндэр сум	32,394.6		32,394.6
	8	Бор-Өндөр сум	52,575.5	35,084.6	87,660.1
	9	Галшар сум	22,771.3	13,542.2	36,313.5
	10	Дадал сум	30,098.3	19,542.8	49,641.1

Д/д	Аймаг, сум		Дэмжлэг	Урамшуулал	Нийт
	11	Дархан сум	17,513.0	11,389.4	28,902.4
	12	Дэлгэрхаан сум	16,350.4	10,146.2	26,496.5
	13	Жаргалтхаан сум	14,058.1	9,314.7	23,372.7
	14	Мөрөн сум	9,502.2	6,345.8	15,848.0
	15	Норовлин сум	24,357.5	15,750.6	40,108.2
	16	Өмнөдэлгэр сум	43,293.0	24,537.2	67,830.1
	17	Хэрлэн сум	59,797.8		59,797.8
	18	Цэнхэрмандал сум	15,601.9	9,984.6	25,586.4
19	**Дархан-Уул**		**460,398.2**	**288,282.7**	**748,680.9**
	1	Дархан сум	156,647.4	97,755.4	254,402.8
	2	Орхон сум	48,539.1	30,288.5	78,827.6
	3	Хонгор сум	138,343.3	86,702.9	225,046.1
	4	Шарын Гол сум	116,868.5	73,535.9	190,404.4
20	**Орхон**		**526,528.8**	**176,004.0**	**702,532.8**
	1	Баян-Өндөр сум	249,264.9	176,004.0	425,268.9
	2	Жаргалант сум	277,263.9		277,263.9
21	**Говьсүмбэр**		**91,465.7**	**61,393.2**	**152,858.9**
	1	Баянтал сум	12,750.1	8,528.1	21,278.2
	2	Сүмбэр сум	45,383.9	30,435.8	75,819.7
	3	Шивээговь сум	33,331.7	22,429.3	55,761.0
	НИЙТ		**10,563,044.0**	**4,615,348.0**	**15,178,392.0**

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2018 он

АГУУЛГА

1. **МАКРО ЭДИЙН ЗАСАГ** 3
   1.1. Дэлхийн Эдийн Засаг *3*
   1.2. Монгол Улсын Эдийн Засаг *4*
2. **2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН БОДЛОГО** 10
   2.1. Төсвийн Орлогын Чиглэлээр: *10*
   2.2. Төсвийн Урсгал Зардлын Чиглэлээр: *12*
   2.3. Төсвийн Хөрөнгө Оруулалтын Чиглэлээр: *15*
   2.4. Гадаадын Зээл Тусламж, Засгийн Газрын Өрийн Чиглэлээр *16*
3. **НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД** 18
   3.1. Төсвийн Нэгдсэн Үзүүлэлтүүд *18*
   3.2. Төсвийн Тусгай Шаардлага *19*
4. **ТӨСВИЙН ОРЛОГО** 20
   4.1. Нэгдсэн Төсвийн Нийт Орлого *20*
   4.2. Төсвийн Тогтворжуулалтын Сангийн Орлого *20*
   4.3. Ирээдүйн Өв Сангийн Орлого *20*
   4.4. Уул Уурхайн Салбарын Орлого *21*
   4.5. Эдийн Засаг Дахь Татварын Ачаалал *21*
   4.6. Татварын Орлого *22*
   4.7. Татварын Бус Орлого *26*
   4.8 Төсвийн Орлогын Гүйцэтгэлд Учирч Болзошгүй Эрсдэл *26*
5. **ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГА** 28
   5.1. Нэгдсэн Төсвийн Урсгал Зардлын Тойм *28*
   5.2. Урсгал Зардлын Өөрчлөлт *28*
   5.3. Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалал *29*
   5.4. Агаарын Бохирдлыг Бууруулах *30*
   5.5. Эрүүл Мэнд *30*
   5.6. Боловсролын Хүртээмжийг Нэмэгдүүлэх *31*
   5.7. Хөдөө Аж Ахуй, Уул Уурхай *32*
   5.8. Аюулгүй Байдал *32*
   5.9. Төрийн Албан Хаагчийн Нийгмийн Баталгаа *34*
   5.10. Орон Тооны Өөрчлөлт *34*
   5.11. Орон Нутгийн Өмчийн Байр Ашиглалтын Зардал *35*
   5.12. Төрийн Бусад Үйлчилгээ *35*
   5.13. Засгийн Газрын Тусгай Сан *37*
   5.14. Нийгмийн Даатгалын Сан *38*
   5.15. Эрүүл Мэндийн Даатгалын Сан *41*
   5.15. Эргэж Төлөгдөх Зээл *43*
6. **ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** 45
   6.1. Хөрөнгө Оруулалтын Төлөвлөлтөд Гарч Буй Нийтлэг Алдаа Дутагдал, Зайлшгүй Анхаарах Асуудал *45*
   6.2. Хөрөнгө Оруулалтын Төлөвлөлт *46*
7. **ОРОН НУТГИЙН ТӨСӨВ** 49
8. **ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ** 51
   8.1. Гадаад Зээл, Тусламжийн Ашиглалтын Мэдээлэл *51*
   8.2. Төслүүдийг Санхүүжүүлэхэд Баримтлах Зарчим *51*
   8.3. Гадаад Зээл, Тусламжийн Төслүүдийг Санхүүжүүлэхэд Тулгарч Буй Асуудал, Түүний Шийдэл *51*
   8.4. 2019 Онд Гадаадын Зээл, Тусламжийг Нийгэм, Эдийн Засгийн Үр Ашигтай Төслүүдэд Дараах Чиглэлээр Ашиглана: *52*
9. **ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР** 57
   9.1. Засгийн Газрын Өрийн Удирдлага *57*
   9.2. Болзошгүй Өр Төлбөр *60*

1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ

1.1. Дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2019 онд 3.7 хувь болж, ***өмнө төсөөлж байснаас саарахаар*** *байна.*

АНУ-ын Засгийн газрын зардлын хэт өсөлт саармагжиж, бусад улстай хийж буй худалдааны маргаан болон Ираны хоригоос үүдэлтэй газрын тосны үнийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн 2019 оны өсөлтийг сааруулж, тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт саарч байна. Хөгжиж буй орнуудын хөрөнгийн урсгал буурч, санхүүжилтийн өртөг нэмэгдэж, валютын ханш суларч байна.

ОУВС 2018 оны 7 дугаар сард нийтэлсэн "Дэлхийн эдийн засгийн төсөөлөл" тайландаа 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг 3.9 хувь гэж төсөөлж байсан бол дээрх нөхцөл байдлын улмаас эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.7 хувь болгон бууруулсан.

Хүснэгт № 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт

Бүс нутаг	2017	2018	2019
Дэлхий	3.7	3.9	3.7
Өндөр хөгжилтэй орнууд	2.4	2.4	2.2
АНУ	2.3	2.9	2.7
Евро бүс	2.4	2.2	1.9
Япон	1.7	1.0	0.9
Хөгжиж буй орнууд	4.7	4.9	5.1
Хөгжиж байгаа азийн орон	6.5	6.5	6.5
ОХУ	1.5	1.7	1.5
БНХАУ	6.9	6.6	6.4

Эх үүсвэр: ОУВС-гийн "Дэлхийн эдийн засгийн төсөөлөл" тайлан.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2018 онд харьцангуй нэмэгдсэн ч 2019 онд саарахаар байна. Хувийн хэрэглээний өсөлт болон төсвийн тэлэлт нь тус улсын эдийн засгийг 2018 онд дэмжсэн. Ингэснээр сүүлийн 50 жилд хамгийн бага ажилгүйдлийн түвшинд хүрч, инфляцын дарамтыг бий болгож байна. Дотоодын өндөр эрэлтийн улмаас импорт өсөж АНУ-ын урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Харин тус улсын Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүгээ нэмэгдүүлж, мөнгөний бодлогыг чангаруулснаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын өсөлт 2019 онд саарч болзошгүй байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт дэлхийн худалдааны сэргэлтээс шалтгаалан 2017 онд нэмэгдэж байсан бол 2018-2019 онд саарахаар байна. Тус улсын засгийн газраас санхүүгийн салбарын зохицуулалтыг чангаруулсан, АНУ-аас тавьж буй худалдааны хориг болон гадаад зах зээлийн эрэлтийн бууралттай холбоотой юм.

Япон улсын эдийн засгийн өсөлт өмнөх оноос 0.1 нэгжээр буурч, 0.9 хувь болохоор байна. Хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт сул байгаа нь тус улсын эдийн засгийн өсөлтийг 2018 онд сааруулах гол шалтгаан болж байна.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2019 онд саарахаар байна. Энэ нь Герман, Франц улсуудын эдийн засгийн өсөлт 2018 оны эхний улиралд төсөөллөөс доогуур гарсан, мөн Итали улсын санхүүгийн хатуу бодлоготой холбоотой юм.

Дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд саарахаар байгаа нь манай худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, улмаар экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

1.2. Монгол Улсын эдийн засаг

1.2.1. Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлт ***2019 онд 8 хувь*** *байхаар байна.*

Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж, 2018 оны эхний хагас жилд 6.3 хувь болж өмнөх оноос 1 нэгжээр нэмэгдэв. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах зорилгоор төсвийн алдагдлыг багасгаж, Засгийн газрын дотоод бондын хэмжээг бууруулах, улмаар хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг 2017-2018 онд хэрэгжүүллээ.

Ийнхүү хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг хангах төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлснээр 2018 оны эхний хагаст хөрөнгө оруулалт буюу үндсэн хөрөнгийн хуримтлалын хэмжээ 40 хувиар өслөө.

Засгийн газар дотоод зах зээлээс авсан өрийн хэмжээгээ 2018 оны эхний хагас жилийн байдлаар 900 орчим тэрбум төгрөгөөр бууруулж, зээл олгох эх үүсвэрийг чөлөөлсний үр дүнд арилжааны банкууд 2018 оны эхний хагас жилд 2.2 их наяд төгрөгийн зээлийг иргэд, аж ахуйн нэгжид олгосон байна. Мөн Монголбанк бодлогын хүүгээ 10 хувь болгон бууруулсан нь арилжааны банкнуудын зээл олгох сонирхлыг нэмэгдүүлэв. Хөрөнгө оруулалт, зээл олголт нэмэгдэж, бизнесийн идэвхжил сэргэсэн нь өрхийн орлогыг нэмэгдүүлж, хэрэглээг дэмжив. Эдийн засгийн өсөлт 2018 онд 7.1 хувь болж, өмнөх оны түвшнээс нэмэгдэхээр байна.

График № 1. Эдийн засгийн өсөлт

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам

Засгийн газраас 2018 оны 9 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлж байгаа нь оны эцэс гэхэд өрхийн хэрэглээг дэмжихээр байна. Гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэж байгаа тул Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг урт хугацааны дундаж өсөлтийн түвшинд хадгалахыг зорьж байна.

Засгийн газар эдийн засгийн өсөлтийг хангах дараах бодлогыг 2019 онд хэрэгжүүлнэ:

1.Татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, бизнесийн орчныг сайжруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, бодит салбаруудын өсөлтийг дэмжинэ.

3.Төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг сайжруулах замаар өрхийн хэрэглээг өсгөнө.

4.Газрын тос боловсруулах үйлдвэр, Төв цэвэрлэх байгууламж зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж, нийт эдийн засгийн потенциал хүчин чадлыг дээшлүүлнэ.

Шигтгээ 1: АНУ болон БНХАУ-ын худалдааны асуудал

АНУ болон БНХАУ-ын хооронд худалдааны маргаан үүсэж, АНУ-аас БНХАУ-ын 250 тэрбум ам.долларын импортын барааанд татвар ногдуулахаар болов. АНУ өнгөрсөн 7-р сард Хятадын 50 тэрбум ам.долларын дүнтэй барааанд 25 хувийн импортын татвар оноож эхэлсэн бол 9 дүгээр сараас эхлэн дахин $200 тэрбумын барааанд 10 хувийн импортын татварыг оноож байна. Хоёрдугаар ээлжийн барааны тариф нь 2019 оноос эхлэн 25 хувь болж өсөх төлөвтэй байна. Харин БНХАУ-ын зүгээс АНУ-ын нийт 110 тэрбум ам.долларын импортод татвар ногдуулах замаар хариу арга хэмжээ авав.

АНУ-ын импортын татвар нь БНХАУ-ын хямд өртөг бүхий ажиллах хүч, томоохон зах зээлийг түшиглэн байршсан гадаадын хөрөнгө оруулагчдын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байгаа тул хөрөнгө оруулагчид БНХАУ-аас үйлдвэрээ шилжүүлэх шийдвэр гаргаж байна.

Тухайлбал, компьютерийн санах ойн чип үйлдвэрлэгч Өмнөд Солонгосын SK Hynix компани, АНУ-ын Micron Technology, автомашины бампер, эд анги үйлдвэрлэгч Toshiba Machine Co зэрэг компаниуд зарим үйлдвэрээ нүүлгэхээ зарлаад байна.

Мөн худалдааны маргааны нөлөөгөөр дэлхийн зах зээл дээрх зэс, цайр, төмрийн хүдэр зэрэг түүхий эдийн үнэ 2018 оны 7 дугаар сараас эхлэн буурах хандлага үйл явц ажиглагдаж байна.

1.2.2. Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 23.7 хувиар өсөж гадаад худалдааны тэнцэл 0.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа боловч ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар буурсан байна.

График № 2. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Төмрийн хүдрээс бусад голлох эрдэс, түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байгаа нь экспорт өсөхөд голлон нөлөөлсөн байна. Энэ оны эхний 8 сарын байдлаар 4.7 тэрбум ам.долларын бараа, түүхий эд экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.9 хувиар өссөн байна.

Дотоод эдийн засгийн сэргэлт, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр импорт 38.3 хувиар өсөж, 3.8 тэрбум ам.долларт хүрлээ. Дизелийн түлш, машин, тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашин, ургамлын гаралтай бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр байна.

Хүснэгт № 2. Импортын бүтээгдэхүүн, төрлөөр /2017 оны гүйцэтгэл, 2018 оны ХБГ/, сая ам.доллар

	2017	2018 ХБГ	Өсөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,148	1,542	34.3%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,619	2,505	54.7%
Аж үйлдвэрийн орц	563	641	13.9%
Нефтийн бүтээгдэхүүн	692	956	38.1%
Бусад	312	506	62.1%
НИЙТ	4,335	6,150	41.9%

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2018 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.6 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. Ам.долларын ханш голлох валютууд болон түүхий эдийн эсрэг чангарч, манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурч байгаа нь экспортын хэмжээнд сөргөөр нөлөөлж байна. Экспортын зарим бүтээгдэхүүний хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн боловч үнийн бууралтаас шалтгаалан нийт экспорт 2019 онд өмнөх оны түвшнээс бага зэргийн өсөлттэй байна.

График № 3. Гадаад худалдаа, 2019-2020 оны төсөөлөл, тэрбум ам.доллар

Эх үүсвэр: Сангийн яам

.

1.2.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр гадаад бондын төлбөр болон импортын огцом өсөлтөөс шалтгаалан 198.5 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Данснуудаар авч үзвэл, урсгал данс 821.6 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 920.5 сая ам.долларын ашигтай гарлаа.

График № 4. Төлбөрийн тэнцэл, эхний хагас жилийн байдлаар, сая ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк

Эдийн засгийн идэвхжил сэргэсэн болон Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт хийгдэж байгаатай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт 2018 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 49 хувиар өсөж 1,067.5 сая ам.долларт хүрснээр санхүүгийн данс ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлэв[1].

Барааны худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа хэдий ч импортын өсөлт нь төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, валютын ханшинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна

[1] *ОТ төслийн хүрээнд 603.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.*

График № 5. Төлбөрийн тэнцэл, 2019-2021 оны төсөөлөл, сая ам.доллар



Эх үүсвэр: Сангийн яам

Дунд хугацаанд хөрөнгө, санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад үнэт цаас, Олон Улсын Валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг зэрэг байна.

- Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд 2019 онд 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байна.
- Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЖАЙКА зэрэг байгууллагуудаас төсвийн дэмжлэгт зориулсан санхүүжилт орж ирэхээр байна.

1.2.4. Валютын ханш

Дэлхийн томоохон төв банкууд бодлогын өөрчлөлт хийж байгаа, худалдааны хориг, тарифын асуудлуудаас үүдэлтэйгээр голлох орнуудын үйлдвэрлэл, экспорт буурахаар байгаа зэрэг нь шилжилтийн эдийн засагтай орнуудын валютын ханшинд дарамт учруулж болзошгүй байна.

2018 он гарснаар шилжилтийн эдийн засагтай орнуудын ам.доллартай харьцах ханш ихээхэн суларч байна.

График № 6. Хөгжиж буй орнуудын ханшийн хөдөлгөөн



Эх үүсвэр: Блүүмбэрг

1.2.5. Инфляц

Улсын хэмжээнд инфляцын түвшин 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.1 хувь байсан бол эдийн засгийн өсөлтийн дүнд эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэж, 2017 онд 6.4 хувьд хүрч, 2018 оны 8 дугаар сард 6 хувь болсон байна. Мөн мах болон хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь нийлүүлэлтийн талаас инфляц өсөх шалтгаан болов.

Шигтгээ 2: 2019 онд газрын тосны үнэ өсөх магадлалтай байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп 2018 оны 8-р сарын 6-ны өдөр "АНУ-ын Засгийн газраас Иран улсын цөмийн хөтөлбөрийн эсрэг авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээний тухай" зарлигт гарын үсэг зурж баталгаажуулснаар Иран улсын эсрэг хориг арга хэмжээнүүд хэрэгжиж эхлээд байна. Уг хоригийн хоёрдугаар үе шатны хүрээнд 2018 оны 11-р сарын 4-ний өдрөөс эхлэн Иран улсаас газрын тос худалдан авахыг хориглох юм.

Иран улс гадаад худалдаагаа хумигдахаас сэргийлэн газрын тосны гол худалдан авагч болох БНХАУ, БНЭУ болон Европын Холбооны орнуудтай худалдааны харилцааг хэвийн үргэлжлүүлэх талаар уулзалт, хэлэлцээг хийж байгаа ч олон улсын зах зээл дээр газрын тосны үнийн огцом өсөлт, савалгаа үүсэх магадлалтай гэж шинжээчид үзэж байна.

График № 7. Инфляцын түвшин /өмнөх оны мөн үеэс/



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Дунд хугацаанд төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатай авч хэрэгжүүлнэ. Инфляцын түвшин 2019-2020 онд 8 орчим хувьд байхаар байна.

Цаашид хүн амын худалдан авах чадвар нэмэгдэж, эрэлтийн гаралтай инфляц өсөх, газрын тосны үнэ нэмэгдэж болзошгүй тул нийлүүлэлтийн гаралтай инфляц өсөх дарамт байна. Иймд хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бизнесийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ 3: Турк улс дахь эдийн засгийн хямрал-2018 он

АНУ-ын иргэн, шашны номлогч Эндрью Брансоныг баривчилсан явдлыг эсэргүүцэн АНУ-ын зүгээс Турк улсад эдийн засгийн хориг тавьж, 2018 оны 8 дугаар сарын 10-нд Туркийн ган, хөнгөн цагааны импортын татварыг хоёр дахин нэмэгдүүлсэн. Үүний хариуд Туркийн засгийн газар АНУ-ын автомашин, тамхи, согтууруулах ундаа, нүүрс, цагаан будаа, косметикийн бараа бүтээгдэхүүнд импортын өндөр татвар оногдуулсан. Тухайлбал Америк автомашин 120 хувийн, согтууруулах ундаа 140 хувийн, тамхи 60 хувийн импортын татвар төлөхөөр болжээ. Гэвч Туркийн мөнгөн тэмдэгт лирийн ханш огцом унасантай холбогдуулан бодлогын хүүгээ 24 хувь болгож өсгөөд байгаа хэдий ч тус улсын лирийн ханш 2018 он гарсаар 61 хувиар суларч, засгийн газрын бондын үнэлгээ буураад байна.

1.2.6. Зээлийн хүү бууруулах стратеги

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 70 дугаар тогтоолд заасны дагуу “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” баримт бичгийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан.

Зээлийн хүү өндөр байхад инфляц, түүнийг дагасан бодлогын хүүгийн өндөр түвшин, банкуудын эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт, мөнгөний нийлүүлэлтийн тогтвортой бус байдал, хөрөнгийн зах зээлийн сул хөгжил зэрэг хүчин зүйл голлон нөлөөлж байна. Иймд, Зээлийн хүүг бууруулах стратегид үндсэн 11 бодлогын зорилтыг дараах бүлэгт хуваан, баталсан:

1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх;
2. Мөнгөний бодлогын хүүгийн шилжих нөлөөг сайжруулах;
3. Монголбанк нь арилжааны банкуудын эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах.

Энэхүү стратегийн баримт бичгийг амжилттай хэрэгжүүлснээр 2023 оны төгсгөлд банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү одоогийн түвшнээс 5-7 нэгж хувиар буурах буюу манай улстай ижил орлогын түвшинтэй орнуудын түвшинд хүрэхээр тооцож байна.

Төсвийн алдагдлыг бууруулах, өрийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга батыг сайжруулахаар хэрэгжүүлж буй бодлого нь макро эдийн засгийн орчин сайжрахад нөлөөлж байгаа бөгөөд үүний үр дүнд хадгаламжийн болон зээлийн хүү аажмаар буурч байна. Тухайлбал, 2018 оны 7 дугаар сарын байдлаар банкуудын төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурсан бол төгрөгийн хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар буурсан байна.

2. 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН БОДЛОГО

*2019 онд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн **“Цахим, ил тод, үр ашигтай”** төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.*

Энэхүү бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

-Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чанд баримтлан төсвийн алдагдлыг бууруулж, өрийн дарамтыг багасгах,

-Экспортод гарч буй эрдэс баялаг, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг цогцоор шийдвэрлэж төсвийн орлогыг нэмэгдүүлэх,

-Бизнесийн орчныг дэмжсэн татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэх,

-Төсвийн зарлагын реформыг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх,

-Нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах,

-Гадаадын хөнгөлөлттэй зээлийг эдийн засаг, нийгмийн үр ашигтай, өгөөжтэй төсөлд зарцуулах зэрэг болно.

2.1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Гаалийн шинэчлэл

Экспортын эрдэс баялаг, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг цогцоор нь шийдвэрлэх замаар төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлж татварыг бүрэн хураах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах гаалийн шинэчлэлийг 2019 оноос хэрэгжүүлж эхэлнэ.

Эрдэс бүтээгдэхүүнийг хилийн боомт дээр шинжлэх лаборатори хангалттай

байхгүйгээс улсын хилээр хууль бусаар ашигт малтмал тээвэрлэх, ашигт малтмалын дагалдах бүтээгдэхүүнээс татварын орлогыг дутуу тооцож ногдуулах, экспортын эрдэс бүтээгдэхүүний агууламж, чанарыг зөрүүтэй тодорхойлох, хилийн боомтоор гаалийн мэдүүлэггүй нүүрс тээвэрлэх, хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ зөрүүтэй байх зэрэг зөрчлүүд өмнөх жилүүдэд гарч байсныг Засгийн газрын Ажлын хэсэг тогтоон хууль хяналтын байгууллага шалгаж байна.

Түүнчлэн, импортоор орж буй газрын тосны бүтээгдэхүүний чанарт нарийвчилсан шинжилгээ хийх лабораторийн хүрэлцээ, хүчин чадал хангалтгүй байдгийн улмаас чанар, стандартын шаардлага хангахгүй түлш, шатахуун зах зээлд нийлүүлэгдэн хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байна.

*Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлснээр **Монгол Улс байгалийн баялгаасаа татвараа бүрэн авдаг** болно.*

Иймд 2019 оноос гаалийн шинэчлэлийн дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бүтээгдэхүүний сорьцын шинжилгээг хилээр орох, гарах тухай бүр хийж экспорт, импортоос олох орлогоо бүрэн хураадаг болно. Үүний тулд хилийн боомтууд дээр эрдэс бүтээгдэхүүн, газрын тос, автобензин, дизель түлшний төрөлжсөн, орчин үеийн лабораториудыг 2019 оноос үе шаттай байгуулан, лабораторийн техник тоног төхөөрөмж, хүчин чадлыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

Гаалийн лабораторийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шинжилгээний хариуг гаалийн бүрдүүлэлтэд цахимаар

ашиглах, сорьцын шинжилгээ авах ажиллагааг хүний хүчин зүйлсээс хамаарал багатай болгоно. Хууль бус бараа, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхээс сэргийлэх орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген тоног төхөөрөмж, металл илрүүлэгч, хар тамхи илрүүлэх үнэрч нохой болон гаалийн хяналт шалгалтын шаардлагатай бусад тоног төхөөрөмжүүдээр хилийн боомтуудыг үе шаттайгаар хангана.

Хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэлийн “Ухаалаг гарц” цахим системийг нэвтрүүлнэ.

Гаалийн ерөнхий газрын дэргэд Шуурхай хяналт, удирдлагын төв байгуулж, гаалийн хяналтын нэгж, цэг бүрийг олон улсын жишигт нийцсэн автомат теле хяналтын системд хамруулан улсын хилээр хууль бусаар бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх, татвараас зайлсхийх явдлаас сэргийлнэ.



Цахим төлбөрийн баримтын системд тулгуурлан импортын барааг эцсийн хэрэглэгч хүртэл, экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс экспортод гарах хүртэлх бүртгэлийг олон улсын стандарт кодчлолыг ашиглан хэрэгжүүлнэ.

Татварын шинэчлэл

Бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийг дэмжих, зээлийн хүүг бууруулах, татварын суурийг өргөтгөх, татварын тэгш, шударга байдлыг бүрдүүлэх татварын шинэчлэлийн цогц бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Иймд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн бариад буй Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг 2019 оноос хэрэгжиж эхлэхээр тооцлоо.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор татварын хялбаршуулсан горимыг нэвтрүүлж, татварын үйлчилгээг улам бүр цахимжуулж, татварын тайлангийн тоог цөөрүүлж, 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлого бүхий аж ахуйн нэгжүүдийн төлсөн татварын 90 хувийг буцаан олгоно.

Алдагдал шилжүүлэх хугацааг салбар харгалзахгүй 5 жил болгох, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээдийн барилга байгууламжийн элэгдэл байгуулах хугацааг 40-өөс 25 жил болгон бууруулах, татварын зорилгоор орлого, зарлага хүлээн зөвшөөрөх зарчмыг тодорхой болгох, Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварыг давхардуулан ногдуулахгүй байх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Зээлийн хүүг бууруулах зорилтын хүрээнд арилжааны банкны татан төвлөрүүлсэн зээлийн хүүгийн болон хувьцааны ногдол ашгийн орлогод ногдох суутган татварыг бууруулна.

Агаарын бохирдлыг бууруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд анх удаа орон сууц авсан иргэдэд үзүүлэх татварын хөнгөлөлтийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.

Хөрөнгийн зах зээлийг дэмжих татварын бодлогыг хэрэгжүүлж, нээлттэй арилжаалах хувьцаа, хувь оролцооны ногдол ашиг, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод ногдох суутган татварын хувь хэмжээг бууруулна.

Татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын стандарт, дүрмүүдийг дотоодын татварын хуульд шинээр тусгах замаар татварын суурийг өргөжүүлнэ.

Татварын ил тод байдлыг хангаж, дэлхийн 150 гаруй улс орнуудтай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Татварыг бүрэн хураах зорилгоор төрийн бусад байгууллагууд, банк санхүүгийн

байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцоно.

Татвар төлөгчдийг дэмжиж тайлангаа засварлах боломж олгож, татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлнэ.

Орон нутгийн орлогын шинэчлэл

Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөвт төвлөрч байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр, түүхий нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн орлогоос тухайн орон нутагт нь тодорхой хувийг нь нэмж хуваарилна. Ингэснээр орон нутаг өөрөө бие даан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах боломжийг бий болгоно. Үүнд:

1.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөр улсын төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд;

2.Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30 хувийг тухайн орон нутгийн төсөвт;

3.Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн төсөвт тус тус нэмж хуваарилна.

2.2. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төсвийн урсгал зарлагын реформыг хэрэгжүүлж төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

Зарлагын оновчтой, үр ашигтай хуваарилалт:

Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутагт хариуцуулна. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүүхэд хамгаалал болон газрын харилцаа гэсэн чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн засаг дарга нар байдаг бөгөөд орон нутгийн засаг захиргаа эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс шилжүүлэн авч захиран зарцуулдаг.

Сургууль, цэцэрлэг, сумын эмнэлгийн барилга байгууламж нь тухайн аймаг, нийслэл, орон нутгийн өмч байдаг боловч улсын хэмжээний нийт цэцэрлэг, сургууль, сум, тосгоны эмнэлгийн ашиглалтын зардлыг төвлөрсөн байдлаар БСШУСЯ болон ЭМЯ-ны төсөвт тусган төлөвлөж байгаа нь оновчгүй, үр ашиг, үр дүн муутай байна.

Энэ нь орон нутгийн засаг захиргааны зүгээс өөрийн өмч хөрөнгөө зөв зохистой, үр ашигтай удирдах, ашиглах, хамгаалах боломж, бүтээлч санаачилгыг төрүүлэхгүй байх, дээрээс хуваарилсан төсвийг хэмнэх хүсэлгүй байгаа нь үр ашиггүй хөрөнгө оруулалт, урсгал болон их засварын зардлыг сүүлийн жилүүдэд эрс нэмэгдүүлж байна.

Иймээс орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллага, газар зохион байгуулалтын албаны байр ашиглалтын зардал */халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түрээс, урсгал засвар үйлчилгээг/*-ыг орон нутагт хариуцуулан шаардагдах зардлыг тухайн орон нутгийн суурь зардалд шилжүүлнэ.

Нөгөөтээгүүр, өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор сумын санхүүгийн албанаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн нягтлан бодогч нарыг тухайн байгууллагад нь шилжүүлэн ажиллуулах зохицуулалт хийнэ. Ийнхүү орон нутгийн засаг захиргаа өмчөө бүрэн хариуцдаг тогтолцоонд шилжсэнээр барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт сайжрах, өр авлага үүсгэхгүй байх ач холбогдолтой. Харин байр ашиглалтаас бусад үйл ажиллагааны зардал болох цалин хөлс, хичээл үйлдвэрлэлийн

дадлага гэх мэт бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Төсвийн тэгш бус хуваарилалтыг арилгаж, ил тод болгоно. Төрийн байгууллагуудын хэрэгцээ шаардлага, онцлогт нийцсэн төсвийг оновчтой тооцон хуваарилдаг тэгш шударга, ил тод механизмыг нэвтрүүлж, ижил хүчин чадал, нөхцөл бүхий төсвийн байгууллага, цаашлаад аймаг, сум, дүүрэгт харилцан адилгүй төсөв хуваарилдаг байдлыг арилгана. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төсвийн суурь зардал, тусгай зориулалтын шилжүүлгүүдийн бүтцэд өөрчлөлт хийж холбогдох норм, нормативыг төсвийн байгууллагуудын хэрэгцээ шаардлага, онцлогт нь нийцүүлж оновчтой хуваарилдаг аргачлал нэвтрүүлнэ. Үүний үр дүнд төсвийн үр ашиггүй зарцуулалт арилж улмаар зардлын ачаалал буурна.

Тухайн төсвийн байгууллага, ялангуяа сургууль, цэцэрлэг бүрд хуваарилагдсан төсөв, орон тоог улсын хэмжээнд байгууллага бүрээр харьцуулсан цахим мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг ил тод авах боломжийг иргэдэд олгоно.

Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын болон нийтийн биеийн тамирын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, санхүүжилтээ тусгай зориулалтын шилжүүлгээр авдаг. Ихэнх улс оронд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээс бусад соёл, спортын чиг үүргийг орон нутгийн засаг захиргаа бүрэн бие даан хэрэгжүүлж байна. Иймд орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал (тогтмол болон хувьсах)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн суурь зарлагад нэмж тусгана.

Урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг төсвийн нөөц хөрөнгөөр санхүүжүүлэхгүй. Баяр наадам тэмдэглэх, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэт урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэг байсныг өөрчлөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. Харин Засаг даргын нөөц хөрөнгийг зайлшгүй шаардлагатай, урьдчилан төлөвлөх боломжгүй арга хэмжээнд зарцуулдаг болно.

Түүнчлэн гэнэтийн гамшиг ослын хохирлыг арилгах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нөөц зардлыг онцгой байдлын байгууллагын төсөвт тусган төлөвлөж санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгоно. Ингэснээр гамшгийн үед шуурхай шийдвэр гаргаж, хохирлыг арилгах арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Орлоготой нь уялдсан зардлын төлөвлөлт:

Хүрээлэн буй орчны бохирдлыг арилгах, цөлжилттэй тэмцэх зэрэг байгаль орчныг хамгаалах чиг үүргийг бие даан шийдвэрлэх боломжийг орон нутагт олгоно. Агаарын бохирдлын төлбөрийн орлого болон газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос орон нутгийн төсөв үлдэх хэсгийг тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, ойжуулах, усжуулах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээхэд зарцуулах ба цаашид агаар, орчны бохирдлыг бууруулах чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх боломжийг орон нутагт олгоно.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгахад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоо бүрэн зарцуулах эрхийг тухайн орон нутгийн хот тохижуулах газарт олгоно. Орон нутгийн ИТХ-аас хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоож, хог хаягдлыг устгах, цэвэрлэх үйл ажиллагааны зардлыг хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоороо санхүүжүүлдэг болгоно.

Ингэхдээ Хот тохижилтын газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулж орон тоо, техник хэрэгслийн хэрэгцээ шаардлагаа тооцож, менежментээ өөрсдөө хариуцдаг тогтолцоонд шилжинэ. Харин нийтийн эзэмшлийн гудамж талбайг

цэвэрлэх, цэцэрлэгжүүлэх зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

Авто замын санд төвлөрөх орлогыг авто замын засвар, арчлалтын ажилд бүрэн зарцуулна. Бусад улс орнуудад авто замын засвар арчлалтын зардлыг автозамын төлбөр, хураамжийн орлогоор нь санхүүжүүлдэг нийтлэг жишигтэй байдаг. Харин манай улсын хувьд улсын төсвөөс санхүүжүүлж ирсэн нь авто замын арчлалт засвар үйлчилгээний ажлын чанар, үр дүн, гүйцэтгэл хангалтгүй байх гол шалтгаан болж байна.

Иймд улсын болон орон нутгийн шинжтэй авто замын засвар арчлалтын хөрөнгө оруулалт, урсгал зардлыг авто замын сангийн өөрийн орлого болох авто зам ашигласны төлбөр, хураамжийн орлогоор санхүүжүүлдэг болно.

Гадаад ажилчдын төлбөрөөс орох орлогыг МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгоход зарцуулна. Ажил олгогч, бизнес эрхлэгчдийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх нь хөдөлмөрийн зах зээлийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Иймд хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байгаа суралцагчид сар бүр 100 мянган төгрөгийн тэтгэлэг олгоно. Шаардагдах зардлыг гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийн орлогоос санхүүжүүлнэ.

Үр ашигтай удирдлагын менежмент:

Халамжийн санг нэгдсэн удирдлагаар хангаж, үйлчилгээг цаг хугацаанд нь шуурхай хүргэнэ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд жилд зарцуулж байгаа нийт хөрөнгийн 42 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Халамжийн сангийн зардал нь орон нутгийн нийт зардалд хамгийн өндөр дүнг эзэлж улмаар орон нутгийн төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан оны эхний хагас жилд тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг санхүүжүүлэхэд орон нутагт хүндрэл учруулж байна.

Түүнчлэн халамжийн зардалд зориулан улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэгийг бусад зориулалт, арга хэмжээнд шилжүүлэн санхүүжүүлж, төсвийн сахилга батыг алдагдуулах тохиолдлууд цөөнгүй гарч байна.

Иймд байнгын давтамжтай олгогддог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг улсын төсвөөс өрхийн мэдээллийн санг түшиглэн халамжийн нэгдсэн бодлого удирдлагаар хангана. Ингэснээр төсвийн сахилга бат, хуваарилалтын үр ашиг сайжирч, иргэдэд халамжийн үйлчилгээг цаг тухай бүр нь хүндрэл, чирэгдэлгүйгээр үзүүлнэ.

Малыг эрүүлжүүлж, хүн амыг эрүүл хүнсээр хангана. Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар хүн ардаа баталгаатай, чанартай хүнсээр хангаж, улмаар гадаад улс орнуудад хүнс экспортлогч улс болох зорилтыг хэрэгжүүлнэ.

Цахим бүртгэл, хяналт:

Төрийн албан хаагчдын орон тоо, цалин хөлсний нэгдсэн цахим систем нэвтрүүлнэ. Төрийн албан хаагчдыг бүртгэлжүүлж орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, санхүүжилтийг цахимжуулна.

Үүний үр дүнд орон тооны бүртгэл, хяналт сайжирч цалин хөлс болон төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангахтай холбоотой зардлыг оновчтой төлөвлөх, санхүүжүүлэх боломжтой болж улмаар төсвийн үр ашиггүй зарцуулалт арилна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг 2019 оноос ЭМД-ын цахим системээр бүрэн гүйцэтгэнэ. Цахим систем нэвтрүүлснээр ЭМД-ын санг оновчтой, үр ашигтай төлөвлөж санхүүжүүлэх боломжтой болохын зэрэгцээ даатгуулагчид үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

Хэрэглээний зардлын хэмнэлт:

Төсвийн байгууллагуудын цахилгаан, халаалт, цэвэр, бохир усны хэрэглээг тоолууржуулах, шаардлагагүй хэрэгцээг хязгаарлах замаар төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулдаг болно. Төвлөрсөн халаалтын системд холбогдсон 1892 төсвийн байгууллагыг үе шаттайгаар дулааны тоолуурт шилжүүлнэ. Байгууллага дулаанаа хэрэглээгээрээ төлснөөр шаардлагатай үедээ халаалт авах, хэмжээг нь бууруулах зэрэг тохируулгыг хийх боломжтой болно.

Автомашин болон шатахууны зохистой хэрэглээг хэвшүүлнэ. Эрүүл мэнд, онцгой байдал, хил хамгаалах, цагдаа зэрэг байгууллагуудаас бусад төрийн байгууллагын албан хэрэгцээндээ ашиглаж байгаа автомашиныг зөвхөн ажлын өдрүүдэд ашиглахаар тооцон шатахууны зардлыг олгоно. Төрийн албаны автомашинд ялгах тэмдэг хэрэглэнэ. Ялгах тэмдэгтэй төрийн автомашиныг зориулалтын бусаар ашигласан бол хариуцлага тооцдог тогтолцоог бий болгоно.

Төрийн байгууллагын захиргааны бичиг хэргийн боловсруулалтыг цахимжуулна. Төрийн байгууллагуудын албан бичиг хэрэг хөтлөлт, архивыг цахимжуулах замаар бичиг хэргийн зардлыг хэмнэх бодлого баримтална.

Эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ:

Анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын нэр төрлийг нэмэгдүүлж шаардагдах эх үүсвэрийг ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ. Ингэснээр анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, даатгуулагч эрүүл мэндийн даатгалын үр шимийг суманд хүртэх боломжтой болно.

Эмнэлгийн бие даасан байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна. Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвийг санхүүгийн хувьд бие даалгаж үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн үр дүнгээр нь тооцож санхүүжүүлнэ. Үүний үр дүнд эмнэлэг менежментээ өөрсдөө бие даан хэрэгжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, зардлын үр ашиг сайжирч өрсөлдөх чадвартай болно.

Боловсролын чанарыг сайжруулна:

Багшийн үр дүнгийн урамшуллыг сурагчийн амжилттай уялдуулна. Одоо үйлчилж байгаа багшийн ажлыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтүүд болон уг шалгуурыг үндэслэн олговол зохих үр дүнгийн урамшуллын зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай байна. Иймд багшид сурагчийн амжилтаас нь хамааран үр дүнгийн урамшуулал олгох тогтолцоог бий болгож боловсролын чанарыг нэмэгдүүлнэ.

Багшийн нэмэгдлийг ажлын ачаалалтай нь уялдуулж ялгаатай тогтооно. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн нэмэгдлийг сурагчийн тоо, ажлын ачаалалттай уялдуулж ялгаатай тогтооно.

2.3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн нэн тулгамдаж байгаа дараах асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх бодлогыг баримтална.

Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “3.2.2.“Хүүхэд

бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно”, “3.2.3.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ”, “3.2.6.Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно” гэж тус тус заасан зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг 2019 онд үргэлжлүүлнэ.

Анхан шатлалын эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар, хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулна. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх” зорилт тусгагдсан. Иргэд анхан шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг хамгийн ойроос, чирэгдэлгүй, түргэн шуурхай авах эрхтэй боловч эдгээр эмнэлгүүдийн хүртээмж, хүчин чадал хангалтгүйн улмаас шатлал алгасан хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдэд ачаалал бий болгодог. Иймд анхан шатлалын эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтад баримталсан.

Гаалийн иж бүрэн бүртгэл, хяналтын тогтолцоо, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх. Монгол Улс байгалийн баялгаасаа татвараа бүрэн авах бодлогын арга хэмжээг 2019 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна. Иймд экспортын эрдэс баялаг, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг цогцоор нь шийдвэрлэх, гаалийн шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогыг төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд тодорхойлсон.

2.4. ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ЧИГЛЭЛЭЭР

Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийг нийгэм, эдийн засгийн үр ашигтай төслүүдэд зарцуулна.

Гадаадын зээл, тусламжийн хүрээнд 2019 онд нийт 1,371.5 тэрбум төгрөгийг ашиглахаар тооцсон бөгөөд үүний 21%-ийг “Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих”, 17%-ийг “Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах”, 39%-ийг “Нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх”, 15%-ийг “Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах” чиглэлээр ашиглаж бусад төслүүдэд 9%-ийг ашиглан нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэнэ.

Мөн АНУ-ын Мянганы сорилтын корпорацитай байгуулсан 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хоёр дахь компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын усан хангамжийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх ажлыг эхлүүлнэ.

Өндөр хүүтэй ЗГҮЦ гаргахгүй байх бодлогыг баримтална. Банкнуудад өндөр хүүтэй, богино хугацаатай Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалахыг зогсоож, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтэд нийцүүлэн хөгжүүлнэ.

Төсөв, санхүү, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг тууштай хэрэгжүүлнэ. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэх замаар өрийн тогтвортой

байдлыг хангаж, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцааг ирэх жилүүдэд үе шаттай бууруулна.

Өрийн зохицуулалтын арга хэмжээг авна. Засгийн газрын өндөр хүүтэй гадаад зээллэгийг зах зээлийн тохиромжтой нөхцөлд төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах боломжийг эрэлхийлэхээс гадна цаашид өрийн зохицуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд анхаарна.

Засгийн газрын өрийн баталгаа нэмж гаргахгүй. Засгийн газрын өрийн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд одоогоор баталгаа гаргасан 4 төсөл арга хэмжээ болон бусад болзошгүй өр төлбөрт тавих хяналтыг сайжруулна.

Барих-шилжүүлэх нөхцөлтэй Концессын гэрээг шинээр байгуулахгүй. Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр байгуулагддаг “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй Концессын гэрээг шинээр байгуулахгүй.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн үр нөлөө, хяналт, хариуцлагыг сайжруулж, нэгдсэн нэг бодлогоор удирдана. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газрын тусгай сангууд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийг нэгдсэн нэг бодлогоор удирдаж, зээл олголт, эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулж, хяналт хариуцлагыг тогтолцоог сайжруулах замаар үр нөлөөг нэмэгдүүлнэ. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр Засгийн газраас тусгай сангуудад эргэж төлөгдөх нөхцөлтэй олгосон хугацаа хэтэрсэн өрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, санхүүжилт нэмж олгохгүй, олгогдсон зээлийн эргэн төлөлтөөр ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Ипотекийн зээлийг орчны бохирдлыг бууруулахад чиглүүлнэ. Засгийн газраас санхүүжүүлэх ипотекийн хөнгөлөлттэй зээлийг агаар орчны бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулж байгаа өрхөд буюу (i) гэр хорооллоос газар чөлөөлж, орон сууцанд нүүн орж байгаа, (ii) анх удаа өрх тусгаарлан орон сууц худалдан авч байгаа, (iii) ногоон амины орон сууцны зээл авч байгаа өрхүүд буюу зорилтод бүлэгт чиглүүлж олгоно.

3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгохын зэрэгцээ төсвийн сахилга батыг чанд мөрдүүлэн, үр ашгийг нэмэгдүүлэх замаар өрийн дарамтыг бууруулснаар төсвийн алдагдал 2017 онд ДНБ-ий 9.5 хувь, 2018 онд ДНБ-ий 8.0 хувьтай тэнцэхээр батлагдаж байсан бол 2019 онд ДНБ-ийн 5.4 хувьд хүргэж сайжруулахаар тооцлоо.

Төсвийн алдагдлыг үе шаттайгаар жил дараалан бууруулснаар алдагдлыг 2019 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнээс 1.5 пунктээр бага байлгах боломжийг бүрдүүлнэ. Төсвийн алдагдал 2019 онд ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэхээр байна.

График № 8. Нэгдсэн төсвийн алдагдал 2012-2021 оноор



Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь -1,913.3 тэрбум төгрөг байгаагаас гадаад зээлийн ашиглалтын 1,225.5 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй алдагдал юм. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу тогтворжуулалтын санд хуримтлагдах 322.0 тэрбум төгрөг, Ирээдүй өв сангийн тухай хууль болон Ирээдүй өв сангийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу 515.4 тэрбум төгрөгийг тус тус төсвийн алдагдлыг нөхөхөд ашиглахаар тусгасан.

3.2. Төсвийн тусгай шаардлага

“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу дараах 4 тусгай шаардлагыг 2019 оны төсвийн төсөл дараах байдлаар бүрэн хангаж байна:

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.

Ирэх 2019 онд нүүрс болон зэсийн баяжмалаас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын **3** хувиас давахаар байгаа тул хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг **6,222.2** ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг **75.9** ам.долларaар тооцлоо.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2019 онд тухайн жилийн ДНБ-ий 6.9 хувиас илүүгүй байх.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого **9,676.5** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **27.4** хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага **11,589.8** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **32.8** хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -**1,913.3** тэрбум төгрөг буюу ДНБ-ий -**5.4** хувь болохоор байна.

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь ДНБ-ий 75.0 хувиас хэтрэхгүй байх

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь **55.3** хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх

2019 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт **17.0** хувьтай, 2007-2018 оны эрдэс баялгийн бус ДНБ- өсөлтийн дундаж **20.5** хувьтай тус тус тэнцэж байна. 2019 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **11,589.8** тэрбум төгрөгөөр тооцож, нийт зарлагын өсөлт **20.1** хувь буюу тусгай шаардлагыг хангаж байна.

4. ТӨСВИЙН ОРЛОГО

4.1. Нэгдсэн төсвийн нийт орлого

Ирэх 2019 онд гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлэн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрэн дайчилснаар нэгдсэн төсвийн нийт орлогыг энэ оны батлагдсан нийт дүнгээс даруй 3,204.1 тэрбум төгрөг буюу 40.7 хувиар нэмэгдүүлэн 11,067.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Ирэх онд 322.0 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, 1,068.5 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлнэ.

График № 9. Нийт орлого ба тусламжийн дүн



Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 9,676.5 тэрбум төгрөг байхаар тооцсон. Үүний 88.7 хувь буюу 8,585.8 тэрбум төгрөгийг татварын орлого, 11.3 хувь буюу 1,090.7 тэрбум төгрөг татварын бус орлого байна.

Хүснэгт № 3. Нэгдсэн төсвийн нийт орлого

Үзүүлэлт	Тэрбум төгрөг
Нийт орлого ба тусламжийн дүн	**11,067**
Тогтворжуулалтын сан	322
Ирээдүйн өв сан	1,069
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	**9,676**
1.Татварын орлого	**8,586**
1.1.Орлогын албан тавар	2,016
1.2.Нийгмийн даатгалын орлого	1,697
1.3.Хөрөнгийн албан татвар	138
1.4.Нэмэгдсэн өртгийн албан тавар	2,321
1.5.Онцгой албан тавар	838
1.6.Тусгай зориулалтын орлого	12
1.7.Гадаад үйл ажиллагааны орлого	743
1.8.Бусад татвар	820
2.Татварын бус орлого	**1,091**
2.1.Нийтлэг татварын бус орлого	944
2.2.Тусламжийн орлого	146

4.2. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу зэс, нүүрснээс 2019 оны төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэхээр байгаа тул гол нэр төрлийн эрдэс баялагт тооцлоо.

Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасны дагуу тооцоход зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 6,222.2 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 75.9 ам.доллар байна.

Ирэх онд зэсийн баяжмалаас 5.6 тэрбум төгрөг, нүүрснээс 316.4 тэрбум төгрөг, нийт 322.0 тэрбум төгрөгийн орлого Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлнэ.

4.3. Ирээдүйн өв сангийн орлого

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 300.9 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 767.6 тэрбум төгрөг, нийт 1,068.5 тэрбум төгрөгийн орлого 2019 онд тус санд төвлөрүүлнэ.

Уг орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу улсын төсөвт 50 тэрбум төгрөгийг шилжүүлж, Хүний хөгжил

сангийн үлдэгдэл өрийг барагдуулснаар Ирээдүйн өв санд 550 гаруй тэрбум төгрөг хуримтлагдана.

4.4. Уул уурхайн салбарын орлого

Ирэх онд уул уурхайн салбарын орлого 2018 оны батлагдсан дүнгээс 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж нийт 3.0 их наяд төгрөгт хүрэхээр тооцлоо. Энэ нь төсвийн нийт орлогын 27.1 хувийг бүрдүүлэхээр байна.

График № 10. Уул уурхайн салбарын орлого



Хүснэгт № 4. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө

Бүтээгдэ-хүүн	АМНАТ	ААНОАТ	Ногдол ашиг	Бусад	Нийт
Зэс	587	292	150	275	1,304
Нүүрс	577	361	180	193	1,311
Алт	46	19	-	18	83
Бусад	55	57	1	189	302
Уул уурхайн салбарын орлого	**1,265**	**729**	**331**	**675**	**3,000**

Ерөнхий сайдын 2018 оны 4 дүгээр сард БНХАУ-д хийсэн айлчлалын үр дүнд нүүрсний экспортын хэмжээ эрс нэмэгдсэн бөгөөд энэхүү хандлага 2019 онд хэвээр хадгалагдахаар байна. Улмаар гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолж, 1,310.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

Зэсийн зах зээлийн үнийг олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудын төсөөлөлд үндэслэн тонн тутамд 6,272.2 ам.доллар, экспортын хэмжээг зах зээлийн хандлага, аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн 1.4 сая тонн байхаар тооцож, 2019 онд 1,304.4 тэрбум төгрөгийн орлого зэсийн баяжмалаас төсөвт төвлөрүүлнэ.

Эдийн засгийн таатай нөхцөл байдал, эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд 2018 онд уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагааны түвшин нэмэгдэж энэ оны жилийн эцсийн хуримтлагдсан ашгаас 2019 онд төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжүүд 330.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

4.5. Эдийн засаг дахь татварын ачаалал

Татварын орлого ба дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаагаар эдийн засаг дахь татварын ачааллыг тооцоход ирэх онд 23.6 хувь байхаар байна.

График № 11. Эдийн засаг дахь татварын ачаалал



Дэлхийн 166 орны харьцуулсан судалгаанаас үзэхэд татварын ачаалал дунджаар 25 орчим хувьтай байгаа ба үүнтэй харьцуулбал манай улс татварын ачаалал багатайд тооцогдож байна. Татварын ачааллыг эдгээр 166 улсаар нэг хүнд ногдох ДНБ-ээр харьцуулбал дараах байдалтай байна.

График № 12. Нэг хүнд ногдох ДНБ ба эдийн засаг дахь татварын ачаалал, улсаар



Мөн Дэлхийн банкнаас улс орнуудын бизнес эрхлэх орчныг харьцуулан гаргасан "Doing Business 2018" судалгаагаар Монгол Улс дэлхийн 31 дэх бага татварын хувь хэмжээтэй улсаар нэрлэгджээ.

4.6. Татварын орлого

Манай улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 88.7 хувь буюу 8,585.8 тэрбум төгрөгийг 2019 онд татварын орлогоор бүрдүүлнэ. Үүний 23.5 хувийг орлогын албан татвар, 19.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 27.0 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.8 хувийг онцгой албан татвар, үлдсэн 19.9 хувийг бусад татвар эзэлж байна.

4.6.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн таамаглал, биет хэмжээний төсөөлөл, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин зэрэгт үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 2019 онд 1,480.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Үүнээс 1,242.0 тэрбум төгрөгийг тэнцвэржүүлсэн орлогоор улсын төсөвт төвлөрүүлнэ.

Засгийн газраас хөрөнгө оруулалтыг дэмжих, зээлийн хүүг бууруулах бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр бизнесийн орчин мэдэгдэхүйц сайжирч байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гүйцэтгэлээс харагдаж байна.

График № 13. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого болон өсөлт /уул уурхай, уул уурхайн бус салбараар/



Тухайлбал, 2018 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт 6.3 хувьд хүрч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 50 орчим хувиар өссөн[2], мөн төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 1.4 пунктээр буурч энэ оны 7 сарын байдлаар 18.3 хувьд хүрсэн [3] зэрэг нь аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа нэмэгдэхэд нөлөөлжээ. Улмаар 2018 оны эхний 8 сарын байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого өмнөх оны мөн үеэс 43.4 хувиар өссөн байна.

График № 14. Төгрөгийн болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүү, хувь



Аж ахуйн нэгжийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын бодит өсөлт бусад салбартай харьцуулахад бага байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогод уул уурхайгаас бусад салбарын үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байгааг илтгэж байна.

[2] Монголбанкны төлбөрийн тэнцлийн статистик

[3] Монголбанкны хадгаламж, зээлийн статистик

График № 15 . Эдийн засгийн бодит өсөлт, салбараар



4.6.2. Хувь хүний орлогын албан татвар

Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл болон эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан хувь хүний орлогын албан татварын орлогыг 2019 онд 822.5 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Энэ нь 2018 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 7.8 хувиар нэмэгдсэн дүн юм.

График № 16. Хувь хүний орлогын албан татвар, тэрбум төгрөг



Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сайжруулах бодлогын улмаас өрхийн дундаж орлого энэ оны 2 дугаар улирлын байдлаар 1,042.2 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар өссөн байна[4].

4.6.3. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвар

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, өмнөх жилүүдийн гүйцэтгэл, цахим төлбөрийн баримтын хамрагдалтын түвшин зэргийг харгалзан 2019 онд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны батлагдсан түвшнээс 67.7 хувиар өсөж 1,040.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн үр дүнд далд эдийн засаг буурч, татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс сайжирч нэмэгдсэн өртгийн албан татварын орлого сүүлийн 2 жилд дунджаар 25 хувь өсөж байна. Улмаар 2018 оны 8 сарын гүйцэтгэл нь 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй ойролцоо түвшинд ирээд байна.

График № 17. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого

Тодруулбал, системд бүртгэгдсэн цахим төлбөрийн баримтын тоо 2018 оны 8 сарын байдлаар 252.7 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.5 дахин өсжээ. Цахим төлбөрийн баримтаар бүртгэгдсэн нийт гүйлгээний хэмжээ 2018 оны 8 сарын байдлаар 3.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс мөн адил 1.5 дахин нэмэгдсэн байна. Улмаар 2018 оны 8 сарын байдлаар 10.1 тэрбум төгрөгийн урамшууллыг буцаан олгожээ.

Ирэх оноос татварын цахим бүртгэл, үйлчилгээг улам бүр боловсронгуй болгоно. Тухайлбал, цахим төлбөрийн баримтын системийг төрийн байгууллагын бүртгэлийн системүүдтэй холбож үйлчилгээг хялбарчлах, татвар төлөгчдөд хялбаршуулсан тайланг боловсруулж өгөх, бэлэн бус төлбөрийн баримтыг е-баримттай нэгтгэх, импортоор орж буй барааг эцсийн хэрэглэгч хүртэл, экспортоор гарч буй барааг үйлдвэрлэгчээс экспортоор гарах хүртэл тус тус олон улсын стандарт кодчлолыг ашиглан бүртгэх системийг хөгжүүлж хэрэгжүүлнэ.

[4] Үндэсний Статистикийн Хороо

4.6.4. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар

Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийг эрчимжүүлэх бодлогын үр дүнд ирэх онд нийт хэрэглээ, тэр дундаа уул уурхай, бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаа улам бүр идэвхжиж, автобензин, дизелийн түлшний импорт өсөхөөр байна. Хэрэглээний өсөлттэй уялдуулан 2019 онд 210.3 тэрбум төгрөгийн автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого төвлөрүүлнэ.

Ирэх онд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь хэмжээг одоогийн түвшнээс бууруулахгүй.

4.6.5. Тамхи, согтууруулах ундааны онцгой албан татвар

Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нөлөөлөл, хэрэглээний түвшин, өмнөх онуудын орлогын гүйцэтгэл зэргийг үндэслэн ирэх онд тамхи, согтууруулах ундаанаас нийт 394.5 тэрбум төгрөгийн онцгой албан татварын орлогыг төсөвт төвлөрүүлнэ. Энэ нь 2018 оны төлөвлөсөн хэмжээнээс 34.8 хувь буюу 101.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж буй үзүүлэлт юм.

Улсын Их Хурлаас баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу ирэх онд тамхи, согтууруулах ундааны онцгой албан татвар 5 хувиар нэмэгдэнэ.

4.6.6. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан ирэх онд гаалийн албан татварын орлогоор 743.0 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 1,539.0 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлнэ. Энэ нь тус хоёр орлогын 2018 оны батлагдсан дүнгээс нийт 39.8 хувь буюу 650.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм.

График № 18. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг

Засгийн газраас үйлдвэрлэгчдийг дэмжих, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, эрдэс бүтээгдэхүүний олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт эрчимжиж, хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээгдэхүүний импорт өсөж байна.

Тухайлбал, 2018 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад машин, механизмын импорт 44.5 хувь, нефтийн бүтээгдэхүүн 29.7 хувиар тус тус өссөн байна. Цаашид энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байгаа нь улсын хилээр нэвтэрч буй импортын бараа, бүтээгдэхүүнээс төвлөрүүлэх татварыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Хүснэгт № 5. Импортын голлох бүтээгдэхүүнүүд

Барааны нэр	Импорт /сая ам.доллар/		
	2017.08	2018.08	Өөрчлөлт
Машин, механизм	962.6	1,390.5	427.9
Түлш, шатахуун	658.2	853.8	195.6
Хүнсний бүтээгдэхүүн	234.7	279.0	44.3
Бусад	898.8	1,278.7	380.0
Нийт	**2,754.2**	**3,802.0**	**1,047.8**

Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистик мэдээлэл

4.6.7. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглал, уул уурхайн

салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдийн 2019 оны олборлолтын төлөвлөгөө, өмнөх онуудын гүйцэтгэл зэрэгт үндэслэн тооцоход ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 2019 онд энэ оны батлагдсан төлөвлөгөөнөөс 57 хувь буюу 458.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1,265.0 тэрбум төгрөгт хүрнэ.

Үүний 46.4 хувь буюу 587.1 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалаас, 45.6 хувь буюу 576.7 тэрбум төгрөгийг нүүрснээс, 3.6 хувь буюу 45.6 тэрбум төгрөгийг алтнаас төвлөрөх орлого эзэлж байна.

Ирэх онд нүүрсний экспорт 42.0 сая тонн, зэсийн баяжмалын экспорт 1.4 сая тонн, Монголбанканд тушаах алтны хэмжээ 21.0 тонн байхаар тооцлоо.

График № 19. Зэсийн баяжмалын экспорт

Алтны олборлолт, тушаалтыг тогтвортой байлгах, валютын нөөцийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Алт-2” хөтөлбөрийн үр дүнд ирэх онд 21 тонн алт Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаахаар тооцлоо.

4.6.8. Агаарын бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын төлбөрийн орлогын 95 орчим хувийг бүрдүүлж байгаа олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөрөөр 42.0 тэрбум төгрөг, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийнд ногдуулах төлбөрөөр 2.0 тэрбум төгрөг, нийт 44.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Энэ нь 2018 оны батлагдсан түвшнээс 47 хувь буюу 14.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, ойжуулах бодлогыг дэмжих, энэ чиглэлээр орон нутгийн төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оноос олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь буюу 21.0 тэрбум төгрөгийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн төсөвт шинээр хуваарилна.

4.6.9. Газрын төлбөрийн орлого

Газрын төлбөрийн орлогыг орон нутгийн газрын эзэмшил, өмчлөлийн мэдээлэл, газрын төлбөр тооцох тухай шинэчлэн батлагдсан Засгийн газрын 182 дугаар тогтоолд үндэслэн ирэх онд газрын төлбөрийн орлогоор энэ оны батлагдсан дүнг 30.9 хувь буюу 17.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 75.8 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

Өнгөрсөн оны байдлаар газрын нэгдмэл санд бүртгэлтэй газрын нийт хэмжээ 156.4 сая га байсан бөгөөд иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөлд байгаа газрын хэмжээ 1.6 сая га газар буюу нийт газар нутгийн 1.0 хувьд хүрсэн байна.

4.6.10. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр

Монгол Улсын хэмжээнд 9.7 сая га талбайд ашигт малтмалын хайгуулын 1,585, ашиглалтын 1,655 нийт 3,240 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Цаашид уул уурхайн салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж тооцож Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тусгай зөвшөөрлийн төлбөрөөр 2019 онд 42.9 тэрбум төгрөг төвлөрүүлнэ. Энэ нь 2018 оны батлагдсан дүнгээс 15.9 хувиар буюу 5.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм.

4.6.11. Хог хаягдлын үйлчилгээний хураамж

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг тухайн орон нутгийн өрхийн тоо, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон

төлбөрийн хэмжээ зэрэгт үндэслэн ирэх онд 19.8 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

Ирэх онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тухайн орон нутгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, булшлахад шаардагдах зардалд бүрэн зарцуулах боломжийг олгож байна.

4.7. Татварын бус орлого

Ирэх онд 1,090.7 тэрбум төгрөгийн татварын бус орлого төвлөрүүлэхээр тооцлоо. Тус орлого нь газрын тос, навигацийн орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

4.7.1. Газрын тосны орлого

Монгол Улсын хэмжээнд 331.4 мянган километр квадрат талбайд 26 блок дээр 21 аж ахуйн нэгж Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудаас БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Петрочайна Дачин Тамсаг ХХК "Тосон-Уул 19", "Тамсаг 21" талбайд, Доншен газрын тос (Монгол) ХХК, "Зүүнбаян 97" талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Газрын тосны нийт экспортын 95 хувийг "Петрочайна Дачин Тамсаг" ХХК, 5 хувийг "Доншен газрын тос (Монгол)" ХХК гаргаж байна.

График № 20. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ

Ирэх онд газрын тосны нийт экспортын хэмжээг 8,150.0 мянган баррел байна гэж төсөөлж газрын тосны орлогоор 335.6 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлнэ. Энэ нь 2018 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 50.2 хувь буюу 112.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүн юм.

4.7.2. Навигацийн орлого

Ирэх онд Хөшигийн хөндий олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулж, агаарын тээврийг либералчилснаар Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх нислэгийн тоо 126,850 хүрэхээр тооцож төсөвт 2019 онд 156.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлнэ.

4.7.3. Хувьцааны ногдол ашиг

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолын 1 дүгээр хэсгийн 4.1-т "улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх" гэж заасныг тус тус үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдээс 2019 онд улсын төсөвт 9.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 300.9 тэрбум төгрөгийг ногдол ашгийг тус тус төвлөрүүлнэ.

4.8. Төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл

Монгол Улсын 2019 оны төсвийн орлогод учирч болзошгүй голлох эрсдэл нь зэс, нүүрс, алт, газрын тос зэрэг экспортын гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл байхаар байна.

АНУ болон БНХАУ импортын бараа, бүтээгдэхүүнд ногдуулах тарифаа харилцан нэмэгдүүлж байгаа "худалдааны дайн", АНУ-ын Засгийн газраас Иран Улсын цөмийн хөтөлбөрийн эсрэг авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээ, Турк Улс дахь эдийн засгийн хямрал, БНХАУ-ын Бээжин хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд гангийн үйлдвэрийн тоог багасгах бодлогын арга хэмжээ зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ 2018 оны 7 сараас эхлэн тогтворгүй байлаа. Тухайлбал, 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдөр нэг тонн цэвэр зэсийн үнэ Лондоны Металлын Бирж дээр 7,332 ам.доллар байсан бол хоёр сарын дараа буюу 9 дүгээр сарын 7-ны өдөр 5,883 ам.долларт хүрч, 20 орчим хувиар буурчээ.

Эдгээр шалтгааны улмаас дэлхийн эдийн засгийн өсөлт 2019 онд 3.7 хувь болж, өмнө төсөөлж байснаас саарахаар байна. Ийнхүү дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд саарахаар байгаа нь манай худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, улмаар экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл ирэх онд ч мөн адил үргэлжлэхээр байгааг олон улсын нэр хүнд бүхий BMI Research, Fitch Solutions, Itau Unibanco Holding SA зэрэг байгууллагын гаргасан таамаглалд дурдсан байна.

4.8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2017 онд 884.5 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 14.0 хувьтай тэнцэж байсан бол 2019 онд 1,085.1 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 12.7 хувьд хүрнэ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хамрагдах татварын хуулиудаар авч үзвэл дараах байдалтай байна:

Хүснэгт № 6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ, хувь

Үзүүлэлт	2016	2017	2018 БАТ	2019 ТӨС	2020 ТӨС
Нийт хэмжээ	**908.3**	**884.5**	**894.0**	**1,085.1**	**1,276.8**
Нийт татварын орлогод эзлэх хувь	**18.3%**	**14.0%**	**14.3%**	**12.7%**	**13.8%**
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	296.6	273.2	260.0	226.3	272.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	251.0	234.7	331.8	533.3	608.6
Гаалийн албан татвар	45.7	55.3	66.6	54.5	69.7
Хувь хүний орлогын албан татвар	121.3	125.5	125.2	176.0	220.0
Онцгой албан татвар	193.7	195.7	110.3	94.9	105.8

Нийт татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дийлэнх хувийг Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламж, газрын тос олборлох салбар, газар тариалан эрхлэгчдийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, сэргээгдэх эрчим хүч, иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, хөдөө аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж эзэлж байна.

5. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГА

5.1. Нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм

Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлыг 2019 онд 8,228.3 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт № 7. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар, их наяд төгрөг/

	2017	2018	2019
	гүйц	төл	төс
Урсгал зарлага	7.0	7.5	8.2
1. Цалин, хөлс	*1.8*	*1.8*	*2.2*
2. Бараа үйлч.бусад зардал	*1.3*	*1.5*	*1.7*
3. Зээлийн хүү	*1.2*	*1.2*	*0.9*
4. Татаас шилжүүлэг	*2.7*	*3.0*	*3.4*

Нийт урсгал зардлыг бүтцийн хувьд авч үзвэл цалин хөлс 27 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 22 хувь, зээлийн хүүгийн зардал 10 хувь, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 41 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт № 8. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/

№	Зардлын томсгосон ангилал	2017	2018	2019
		гүйц	төл	төс
Урсгал зарлага		7.0	7.5	8.2
1. Цалин хөлс		26%	24%	27%
2. БҮ-ний бусад		19%	20%	22%
3. Зээлийн хүү		16%	15%	10%
4. Татаас, шилжүүлэг		39%	41%	41%

5.2. Урсгал зардлын өөрчлөлт

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх болон иргэдийн орлогын баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээнд шаардагдах зардал нь нэгдсэн төсвийн урсгал зардлын өөрчлөлтөд голлон нөлөөлж байна.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан зарчим:

1. Цалин, тэтгэврийг инфляцын өсөлттэй уялдуулж нэмэгдүүлнэ;

2. Статистик, хүн ам зүйн өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдэх нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн зардлыг төсөвт тусгана;

3. Зөвхөн онцгой байдал, эрүүл мэнд, боловсролын салбарын шинэ хөрөнгө оруулалттай холбоотой орон тоо, урсгал зардлыг төсөвт тусгана;

4. Тээвэр шатахуун, халаалт, гэрэл цахилгаан, интернет, шуудан холбоо, бичиг хэрэг, эд хогшлын зардлыг 2018 оны түвшнээс нэмэгдүүлэхгүй;

5. Дотоод албан томилолтын тарифыг шинэчилнэ;

6. Гадаад албан томилолтын зардлыг бүх шатанд нэмэгдүүлэхгүй;

7. 2018 онд хэрэгжсэн нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулна;

8. Төсөвт өндөр ачаалал үзүүлэх үр дагавартай шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хойшлуулна

9. Өрийн дарамтыг бууруулах, зээлийн ашиглалтын үр ашгийг сайжруулах, уян хатан зохицуулалт бүхий удирдлагаар хангах зорилгоор зээл, тусламжаар хэрэгжих төслийн санхүүжилтийг Сангийн сайдын багцад нэгдсэн байдлаар тусгана;

Урсгал зардлын өөрчлөлтийг ангилж үзвэл нийт өөрчлөлтийн 61.1 хувь нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд, 5.7 хувь нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд, 1.6 хувь нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд, 6.0 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой байна.

Ирэх 2019 онд зээлийн хүүгийн зардлыг бууруулах бодлого баримтлан ажилласнаас зээлийн үйлчилгээний төлбөрийг 285.2 тэрбум төгрөгөөр буюу 25 хувиар бууруулж байна.

5.3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх. Ирэх онд цалингийн сан нийт 418.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Үүнээс 151.0 тэрбум төгрөг нь Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэрийн нөлөөлөл, үлдсэн 267.1 тэрбум төгрөг нь 2019 онд төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх эх үүсвэрт зарцуулагдана.

Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх

2019 онд нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд 119.5 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэврийг зүүн бүсийн амьжиргааны доод түвшинтэй уялдуулж харин халамжийн тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцож нийт 21.2 тэрбум төгрөгийг нэмж тусгалаа. Ингэснээр нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авч буй нийт 134.9 мянган хүний орлого сар бүр нэмэгдэх боломжтой болно.

Ирэх 2019 онд нийгмийн даатгалын сангаас 1,086.0 мянган хүн тэтгэвэр, тэтгэмж авахаар байгаа нь 2018 оноос 25.4 мянган даатгуулагчаар нэмэгдэхээр байна. Үүнээс тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тооны цэвэр өсөлт 23.1 мянгад хүрэхээр байна.

Хүснэгт № 9. Тэтгэвэр, тэтгэмжийн зардлын өсөлт /тэрбум төгрөгөөр/

Арга хэмжээ	Өөрчлөлт
Нийт өөрчлөлт	**301.0**
Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	**140.7**
Нийгмийн даатгалын сан	*119.5*
Нийгмийн халамжийн сан	*21.2*
Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тооны өсөлт	**160.3**
Нийгмийн даатгалын сан	*135.1*
Нийгмийн халамжийн сан	*25.2*

Гадаад ажилчдын төлбөрөөс орох орлогыг МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгоход зарцуулна. Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байгаа 41 мянган суралцагчид сар бүр 100 мянган төгрөг олгохоор тооцож 41.0 тэрбум төгрөгийг тусгалаа. Ингэснээр гадаадаас орж ирэх ажилчдын ажлын байранд дотоодын ажилчдыг ажиллуулах, ажилгүйдлийг бууруулах боломж бий болно.

Халамжийн санг нэгдсэн удирдлагаар хангаж, үйлчилгээг цаг хугацаанд нь шуурхай хүргэнэ.

Халамжийн зардалд зориулан улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг тухайн орон нутгийн засаг захиргаа бусад зориулалт, арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсан болон орон нутгийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалж иргэд халамжийн тэтгэвэр, тэтгэмжээ хугацаанд нь авч чадахгүй байх нөхцөл үүсэж байна.

Иймд байнгын давтамжтай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг өрхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс шууд олгохоор тооцож 266.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс шилжүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын төсөвт тусгалаа.

Ингэснээр төсвийн сахилга бат, хуваарилалтын үр ашиг сайжирч, иргэд халамжийн үйлчилгээг цаг тухай бүр нь хүндрэл, чирэгдэлгүйгээр авах боломж бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын арга хэмжээний төсвийн зарцуулалт, хуваарилалтын үр ашгийг сайжруулна. Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны төсөвт шинээр хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор нийт 6.4 тэрбум төгрөг тусгаснаас 57 хувийг (3.7 тэрбум төгрөг) байгууллагын үйл ажиллагааны зардал, эд хогшил, тавилга худалдан авахад, 15 хувийг (957.5 сая төгрөг) мэдээлэл сурталчилгаа, урлагийн наадам, тэмдэглэлт өдөр зохион байгуулахад, 8 хувийг (528.1 сая төгрөг) сургалт семинар зохион байгуулахад, 10 хувийг бусад үйл ажиллагааны зардалд, 10 хувийг хүүхэд хамгааллын ажилд тус тус зарцуулсан байна.

Харин орон нутагт хүүхэд хамгааллын шаардлагатай арга хэмжээнд хангалттай төсөв хуваарилаагүй байна.

Иймд ирэх 2019 оны төсөвт уг зардлыг хүүхдийн тоо, гэмт хэргийн гаралт зэрэг статистик үзүүлэлт болон хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээний судалгааг харгалзсаны үндсэн дээр орон нутгийн хүүхдийн байгууллагын төсөвт хүүхэд хамгааллын чиглэлээрх арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцож нийт 2.4 тэрбум төгрөгийг төсөвлөлөө. Ингэснээр төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу илүү үр дүнтэй, зарцуулах боломж бий болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмнэлгийг ашиглалтад оруулна. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 250 ортой эмнэлэг ашиглалтад орж Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэргэд 2019 оны 6 дугаар сараас эхлэн ажиллахаар тооцож 189 орон тоо, үйл ажиллагааны зардал 4.0 тэрбум төгрөгийг нэмж тусгалаа.

5.4. Агаарын бохирдлыг бууруулах

Агаар орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Ирэх онд агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд нийт 146.2 тэрбум төгрөгийн зардлыг нэмж тусгана. Энэ хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиг үүрэг, давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулна.

Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн орлого болон газрын тосны лицензийн төлбөрийн орлогын зарцуулалтыг оновчтой болгоно. Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн орлогын 50 хувь буюу 21.0 тэрбум төгрөгийг тухайн орон нутгийн агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулна.

Мөн газрын тосны лицензийн төлбөрийн 30 хувь буюу 838.9 сая төгрөгийг тухайн аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна. Ингэснээр тухайн аймаг түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн орлого болон газрын тосны лицензийн төлбөрийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах боломжтой болох юм.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг хот суурины хог зайлуулах, устгах, цэвэрлэхэд бүрэн зарцуулна. Орон нутгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн нийт орлого 4.9 тэрбум төгрөгийг тухайн аймгийн хог хаягдал зайлуулах, устгах, цэвэрлэх арга хэмжээнд бүрэн зарцуулна. Ингэснээр орон нутагт хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх бүрэн эрх шилжиж төсвийн үр ашгийг сайжруулах боломжтой болно.

5.5. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг нэмэгдүүлнэ. Өртгийн нарийвчилсан тооцоолол

хийсний үндсэн дээр эхний ээлжид Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, нийслэлийн Өргөө амаржих газар, Төв, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв гэсэн 9 эрүүл мэндийн байгууллагад ирэх 2019 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр тооцож, холбогдох төсвийг эдийн засгийн томсгосон ангилал буюу зардлын дэлгэрэнгүй ангиллын хэд хэдэн зүйлийг нэгтгэн бүлэглэсэн байдлаар төсөвлөж тухайн жилийн төсвийн хуваарийг батлах эрхийг эмнэлгийн удирдлагад олгохоор төлөвлөж байна.

Эмнэлгүүд хараат бус, хамтын удирдлага бүхий хагас бие даасан засаглалтай болсноор авсан санхүүжилтээ уян хатан зохицуулж, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний онцлогтоо тохируулан эмч, эмнэлгийн ажилтнуудын орон тоог оновчтой зохион байгуулах, цалин нэмэгдүүлэх, ажлын ачаалалтай нь уялдуулан нэмэгдэл урамшуулал олгох зэрэг асуудлыг шийдэх боломжтой болох юм.

Мөн энэ зорилгын хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвийг төсвөөс бүрэн гаргаж бие даан удирдлагаа хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийт **15.2** тэрбум төгрөгийн татаас олгоно.

“Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөр” хэрэгжүүлнэ. Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн зорилго нь хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн шүдний өвчний тархалтыг 30 хувиар, цоорлын эрчмийг 4 нэгжээр бууруулахад оршино. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2019 онд **4.7** тэрбум төгрөг төсөвлөлөө.

5.6. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх

Ирэх 2019 онд цэцэрлэгийн насны хүүхдийн тоо 20.4 мянгаар, ерөнхий боловсролын сургуульд суралцагчийн тоо 26.0 мянгаар тус тус нэмэгдэж байгаатай холбоотойгоор нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг нийт 33.6 тэрбум төгрөгөөр, харин үдийн цай хөтөлбөр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 14.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тооцлоо.

Хүснэгт № 10. Хүүхдийн тооны өсөлтөөс нэмэгдэх урсгал зардал /тэрбум төгрөгөөр/

Арга хэмжээ	Өөрч.
Хүүхдийн тооны өсөлт, Үүнээс:	**48.4**
Сургууль, цэцэрлэгийн хувьсах зардал	*33.7*
Сургууль, цэцэрлэгийн үдийн цай, хүүхдийн хоол	*14.7*

Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлнэ. Соёл, биеийн тамирын салбарын тусгай зориулалтын бүрэлдэхүүнд багтдаг орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир спортын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал 59.2 тэрбум төгрөгийг орон нутгийн суурь зарлагад шилжүүллээ. Соёл, урлаг, спортын чиг үүргийг орон нутагт шилжүүлснээр тухайн орон нутгийн онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ. Чиг үүргийг орон нутгийн төсөвт бүрэн шилжүүлж байгаатай холбогдуулан Төсвийн тухай хууль болон Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэв.

Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг салбарын ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулахад зарцуулна. Ирэх 2019 оноос соёл урлагийн салбарын байгууллагуудад орлогын төлөвлөгөө батлахгүй байхаар төсвийн төсөлд тусгалаа. Ингэснээр тухайн байгууллага олсон орлогоо ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалин

урамшуулал зэрэг бусад нэн шаардлагатай зардалд бие даан зарцуулах эрхтэй болж байна.

Шинэ хөрөнгө оруулалттай холбоотой урсгал зардлыг төсөвт тусгана. Шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн орон тоо 3308, цалин хөлс 27.6 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна. Хүүхдийн тоо өссөнтэй холбоотойгоор үдийн цай хөтөлбөр болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 14.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөлөө.

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг сайжруулна. Сурах бичгийг төрөөс бага ангийн сурагчдад 100 хувь, харин төрийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай дунд, ахлах ангийн сурагчдын 40 хувьд олгож байгаа юм. Ингэснээр үлдэж буй 60 хувь нь сурах бичгийг худалдан авах шаардлагатай болж байна. Иймд сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн номын санд сурах бичгийг түрээслүүлж, түрээсийн орлогоороо нөхөн хэвлэлт хийдэг сурах бичгийн түрээсийн тогтолцоог 2019 оноос нэвтрүүлэхээр тооцож 3.7 тэрбум төгрөг тусгалаа.

Багшийн үр дүнгийн урамшууллыг сурагчийн амжилттай уялдуулна. Багшийн хөгжлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дугаар заалт болон МАН-ын мөрийн хөтөлбөрийн 1.2.6 дугаар заалтыг тус тус үндэслэн багшид сурагчийн амжилтаас нь хамааран үр дүнгийн урамшуулал олгох тогтолцоог бий болгож боловсролын чанарыг нэмэгдүүлнэ.

5.7. Хөдөө аж ахуй, уул уурхай

Улсын мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хүн ардаа баталгаатай, чанартай хүнсээр хангах арга хэмжээний зардлыг 25.0 тэрбум төгрөгөөр төсөвлөв.

Мал сүрэг эрүүлжсэнээр малын гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаа нэмэгдэж экспорт, импортын хориг саадыг арилгах нөхцөл бүрдэнэ.

Геологи судалгааны зардлыг нэмэгдүүлнэ. Монгол Улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлж эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, гео-экологийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд геологийн судалгааны ажлын цар хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний зардлыг **11.3** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.

5.8. Аюулгүй байдал

Цэргийн алба хаагчдын нийгмийн баталгаа. Хууль зүй, дотоод хэргийн салбарын 1290 алба хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд **36,809.2** сая төгрөг тусгасан нь өмнөх жилээс **22,228.7** сая төгрөгөөр нэмэгдэж байгаа бол батлан хамгаалах салбарын 371 алба хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд **7,770.8** сая төгрөг тусгасан нь өмнөх жилээс **2,865.7** сая төгрөгөөр буурч байна.

Хууль зүй, дотоод хэргийн салбарт ажиллагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5 жилийн урамшууллын зардалд **11,283.2** сая төгрөг тусгасан нь өмнөх жилээс **1,805.2** сая төгрөгөөр нэмэгдэж байгаа бол батлан хамгаалах салбарт **616.3** сая төгрөг тусгасан нь өмнөх жилээс **504.9** сая төгрөгөөр буурч байна.

Шинэ хөрөнгө оруулалтын улмаас нэмэгдэх урсгал зардал. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт 667.7 сая төгрөг, Цагдаагийн ерөнхий газарт 170.3 сая төгрөг, Хил хамгаалах ерөнхий газарт 210.0 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 52.1 сая төгрөг,

Гадаадын иргэн, харьяатын газарт 35.4 сая төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 23.3 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 30.2 сая төгрөг тус тус нэмэгдүүлэн тусгав. Мөн Батлан хамгаалахын салбарын шинэ хөрөнгө оруулалтын улмаас нэмэгдэх урсгал зардалд 144.1 сая төгрөг нэмж тусгав.

Зэвсэгт хүчний анги, салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна. Зэвсэгт хүчний анги, салбарын анхан шатны эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдаж буй эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 250.0 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийн зардлыг 193.6 сая төгрөг, нийт **443.6** сая төгрөг нэмэгдүүлэн тусгав.

Тусгай эмнэлгүүдэд ЭМД-ын сангаас олгох санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зардлыг 2,401.8 сая төгрөгөөр, Цэргийн төв эмнэлгийн зардлыг 984.1 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдүүлэв.

Хилийн цэргийн алба хаагчдад олгох нэмэгдлийн хэмжээг шинэчилнэ. “Хилийн цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас болон хэрэглэлийн норм, эдэлгээний хугацаа, хүнсний хангамжийн хэмжээ, хилийн нэмэгдэл олгох журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 174-р тогтоолоор хилийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосны дагуу хил дээр алба хааж буй 5913 хилчдэд олгох хилийн нэмэгдэлд нийт **5,014.1** сая төгрөг нэмж тусгав.

Гадаад паспорт. Засгийн газрын 2017 оны 94 дүгээр тогтоолоор гадаад паспортын хүчинтэй хугацааны сунгалтын бүртгэл хийгдэхгүй болсон тул энгийн гадаад паспортын бэлдцийн зардлыг **1,153.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэв.

Тэмдэглэлт ой. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэх зардалд **1,300.0** сая төгрөг тусгав.

Гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөлтийг оновчтой болгоно. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгахад чиглэсэн арга хэмжээний зардлыг Засгийн нөөц сангаас санхүүжүүлж байгааг өөрчилж, гамшгийн эрсдэлийн удирдлагыг шуурхай хангах үйл ажиллагаанд 8.0 тэрбум төгрөг зарцуулахаар тусгалаа.

Гал унтраах анги, бүлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоолоор нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Баян-Өлгий, Баянхонгор, Төв, Хөвсгөл аймагт шинээр байгуулагдсан эрэн хайх, аврах 5 анги, 4 бүлэг 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагаа эхлүүлэхтэй холбогдуулан нийт 264 орон тоо, 4.2 сая төгрөгийн урсгал зардал нэмж тусгав. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу онцгой байдлын байгууллагын алба хаагчдад онцгой нөхцөлийн, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход нийт 4.1 тэрбум төгрөг зарцуулахаар тооцож, төсвийн төсөлд тусгав.

Хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөнө. Хилийн боомт дээр ачаа тээвэрлэлт саатдаг шалтгаан болж байгаа дэд бүтцийн асуудал зэргийг цогцоор нь шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгана.

Энэ хүрээнд хилийн гаалийн төв лабораторийг өргөтгөж чадавхжуулах, хилийн боомтууд дээр салбар лабораториудыг байгуулах, гаалийн хяналтын тоног төхөөрөмжийг сайжруулах, теле хяналтын нэгдсэн системийг бий болгох зэрэг бүтээн ажлууд хийгдэхээр төлөвлөсөнтэй холбоотойгоор Гаалийн байгууллагын урсгал зардлыг **3,143.0** сая төгрөгөөр нэмэгдэхээр тооцож төсвийн төсөлд тусгалаа.

Засгийн газрын 2014 оны "Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоолын дагуу Монгол-Оросын улсын хилийн Алтанбулаг-Хиагт боомтоор зорчигч нэвтрүүлэх ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлсэнтэй холбоотойгоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 41 орон тоо 468.1 сая

төгрөгийн урсгал зардлыг нэмэгдүүлэн төсөвлөлөө.

Шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулах Хөшигийн хөндийд баригдаж буй нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагаа эхэлж байгаатай холбоотойгоор шинэ нисэх буудалд үйл ажиллагаа явуулах гаалийн байгууллагын урсгал зардлыг **872.8** сая төгрөгөөр нэмэгдүүлж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр эрчимтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ази Номхон Далайн Бүсийн Байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээний тайланг 2018 оны 7 дугаар сард хэлэлцэж, Монгол Улсыг "эрчимтэй хяналтад" оруулах шийдвэрийг хэвээр үлдээсэн. Харилцан үнэлгээний тайлангийн мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг ирүүлэх хугацааг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан. Энэхүү тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоодын тогтолцоог сайжруулах зорилгоор олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу төсөвт нийт 941.6 сая төгрөгийг тусгасан. Ингэснээр, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээний мөрөөр шаардлагатай зохицуулалтыг баталж мөрдүүлэх, олон улсын хурал, зөвлөгөөнд холбогдох байгууллагуудын төлөөлөлтэйгөөр бэлтгэлтэй оролцох, холбогдох байгууллагуудад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч Монгол Улс "саарал жагсаалт"-д орох эрсдэлээс сэргийлэх ажил хийгдэнэ.

5.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа

Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид 27.4 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар байгаа нь 2018 онтой харьцуулахад 36 хувиар нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 11. Тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгийн өөрчлөлт

Хууль	2018	2019	Өөрчлөлт	
	Төл	Төс	Тоо	%
НИЙТ	4,079	5,401	1,322	32%
Төрийн албаны тухай	474	730	256	54%
Боловсролын тухай	811	1,198	387	48%
Эрүүл мэндийн тухай	877	663	-214	-24%
Цэргийн албан хаагчийн Т.Т тухай	980	1,604	624	64%
Хөдөлмөрийн тухай	937	1,206	269	29%
Зарцуулах хөрөнгө /тэрб.төг/	76.9	104.3	27.4	36%

Ирэх онд нийт 5.4 мянган албан хаагч төрийн албанаас тэтгэвэрт гарах ба үүний 35.8% нь хууль зүй, батлан хамгаалах болон онцгой байдлын салбараас, 32.2% нь боловсролын салбараас, 12.3% нь эрүүл мэндийн салбараас, 7.8% нь орон нутгийн засаг захиргааны байгууллагаас, 11.9% нь төрийн захиргааны бусад байгууллагаас тэтгэвэрт гарагч эзэлж байна.

5.10. Орон тооны өөрчлөлт

Төрийн албан хаагчдын тооны өсөлт 2019 онд 2.1 мянгаар нэмэгдэхээр байна. Ирэх онд орон тоо нийт 4.3 мянгаар нэмэгдэж, 2.2 мянгаар буурах ба цэвэр өөрчлөлт нь 2.1 мянган хүнээр нэмэгдэхээр байна. Орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор урсгал зардлыг 60.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон тооны нэмэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгт 3,308 орон тоо, эмнэлэгт 543 орон тоо, гал унтраах аврах анги, эрэн хайх, аврах бүлэгт 264 орон тоо, хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой 141 орон тоо, Төрийн албаны

зөвлөлийн бүтцийг өргөжүүлэхтэй холбоотой 26 орон тоо нэмэгдэж байна.

Мөн улсын 2 дугаар төв эмнэлэг болон хавдар судлалын үндэсний төвийг бие даалган төсвөөс гаргах, мөн орон нутгийн хот тохижилтын албыг өөрийн орлогоор санхүүжүүлэх болсонтой холбогдуулан орон тоо 2,233 хүнээр буурахаар байна. Үүнтэй холбогдуулан зардал буурахгүй бөгөөд бараа үйлчилгээний бусад зардалд шилжиж байгаа болно.

Хүснэгт № 12. Орон тооны өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг/

Хүчин зүйлс	Орон тоо	Урсгал зардал
НИЙТ	**2,068**	**61.0**
I. Нэмэгдэх	4,301	60.1
1.Шинэ сургууль, цэцэрлэг	3,308	41.4
2.Шинэ эмнэлэг	543	8.1
3.Шинэ гал унтраах анги, эрэн хайх, аврах бүлэг	264	4.2
4.Хилийн боомтын үйлчилгээ өргөжүүлэх	141	4.5
5. Төрийн албаны шинэ хууль хэрэгжихтэй холбогдуулан ТАЗ-ын бүтцийн өөрчлөлт	26	0.4
6.Худалдааны төлөөгчийн газар байгуулах, Гадаад харилцааг өргөжүүлэх, жендерийн хороо	19	1.5
II. Буурах	-2,233	1.0
1.УХТЭ-ийг төсвөөс гаргах	-1,176	-
3. Хот тохижилтыг АА-н тооцоонд гаргах	-1,057	-

5.11. Орон нутгийн өмчийн байр ашиглалтын зардал

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох тусгай шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлыг орон нутгийн суурь зардалд шилжүүлж өмчийн ашиглалтыг сайжруулна. Орон нутагт эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зардлыг харилцан адилгүй хуваарилсны зэрэгцээ барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт суларч өмч эзэнгүйдэхэд хүрч байгаа нь ирээдүйд гарах засвар арчилгааны зардлыг ихээр нэмэгдүүлэхээр байна.

Иймд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв зэрэг 7 байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, түрээс, урсгал засвар/-ыг орон нутаг хариуцдаг байхаар өөрчлөх ба энэ зориулалтаар 2019 онд улсын төсвөөс 138.1 тэрбум төгрөгийг орон нутгийн суурь зарлагад тооцож орон нутгийн төсөвт шилжүүлнэ. Ингэснээр орон нутгийн засаг захиргаа буюу өмчийн эзэн нь өмчийнхөө ашиглалтыг бүрэн хариуцдаг тогтолцоонд шилжиж өмчийн ашиглалт, хамгаалалт сайжрах, өр авлага үүсгэхгүй ажиллах давуу талтай. Энэхүү зохицуулалттай холбогдуулан Төсвийн тухай хууль болон Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бэлтгэв.

5.12. Төрийн бусад үйлчилгээ

Улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үйлчилгээг ойртуулна. “Нэг иргэн, нэг бүртгэл хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж иргэд аж ахуйн нэгжүүд төрийн болон цахим бизнес, онлайн банкны үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлнэ. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

Оюуны өмчийн газрыг өөрийн орлогоос санхүүжүүлнэ. Оюуны өмчийн газрын зардлын 19 хувийг улсын төсвөөс, 81 хувийг өөрийн орлогоос санхүүжихээр тооцож, нийт **970.0** сая төгрөгийг төсөвлөв.

Төрийн албан хаагчдын цахим бүртгэлийг нэгтгэж орон тоо, цалин хөлсний зардлын хяналтыг сайжруулна. Төсөвт байгууллагын орон тооны хязгаарыг цалингийн сангаар хянадаг ба орон тооны хязгаараас давсан ажилчдыг төсөвт байгууллагын үйл ажиллагааны хэмнэгдсэн зардлаас цалинжуулж гэрээгээр ажиллуулж байна. Иймд төсвийн сахилга батыг сайжруулах, төсөвт байгууллагын ажиллах хүч, хүний нөөцийг үр дүнтэй байлгах

зорилгоор төрийн албан хаагчдын хүний нөөцийн бүртгэлийн системийг нэвтрүүлнэ.

Төрийн албаны хүний нөөц, шилжилт хөдөлгөөн, цалин хөлсийг цахим систем ашиглан бүртгэнэ. Ингэснээр төрийн байгууллагын нийт орон тоо, цалингийн зардлын төлөвлөлт, зарцуулалтыг бүрэн хяналтад оруулж төсвийн үргүй зардлыг эрс бууруулна.

Түлш халаалтын зардлын үр ашгийг нэмэгдүүлнэ. Аймаг, сумдад мөрдөгдөж байгаа дулааны үнэ, тарифыг бодитой тогтоох, түлш халаалтын зардлын ачааллыг бууруулах, тоолууараар буюу хэрэглэсэн дулааны эрчим хүчний хэмжээгээр төлбөрөө төлдөг байх, түлш халаалтын хэмнэсэн зардлаа төсвийн байгууллагууд бусад зардалдаа шилжүүлэн зарцуулдаг байх чиглэлээр дараах өөрчлөлтүүдийг хийнэ:

1. Аймаг, сумдад мөрдөгдөж байгаа дулааны үнэ, тарифыг тогтоох аргачлал, процессыг боловсронгуй болгоно.

2. Төвлөрсөн халаалтын системд холбогдсон төсвийн байгууллагын дулааны төлбөрийг байрны эзлэхүүний хэмжээгээр халаалтын саруудад тогтмол төлдөг байдлаас бодит хэрэглээнд нь үндэслэн тоолуурын заалтаар төлдөг тогтолцоонд шилжинэ.

3. Өөрийн бие даасан халаалтын зуухтай төсөвт байгууллагуудад өөрийн дулааны эрчим хүчний хэрэгцээг бие даан хангах боломжийг олгож, хэрэв төвлөрсөн халаалтын системд холбогдох бол урсгал зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохион байгуулна.

Дотоод албан томилолтын тарифыг нэмэгдүүлнэ. Төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 2011 оноос хойш шинэчлээгүй хэвээр мөрдөж байна. Зах зээл дэх бараа, ажил үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлт, ялангуяа зочид буудал, тээвэр шатахууны үнийн өсөлтийг харгалзан холбогдох судалгаанд үндэслэн тарифыг дараах байдлаар шинэчлэн тогтоохоор тооцов.

Хүснэгт № 13. Дотоод албан томилолтын тарифын өөрчлөлт /мян.төг/

	Одоогийн		Шинэчлэх	
	Аймаг	Сум	Аймаг	Сум
Зам хоног, байр /Дархан, Орхоноос бусад/	29.0	8.0	50.5	26.5
Зам хоног, байр /Дархан, Орхон/	35.5	-	69.0	-
Байр /Дархан, Орхон ороогүй/	15.0	6.0	6.5	4.5
Байр /Дархан, Орхон/	19.5	-	53.0	-

Сумдын санхүүгийн албадад бүтцийн өөрчлөлт хийнэ. Сумын санхүүгийн алба нь суманд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлтийг хариуцаж үйл ажиллагаа явуулж байна. Нягтлан бодогчид сумын ЗДТГ-т төвлөрөн ажилласнаар сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг байгууллагуудад нягтлангийн хараа хяналт алдагдах асуудлууд гарч байна.

Нөгөөтэйгөөр, сумын санхүүгийн алба нь жилийн турш нийт 26 төрлийн тайлан, мэдээг 1-12 удаагийн давтамжтайгаар, 8-9 өөр програм хангамж ашиглан боловсруулж, мэдээлдэг. Эдгээр тайлан, мэдээний тайлант хугацаа хоорондоо давхацдаг, олон төрлийн програм хангамж дээр ажиллах шаардлагатай байдаг зэрэг нь тэдний ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлж байна.

Тиймээс 2019 оны төсвийн жилээс эхлэн 8000-аас доош хүн амтай сумын цэцэрлэг, эмнэлэг, сургууль зэрэг байгууллагад нягтлангуудыг харьяалуулан ажиллуулж, харин сумын засаг даргын тамгын газрын бүтэц орон тоонд сумын санхүүгийн албыг хэвээр үлдээн 2-3 орон тоотойгоор ажиллуулах зохион байгуулалтын өөрчлөлтийг хийнэ.

Мөн сумын санхүүгийн албаны даргын цалин хөлсний шатлалыг байгаль орчны улсын байцаагч, мал эмнэлгийн тасгийн дарга, газрын даамал

зэрэг албан тушаалуудтай ижил төвшинд хүргэнэ.

Орон нутгийн төсвийн онцлог, хэрэгцээнд тохирсон татаас шилжүүлгийн механизмыг нэвтрүүлнэ. Төсвийн хуваарилалтын тэгш байдлыг хангаж, өмчийн хариуцлагыг нэмэгдүүлнэ. Орон нутгийн төсөвт тулгамдаж байгаа төсвийн тэгш бус хуваарилалтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүний тулд тухайн орон нутгийн алслалт, хүн ам, малын тоо толгой, газар нутгийн хэмжээ, газарзүйн онцлог, дэд бүтцийн хөгжил, тухайн бүс нутаг дахь бараа үйлчилгээний зах зээлийн үнэ ханш зэрэг орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон байдлаар төсвийг хуваарилах аргачлалыг 2019 оны төсвийн жилээс нэвтрүүлнэ.

5.13. Засгийн газрын тусгай сан

Монгол Улсын 2019 оны төсвийн жилд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 3,591.2 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 88.3 хувь буюу 3,170.7 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 11.7 хувь буюу 420.5 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

Хүснэгт № 14. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум.төг/

#	ЗГ-ын тусгай сан	2017 Гүйц.	2018 Төл.	2019 Төсөл
	НИЙТ	**3,166.1**	**3,287.2**	**3,591.2**
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2.2	2.5	2.1
2	Хилийн чанадад байгаа МУ-ын иргэдэд туслах сан	0.2	0.2	0.2
3	Олон улсын хамтын ажиллагааны сан	0.1	1.0	1.0
4	Засгийн газрын нөөц сан	28.9	25.0	25.0
5	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	29.8	40.0	35.0
6	Эрүүл мэндийг дэмжих сан	3.0	5.0	3.0
7	Байгаль орчин, уур амьсгалын сан	1.9	1.9	1.9
8	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.2	0.6	0.6
9	Боловсролын зээлийн сан	45.0	118.9	118.5
10	Соёл, урлаг хөгжүүлэх сан	1.0	2.0	2.0
11	Шинжлэх ухаан, технологийн сан	8.8	12.5	12.6
12	Монгол судлалыг дэмжих сан	0.5	0.9	0.9
13	Спортыг дэмжих сан	0.6	3.0	2.0
14	Улсын авто замын сан	1.8	2.1	2.1
15	Тариаланг дэмжих сан	82.3	65.9	52.0
16	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	50.6	99.2	1.0
17	Мал хамгаалах сан	76.9	36.7	36.3
18	Нийгмийн халамжийн сан	585.2	648.0	694.5
19	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	53.2	65.3	75.4
20	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	8.1	6.8	49.0
21	НД сан	1,890.9	1,808.3	2,068.5
22	ЭМД сан	294.9	341.3	407.7

Боловсролын зээлийн сан

Боловсролын зээлийн санд нийт 118.5 тэрбум төгрөг төсөвлөснөөс оюутны хөгжлийн зээлд 75.0 тэрбум төгрөг, дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлд 14.5 тэрбум төгрөг, зарим суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэгт 12.6 тэрбум төгрөг, Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээлд 7.3 тэрбум төгрөг, багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөрт 2.8 тэрбум төгрөг, бусад зээл, арга хэмжээний зардалд 5.9 тэрбум төгрөг тусгасан.

Нийгмийн халамжийн сан

Халамжийн сангийн нийт зарлага 694.5 тэрбум төгрөг байгаа нь урьд оноос 46.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Зардлын нэмэгдлийг шалтгаанаар нь авч үзэхэд халамжийн тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэхэд 21.2 тэрбум төгрөг, хүн амын өсөлтөөс шалтгаалан 25.2 тэрбум төгрөг тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 15 . Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Халамжийн сан	2018 Бат	2019 төсөл
Халамжийн тэтгэвэр	96.5	99.5
Жирэмсэн эхийн тэтгэмж	19.8	18.1
Ахмад дайчин, алдар цолтон	6.4	6.4
Алдарт эхийн тэтгэмж	29.4	29.4
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	164.2	218.9
Нөхцөлт мөнгөн тусламж	35.2	37.5
Олон нийтийн оролцоо	3.3	1.8

Амьжиргааг дэмжих тусламж	23.1	27.8
Асрамжийн үйлчилгээ	0.2	0.2
Хүнсний талон	42.2	42.2
ХБИ тэтгэмж	12.3	12.3
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	22.3	26.1
Цалинтай ээж	96.8	96.8
Насны хишиг	20.5	22.3
Халамжийн бусад хөнгөлөлт	55.5	31.1
Тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх	17.8	21.2
Үйл ажиллагааны зардал	2.6	2.7
НИЙТ	**648.0**	**694.5**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт зардлыг 75.4 тэрбум төгрөгөөр тооцсон нь өмнөх оноос 10.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Дэлхийн банкнаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор зарим арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцож өөрийн орлогоор санхүүжүүлэх зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг тус тус бууруулсан. Мэргэжлийн боловсролын сургалтын суралцагчдад сар бүр 100 мянган төгрөгийн тэтгэмжийг гадаад иргэдийн ажлын байрны төлбөрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан олгохоор тооцож 41.0 тэрбум төгрөгийн нэмж тусгалаа.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сан

Мэргэжлийн боловсролыг дэмжих сангийн 2019 оны төсвийн нийт зардлыг 49.0 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2018 оноос 42.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Сангийн зардал нэмэгдсэн гол шалтгаан нь 2019 оноос мэргэжлийн боловсролын сургалтын суралцагчдад сар бүр 100 мянган төгрөгийн тэтгэмж олгохоор тооцож нийт 41.0 тэрбум төгрөг, хувийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудын хувьсах зардалд хүүхдийн тооны өсөлтөөс шалтгаалан 1.2 тэрбум төгрөг нэмэгдсэн байна.

5.14. Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсөвт нийт орлого 1,603.3 тэрбум төгрөг, нийт зарлага 2,068.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Энэ нь 2018 онтой харьцуулахад орлого 301.9 тэрбум төгрөг, зарлага 260.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Хүснэгт № 16 . Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2017 Гүйц	2018 Төсөв	2019 Төсөл
ОРЛОГО	**1,544.0**	**1,301.4**	**1,603.3**
1 Шимтгэлийн орлого	1,432.2	1,240.9	1,534.7
2 Бусад орлого	111.8	60.5	68.6
ЗАРЛАГА	**1,890.9**	**1,808.3**	**2,068.5**
1. Тэтгэврийн даатгалын	1,417.3	1,619.6	1,859.9
2. Тэтгэмжийн даатгалын	100.2	102.4	114.1
3. ҮОМШӨ-ний даатгалын	29.4	31.7	32.9
4. Ажилгүйдлийн	34.6	35.4	36.8
5. Эрүүл мэндийн	288.0	0.0	0.0
6. Бусад зарлага	0.2	0.1	0.01
7. Ажиллагааны зардал	21.4	19.0	24.7
Улсын төсвөөс олгох	**570.2**	**609.8**	**605.5**

5.14.1. Нийгмийн даатгалын сангийн орлого

Ирэх 2019 онд 46.9 мянган аж ахуйн нэгж байгууллагын 878.8 мянга гаруй ажилтан албан журмын даатгалд хамрагдахаар байгаа нь 2018 оноос 21.4 мянган хүнээр нэмэгдэхээр байна. Харин албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 320.0 гаруй мянган иргэдийн 64.8 хувь буюу 207.2 орчим мянган хүн сайн дурын даатгалд хамрагдахаар тооцлоо.

Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалд хамрагдах даатгуулагчдын хүрээг нэмэгдүүлэх, боломжит бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар 2019 онд нийгмийн даатгалын санд төвлөрөх шимтгэлийн орлого 1,534.7 тэрбум төгрөг, хадгаламж болон үнэт цаасны хүүгийн орлого 68.6 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Харин цэргийн албан хаагчдын тэтгэвэр, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийг төр хариуцахаар заасан болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөн зорилгоор улсын төсвөөс 605.5 тэрбум төгрөг олгохоор тооцлоо.

УИХ-аар батлагдсан Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг аажмаар буюу 3 жилийн хугацаанд ажил олгогч болон даатгуулагч тус бүр 2.5 пунктээр, нийт 5.0 пунктээр нэмэгдүүлэхээр баталсантай холбоотойгоор тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 2019 онд 70.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Хүснэгт № 17. НДШ-ийн хувь хэмжээний өөрчлөлт

Үзүүлэлт	2018	2019 он	Өөрчлөлт
Тэтгэвэр	16.0	17.0	1.0
Тэтгэмж	1.8	1.8	-
Ажилгүйдэл	0.4	0.4	-
Эрүүл мэнд	4.0	4.0	-
ҮОМШӨ	0.8-2.8	0.8-2.8	-
Нийт дүн	**23.0-25.0**	**24.0-26.0**	**1.0**

5.14.2. Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зардал 2,068.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 онтой харьцуулахад 260.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Улсын Их Хурлаар 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 2019 оноос хэрэгжиж эхлэхээр шийдвэрлэсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд нь нийгмийн даатгалын сангийн зарлагыг 2019 онд 81.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үр дагавартай байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд алдагдал нь байнга нэмэгдэж байгаа тэтгэврийн даатгалын сангийн зарлага болон сангийн алдагдлыг нөхөх зорилготой улсын төсвөөс олгох татаасыг их хэмжээгээр нэмэгдүүлэхээр байгаа тул дээрх хуулиудын хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулж 2020 оноос хэрэгжиж эхлэхээр тооцож холбогдох хуулийн төслийг боловсруулаа.

5.14.3. Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 1,859.9 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,258.3 тэрбум төгрөгөөр тооцлоо. Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 76.0 хувийг өндөр насны тэтгэвэр, 13.0 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 7.0 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2019 онд нийт 439.9 мянган хүний тэтгэвэрт 1,858.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2018 онтой харьцуулахад 240.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

График № 21 .Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 16 дугаар тогтоолоор бүх тэтгэврийн хэмжээг 27.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээ 251.0 мянган төгрөгөөс 280.0 мянган төгрөгт хүрч 11.6 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 216.0 мянган төгрөгөөс 243.0 мянган төгрөгт хүрч 12.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График № 22. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ /төгрөгөөр



Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2019 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч байгаа эрэгтэй (60 нас) 10.8 мянга, эмэгтэй (55 нас) 16.6 мянган хүн байна. Дээрх судалгаанд үндэслэн шинээр тэтгэвэр тогтоолгох 45.9 мянган хүн, харин тэтгэвэр нь зогсох 22.8 мянга хүн, цэвэр өсөлтийг 23.1 мянган хүн байхаар тооцлоо.

Улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан цэргийн тэтгэвэрт гарах иргэдийн тоо 2019 онд 733 хүнээр нэмэгдэж нийт 18.8 мянган хүн, харин 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нийт 55.8 мянган иргэн тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаар байна. Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээг 601.6 тэрбум төгрөг байгаагаас цэргийн болон 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 366.1 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх зорилгоор 235.5 тэрбум төгрөг олгохоор төсөвлөлөө.

Улсын төсвөөс 2017-2019 онд тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх зорилгоор нийт 791.3 тэрбум төгрөг олгохоор байна.

Хүснэгт № 18. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2017	2018	2019
1. Улсын төсвийн татаас	587.3	609.8	601.6
Үүнээс:			
1.1. Цэргийн тэтгэвэр	*103.8*	*107.9*	*130.5*
1.2.1995 оноос өмнөх	*227.0*	*202.6*	*235.6*
1.3.НДС-н алдагдалд	***256.5***	***299.3***	***235.5***

Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцож нийт 119.5 тэрбум төгрөг тусгалаа. Ингэснээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах 421.5 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх юм.

Хүснэгт № 19. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол /мян хүн, тэрбум төгрөг/

Тэтгэврийн төрөл	Хүн Тоо	Дундаж тэтгэвэр /мян ₮/		Нэмж шаар-дагдах
		2018	2019	
НИЙТ	**421.5**	**343.5**	**388.6**	**119.5**
НД тэтгэвэр:	403.4	295.1	318.7	114.4
Үүнээс:				
Өндөр нас	*307.0*	*351.8*	*375.4*	*87.0*
Тахир дутуу	*75.3*	*262.8*	*286.4*	*21.4*
Тэж. алдсаны	*21.1*	*269.2*	*292.8*	*6.0*
Цэргийн тэтгэвэр	18.0	576.0	599.6	5.1

5.14.4. Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сан 2019 онд 133.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 116.2 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар тооцлоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар (сайн дурын даатгуулагчид 70 хувь) олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

Хүснэгт № 20. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мян хүн, тэрбум төгрөг/

Тэтгэмж	2018		2019		Өөрчлөлт	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
ХЧТА	131.7	17.2	133.0	18.7	1.3	1.5
Ж.А	60.1	71.7	60.7	86.6	0.6	14.9
Оршуул-гын	13.4	13.4	13.4	13.4	0.0	0.0
Нийт	**190.5**	**101.9**	**207.1**	**118.7**	**1.9**	**16.4**

Тэтгэмжийн даатгалын сан 2015 онд 8.3 тэрбум төгрөг, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2 пунктээр нэмэгдүүлснээр 2017 онд 12.6 тэрбум, 2018 онд 9.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж сангийн үйл ажиллагаа тогтворжиж 2019 онд 17.7 тэрбум төгрөгийн ашигтай байх тооцоотой байна.

5.14.5. ҮОМШӨ-ий даатгалын сан

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд 2019 онд 168.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд нийт 55.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 5.6 мянган иргэнд нийт 29.8 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

5.14. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 2019 онд 43.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 37.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Тус сангаас 2019 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 21.3 мянган иргэнд 36.6 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

5.15. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2019 онд 407.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 оны орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 31.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Энэ нь цалин өссөн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг ирэх онд олсон орлогын хэмжээгээр буюу 407.7 тэрбум төгрөгөөр тооцлоо.

Хүснэгт № 21. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төг/

Үзүүлэлт	2018 төл	2019 төс
ОРЛОГО	**376.0**	**407.7**
Ажил олгогч ААН-ээс төлөх шимтгэл	97.7	100.6
Даатгуулагчаас төлөх шимтгэл	119.6	122.5
Төсөвт газраас төлөх шимтгэл	36.2	44.5
Төр хариуцах иргэдийн шимтгэл	67.7	83.9
Бусад даатгуулагчаас төлөх	15.5	16.8
Бусад орлого	39.3	39.3
ЗАРЛАГА	**341.3**	**407.7**
Улсын эмнэлгүүдэд олгох	214.5	222.3
Сум, тосгоны эмнэлгүүдэд олгох	-	8.7
Төрийн өмчит АА тооцоот эмнэлгүүдэд олгох	-	22.3
Эмийн сан, хувийн эмнэлэгт олгох	122.5	148.9
Ажиллагааны зардалд зарцуулсан	4.0	5.4
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн төлбөр	0.03	0.03
НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	0.24	0.24
ТЭНЦЭЛ	**34.7**	**-**

ЭМД-ын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлт болон урьдчилан сэргийлэх үйлчилгээ. Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлыг 4,942.7 сая төгрөгөөр, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээний зардлыг 3,612.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тооцсон.

ЭМД-ын сангаас анхан шатлалын тусламж үйлчилгээнд олгох санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн аргачлалыг шинэчлэх, тусламж, үйлчилгээний багцыг нэмэгдүүлэхэд зориулж эрүүл мэндийн даатгалын сангаас 15,891.5 сая төгрөг төсөвлөв.

Анхан шатлалын тусламж, үйлчилгээг улсын төсвөөс бүрэн хариуцаж байгаа бөгөөд алслагдсан орон нутагт амьдарч буй иргэд эрүүл мэндийн даатгалын

үр шимийг шууд хүртэж чадахгүй, ач холбогдлыг төдийлөн ойлгохгүй байгаа учраас малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд эрүүл мэндийн даатгалын хамрагдалт бага байна. Харин анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлснээр иргэд өөрт ойр өрх, сум, тосгоны эмнэлгээс тусламж, үйлчилгээ авах, тусламж, үйлчилгээ авахдаа өөрөөс зарцуулах төлбөрийн хэмжээ буурах, бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад хүрэхэд чухал алхам болох юм.

Иймд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нэн шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход илүү анхаарах, эрүүл байх зан үйлийг төлөвшүүлэхийг дэмжсэн санхүүжилтийн аргачлалыг боловсруулж, анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжихээр төлөвлөсөн. Тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт, түүний хяналтын тогтолцоо нь чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Уг аргачлал хэрэгжсэнээр төсвийг тогтвортой хөгжлийн үзүүлэлт, салбарын бодлоготой уялдуулан санхүүжүүлж, үр дүнг нь гүйцэтгэлтэй уялдуулах, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний ачааллыг бууруулах боломж бүрдэх юм.

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Элэг бүтэн монгол хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зардалд 8,822.0 тэрбум төгрөг нэмж зарцуулна. Хөтөлбөрийн хүрээнд элэгний С вирусийн идэвхжилийг тодорхойлдог байсан бол 2018 оны 7 сараас элэгний В вирусийн идэвхжилийг тодорхойлох үйл ажиллагааг эхлүүлж сонгон шалгаруулалтад тэнцсэн 25 лабораториттой гэрээ байгуулан ажиллаж байгаатай холбоотой хөтөлбөрийн шинжилгээний зардал нэмэгдэж байна. Мөн элэгний В, С вирусийн эсрэг хэрэглэгдэж буй эмийн зардлаас гадна элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэх эмийн эмчилгээг Монгол улсад хөгжүүлэх, улмаар эмчилгээнд нэвтрүүлэх зорилгоор Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг нэмэгдүүлэн тусгалаа.

Иргэн хувийн эмнэлгээр үйлчлүүлэхэд эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөх зардлын хэмжээг нэмэгдүүлж, иргэнд учрах төлбөрийн дарамтыг бууруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ялгаатай олгодог байдлыг үе шаттайгаар бууруулахаар төлөвлөж 2019 онд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад олгох хэвтүүлэн эмчлэх, оношилгоо, шинжилгээ хийлгэх, амбулаторийн тусламж, үйлчилгээнд зориулж 6.8 тэрбум төгрөг нэмж тооцов. Ингэснээр төрийн эмнэлгийн үйлчилгээний ачааллыг бууруулах, даатгуулагч эмнэлгийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломжийг бүрдүүлнэ.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийн ашиглалтыг сайжруулна. НӨАТ-ын урамшууллын системд суурилсан эрүүл мэндийн даатгалын цахим системийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Ирэх онд цахим системийг үргэлжлүүлэн хөгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа системтэй холбох, мэдээлэл дамжуулах, өөр систем дээрх лабораторийн хариуг татаж харуулах болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн системтэй холбох, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулахад ашиглагдах мэдээллүүдийг нэгтгэн харуулах системтэй болоход зориулж 980.0 сая төгрөг төсөвлөв.

Мөн мобайл технологийг хөгжүүлж эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй холбоотой тусламж, үйлчилгээ авч чадахгүй хохирч байгаа иргэдэд дэмжлэг үзүүлэх, 2019 оноос эрүүл мэндийн даатгалын дэвтэргүйгээр иргэний үнэмлэхээр үйлчилгээ авдаг болох, иргэн бүр өөрийн эрүүл мэндийн даатгалын төлөлт,

зарцуулалтдаа хяналт тавих боломжтой болно. Мобайл системээс хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт, даатгалаас хөнгөлөгдөх тусламж, үйлчилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалаар үйлчилдэг байгууллагуудын мэдээллийг авч болохоос гадна хэрэглэгчдийн хувьд эрүүл мэндийн даатгал төлсөн байдал, эрүүл мэндийн даатгалыг эм, эмчилгээнд ашигласан байдлыг харуулна. Түүнчлэн элэгний хепатит В, С вирусийн илрүүлэг, хавдрын эрт илрүүлгийн мэдээлэл авах боломжтой.

5.15. Эргэж төлөгдөх зээл

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн үр нөлөө, хяналт, хариуцлагыг сайжруулж, нэгдсэн нэг бодлогоор удирдана. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч, санхүүжилтийг нэмэгдүүлж ирсэн. Тухайлбал, 2008-2009 онд улсын төсвөөс 60.4 тэрбум төгрөг, Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж, төвлөрүүлсэн эх үүсвэрээс 2011-2012 онд 290.1 тэрбум төгрөг, 2018 онд улсын төсвөөс 70.5 тэрбум төгрөгийг тус тус Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан (ЖДҮХС)-д олгож, үйлдвэрлэгчдэд зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 335.0 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй сан бий болсон байна.

ЖДҮХС нь арилжааны банкуудаар дамжуулахгүй шууд зээл олголтыг хийж, хяналтын тогтолцоо сул байснаас үүдэн зөрчилтэй, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж 2018 оны 8 дугаар сарын байдлаар 75.6 тэрбум төгрөгт хүрсэн. Энэхүү чанаргүй зээл нь 2009-2016 оны хооронд олгогдсон бөгөөд 19.8 тэрбум төгрөгийг тус сангаас шууд, 55.7 тэрбум төгрөгийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон байна.

Түүнчлэн ЗГҮЦ арилжаалж төвлөрүүлсэн эх үүсвэрийн үлдэгдэл 130.1 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өрийг улсын төсөвт хугацаанд нь төлж барагдуулах бүрэн боломжтой байсан боловч эх үүсвэрийг дахин зээл олгоход ашиглаж хугацаа хэтэрсэн өр үүсгэсэн байна.

Дээр дурьдсан зөрчлүүдээс гадна (i) орлого зарлагын тоон үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн; (ii) бүртгэлийг алдаатай, дутуу хөтөлсөн, зохих хяналтыг тавиагүй; (iii) төслийн зээл, санхүүжилтийн өр авлагыг барагдуулаагүй (iv) зээлийн чанар үр дүн хангалтгүй (v) гэрээг дүгнэж үр дүнг тооцож баталгаажуулаагүй зэрэгтэй холбоотой нийт 84.1 тэрбум төгрөгийн санхүүгийн зөрчил тус сангийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт, шалгалтаар илэрсэн байна. Тухайлбал, 2013-2015 оны хооронд олгогдсон зээлүүдээс нийт 12.6 тэрбум төгрөгийн зээлийг зориулалтын бусаар ашигласан байгаад хяналт тавиагүй, 2015-2016 онд 23.2 тэрбум төгрөгийг ААН, иргэдэд сонгон шалгаруулалтгүйгээр шууд олгосон, 2015 онд Аж үйлдвэрийн сайдын тушаалаар 7.3 тэрбум төгрөгийг сонгон шалгаруулалтгүй шууд олгосон, 201... онд ЖДҮХС-ийн захирал холбогдох зөвшөөрөлгүйгээр 1.3 тэрбум төгрөгийн зээлийг шууд олгосон, 2010-2014 онд зээл олгосон 62 ААН-ын 13.0 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан байгааг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй, зээлийг судалгаа, шинжилгээгүй, баримт материал дутуу байхад олгосноос 10.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөх боломжгүй болсон зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Иймд дээр дурдсан нийт 214.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгаж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж, нэгэнт бий болсон эргэлтийн сангаараа үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газрын тусгай сан, гадаад зээлийн төсөл, хөтөлбөрүүдийн эх үүсвэр, хөрөнгө нийт 649.0 тэрбум төгрөг байгааг нэгдсэн бодлогоор оновчтой удирдаж, үр ашгийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт № 22. ЖДҮ-ийг дэмжих санхүүжилт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нийт эх үүсвэр
1. ЖДҮХСан	335.0
2. ТЭДСан	93.9
3. ХАА, хөдөөгийн хөгжил төсөл	16.8
4. ЖАЙКА 2 үе шаттай зээлийн төсөл	135.9
5. ДБ-ны Экспортыг дэмжих төсөл	5.4
6. ЗБДТДэмжих, ажлын байр нэмэгдүүлэх төсөл	62.0
Нийт	**649.0**

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогоор удирдаж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

1. Зээлийн нөхцөл, шалгуур, журмыг ил тод, нээлттэй болгож, санхүүжилтийн тогтолцоог сайжруулна;
2. Зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулах, хугацаа хэтэрсэн өглөг, авлага үүсгэхгүй байх чиглэлээр холбогдох журам, гэрээний нөхцөлүүдийг сайжруулна;
3. Гэрээний хяналт, хариуцлагын зохистой тогтолцоог бүрдүүлнэ;
4. Улсын төсөвт эргэж төвлөрүүлэх хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлүүлж, зөрчлийг арилгах;
5. Зээлийн батлан даалтын сангийн хууль, журмыг боловсронгуй болгох, бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Ипотекийн санхүүжилтийг зорилтот болгож, орчны бохирдлыг бууруулахад чиглүүлнэ. Монголбанкийг төсвийн шинж чанартай төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх үйл ажиллагаанаас бүрэн гаргах, ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэн авах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Ипотекийн зээлд 2019 онд 115.0 тэрбум төгрөг олгохоор тусгалаа.

Засгийн газраас ипотекийн хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хэмжээг 115.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо

Ипотекийн зээлийн санхүүжилт нь импортыг нэмэгдүүлснээр урсгал тэнцлийн алдагдлыг өсгөх, улмаар төгрөгийн ханшийг сулруулах, үл хөдлөх хөрөнгийн үнийг хөөрөгдөх сөрөг нөлөөтэй тул 2019 оны санхүүжилтийн хэмжээг 2018 оны төвшнөөс нэмэгдүүлэхгүй байхаар тооцсон.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан иргэдийг орон сууцжуулах, агаар орчны бохирдлыг багасгаж эрүүл, аюулгүй орчинд амьдруулах зорилго, зорилтуудыг биелүүлэх хүрээнд ипотекийн зээлийг агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулж байгаа өрхөд буюу (i) гэр хорооллоос газар чөлөөлж, орон сууцанд нүүн орж байгаа, (ii) анх удаа өрх тусгаарлан орон сууц худалдан авч байгаа, (iii) ногоон амины орон сууцны зээл авч байгаа өрхүүдэд олгох журам баталж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу Монголбанкны олгосон ипотекийн зээлийн хөрөнгүүдийг тус банкны тайлан, тэнцэлд хэвээр үлдээж, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Монголбанкны санхүүжилтийг шууд зогсоох бус, аажмаар бууруулж, тус банкийг ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцооноос гаргах талаар олон улсын байгууллагатай хэлэлцэж, шийдвэрлэнэ.

6. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

6.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд гарч буй нийтлэг алдаа дутагдал, зайлшгүй анхаарах асуудал

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг зөрчсөн, удаан хугацааны туршид үргэлжилсэн, дараах нийтлэг алдаа дутагдал, зөрчил байгааг цаашид тодорхой үе шаттайгаар засаж залруулах зайлшгүй шаардлагатай байна.

Зураг төсөв, ТЭЗҮ. Холбогдох зураг төсөв, ТЭЗҮ гараагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулах, үндэслэлтэй тооцоо судалгаа, жишиг стандарт баримтлалгүй төсөвт өртгийг тооцон хэрэгжилтийг эхлүүлэх, улмаар тухайн төсөл, арга хэмжээнд холбогдох зураг төсөв, ТЭЗҮ-ийн дагуу төсөвт өртөг нэмэгдэх асуудал тогтмол гарч байна.

Төсвийн сахилга бат. Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлсон төсвийн сахилга баттай байх зарчмыг хэрэгжүүлээгүйн улмаас гарч буй дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:

- ✓ Тухайн ондоо хэрэгжиж дуусах боломжтой бага хэмжээний тоног төхөөрөмж, их засвар, ТЭЗҮ зэрэг төсөл, арга хэмжээг он дамжин хэрэгжих хэлбэрээр хуульд тусгаж баталсан;
- ✓ Нийт төсөвт өртгөөс тухайн жилд санхүүжих дүнг, төслийг хэрэгжүүлэх нийт хугацаанд нийцүүлдэггүй буюу батлагдсан төсөвтэй харьцуулахад хэт багаар тусгасан.

Төсөвт ирэх ачаалал. Дээр дурдсан нөхцөл байдлаас шалтгаалан төсвийн хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилт, үр ашигтай байдалд их хэмжээгээр нөлөөлж, төсөвт их хэмжээний ачаалал үүсгэж байна.

Эдгээр нийтлэг алдаа, дутагдлын улмаас тооцоо судалгаагүй, бодитой бус хөрөнгө оруулалтын төлөвлөлт урт хугацаанд хийгдэж, олон жил дамжин үргэлжилж төсөвт өртөг нэмэгдэж байгаа төсөл, арга хэмжээг нэлээдгүй бий болгоод байна.

Цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ:

Нэг. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр ашгийг үнэлэх аргачлалыг боловсруулан, дараа оны төсвийн төлөвлөлтөөс эхлэн төсөл, арга хэмжээний үр ашигтай байдалд үнэлгээ өгөх замаар төлөвлөлтөд тусгадаг тогтолцоог нэвтрүүлэх;

Хоёр. Төсвийн тухай хууль [5] -д заасны дагуу он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн жилд бодитой, тэнцүү хуваарилах зарчмыг баримтлах;

Гурав. Холбогдох норм, норматив, стандартыг мөрдөөгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санал ирүүлсэн, мөн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хуулийн дагуу хяналт тавих эрх үүргээ биелүүлээгүй бол хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд харгалзан үздэг байх;

Дөрөв. Төсөл, арга хэмжээний нэрийг ерөнхий байдлаар тоймлон бичиж, “улсын хэмжээнд” гэж

[5] Төсвийн тухай хуулийн 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

томьёолон, он дамжин хэрэгжүүлж байгаа төслүүдийг Төсвийн тухай хууль [6][7] -д нийцүүлэн төсөл нэг бүрээр төсөвт суулгадаг байх.

Баримталсан зарчим

Хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлтөд урьд өмнө гарсан алдаа, дутагдлыг давтахгүй байх үүднээс, 2019 оны төсвийн жилийн шинэ хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөд дараах үндсэн зарчмуудыг баримталсан. Үүнд:

Нэг. Зайлшгүй эхлүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын тоо хэмжээ, хүчин чадлыг бодитой тавьж, төсөвт өртгийг жишиг үнээр тооцон, хэрэгжилтийг хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөрт нийцүүлж тусгах;

Хоёр. Дээрх төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгжилттэй нь уялдуулж, хэрэгжих хугацаанд нь нийцүүлэн санхүүжүүлэх дүнг аль болох бодитой, тэнцүү хуваах зарчим баримталсан.

6.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Монгол Улсын Засгийн газар нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 2019 оны төсвийн жилд нийт 1,217.6 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой байхаар тооцож, нийт 2,546.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 877 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

6.2.1. Хуулиар 2018 оны төсвөөс 2019 он руу шилжих хөрөнгө оруулалт

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаар нийт 2,159.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 375 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс хуулиар 1,248.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 362 төсөл, арга хэмжээний санхүүжих дүн болох 465.1 тэрбум төгрөг 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд шилжиж байна. Энэ нь ирэх оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт хөрөнгө оруулалтын 2019 онд санхүүжүүлэх дүнгийн 34%-ийг эзэлж байна.

6.2.2. Ерөнхий боловсролын сургууль

Ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ, ачаалал Улаанбаатар хотод нэн тулгамдсан асуудал болсон. Нийслэлийн 2018-2019 оны хичээлийн жилд 28 сургууль 3 ээлжээр хичээллэх урьдчилсан тооцоолол байна. Иймд нийслэлийн сургуулийн барилга, барилгын өргөтгөлийг хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэх бодлогыг 2019 оны төсвийн жилд үргэлжлүүлнэ. Түүнчлэн хөдөө орон нутгийн сургуулиудын барилгын насжилт болон чанар ашиглалтын шаардлага хангахгүй болсныг харгалзан сургуулийн барилга, барилгын өргөтгөлийг санхүүжүүлнэ.

[6] Төсвийн тухай хуулийн 29.3.3.нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;

[7] Төсвийн тухай хуулийн 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах.

Хөрөнгө оруулалтын 2019 оны төсвийн төлөвлөлтөөр улсын хэмжээнд шилжих болон шинээр нийт 117 сургуулийн барилга, барилгын өргөтгөлийн ажилд зориулан 175.5 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

2018 онд **15** сургууль ашиглалтад орсон

2019 онд **117** сургууль санхүүжүүлнэ

6.2.3. Сургуулийн дотуур байр

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг хангах" зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр шилжих болон шинэ нийт 34 сургуулийн дотуур байрын барилгын ажилд зориулан 27.8 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

2018 онд **6** дотуур байр ашиглалтанд орсон



2019 онд **34** дотуур байр санхүүжүүлнэ

6.2.4. Сургуулийн өмнөх боловсрол

Урьдчилсан тооцооллоор энэ 2018-2019 оны хичээлийн жилд нийслэлийн цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 77,6% нь цэцэрлэгт хамрагдсан, 39,000 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.

"Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийн хүрээнд 2019 онд нийт 143 цэцэрлэгийн шилжих болон шинэ барилга, барилгын өргөтгөлийн ажилд зориулж 144.4 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

2018 онд **23** цэцэрлэг ашиглалтад орсон

2019 онд **143** цэцэрлэг санхүүжүүлнэ

6.2.5. Анхан шатлалын эмнэлэг

Хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулах зорилтын хүрээнд 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд шилжих болон шинэ нийт 62 анхан шатлалын эмнэлгийн барилга, барилгын өргөтгөлийн ажилд зориулан 67.7 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

2018 онд **12** эмнэлэг ашиглалтанд орсон

2019 онд **62** эмнэлэг санхүүжүүлнэ

6.2.6. Гаалийн шинэчлэл

Монгол Улсын экспортын эрдэс баялаг, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг цогцоор нь шийдвэрлэх, гаалийн шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдэд зориулан 74.6 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

6.2.7. Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн санхүүжилт нь харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусгагддаг. Улмаар тухайн төслийн хэрэгжилтээс хамааран зарим төслийн санхүүжилт батлагдсан төсөвт багтахгүй, харин зарим төслийн санхүүжилт бүрэн ашиглагдахгүй байх тохиолдол нэлээдгүй гарч, хөгжлийн түнш олон улсын байгууллага, орнуудаас гомдол, саналууд ирүүлж байсан. Иймд 2019 онд гадаад зээл, тусламжийн санхүүжилт болон гэрээ, хэлэлцээрийн дагуу Засгийн газрын хариуцах санхүүжилтийн зардлыг Сангийн сайдын багцад суулгаж, санхүүжилтийг уян хатан, шуурхай шийдвэрлэх, төсвийг үр ашигтай ашиглах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр зээл, тусламжийн төслүүдийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлага зохион байгуулалтад өөрчлөлт орохгүй, тухайн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төслийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих чиг үүрэг хэвээр байж, зөвхөн төслийн санхүүжилт нь Сангийн сайдын багц дотор зардлаар бүртгэгдэнэ. Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний Монгол талын хөрөнгө оруулалтад нийт 65.3 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн.

6.2.8. Концессын төсөл, арга хэмжээ

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар төрийн өмчийн концессын жагсаалтад тусгагдсан “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа концессын гэрээнүүдээс барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад орсон, шилжих болон шинэ 12 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд нийт 144.7 тэрбум төгрөгийг тусгасан.

7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Улсын төсвөөс орон нутгийн хөрөнгө оруулалтад 2019 онд 189 тэрбум төгрөг тусгав. Төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2018 оноос эхлэн анх удаа аймгуудад Улсын төсвөөс хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хуваарилсан бөгөөд 2018 онд нийт 59 тэрбум төгрөгийг аймгуудад хуваарилсан бол 2019 онд 189 тэрбум төгрөгийг хуваарилахаар төсвийн төсөлд тусгалаа.

График № 23: Улсын төсвөөс орон нутагт хуваарилсан хөрөнгө оруулалтын дүнг 2018-2019 оноор харуулав.



.

Орон нутагт шинээр 33 тэрбум төгрөгийн эх үүсвэр хуваарилж байна. Мөн 2019 онд ашигт малтмалын хайгуулын лицензийн төлбөрийн 50 хувь, түүхийн нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь, газрын тосны лицензийн төлбөрийн 30 хувь болох нийт 33 тэрбум төгрөгийг орон нутагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор орон нутгийн төсөвт шинээр хуваарилж байна.

График №24.ОН-ын төсөвт шинээр хуваарилж буй шинэ хөрөнгө оруулалт



Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр тогтмол буурч ирсэн бөгөөд 2017 онд хамгийн бага түвшинд буюу 53 тэрбум төгрөгт хүрээд байсан бол 2018 онд 68 хувиар нэмэгдүүлж 89 тэрбум төгрөг, 2019 онд 2018 оноос 62 хувиар нэмэгдүүлж 144 тэрбум төгрөгт хүрэхээр байна.



Орон нутгийн нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэр. Орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр 2019 онд 681 тэрбум төгрөг болж 2018 оноос 276 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Үүнд:

- Улсын төсвөөс аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ 55 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 144 тэрбум төгрөг;
- 21 аймгийн орон нутгийн төсвийн суурь зардалд олгох хөрөнгө оруулалтын хэмжээ 130 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 189 тэрбум төгрөг;
- Орон нутгийн суурь орлого болон нийт орлогын зөрүү 33 тэрбумаар нэмэгдэж 115 тэрбум төгрөг;
- Үндсэн тэнцлийн ашгаас орон нутагт үлдэх хөрөнгө 56 тэрбумаар өсөж 204 тэрбум төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа.



8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

8.1. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагуудаас 1991-2017 онд нийт **4.3** тэрбум ам.долларын гадаад зээл, **2.6** тэрбум ам.долларын тусламжийг авч ашиглажээ. 2017 онд төсвийн дэмжлэгийн зориулалттай зээлийг оруулахгүйгээр төслийн зээлийн ашиглалт 752.1 тэрбум, тусламжийн ашиглалт 56.3 тэрбум төгрөг байсан. 2018 оны төсөвт гадаад төслийн зээлийн ашиглалт 835.9 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 110.0 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2019 онд нийт **1,371.5** тэрбум төгрөгийн зээл, тусламж авч ашиглахаар тооцлоо. Үүнээс 528.1 тэрбум төгрөг буюу 38.5 хувийг Азийн хөгжлийн банк, 328.6 тэрбум төгрөг буюу 24.0 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээл, тусламж эзэлж байна.

Хүснэгт № 23. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2019 оны ашиглалт (тэрбум төгрөг)

Хөгжлийн түнш	Зээл ашиглалт	Тусламж ашиглалт	Нийт дүн
АХБ	495.5	32.6	528.1
Хятад	279.4	49.2	328.6
Япон	125.8	18.8	144.6
Дэлхийн банк	106.5	10.6	117.1
БНСУ	58.7	0.5	59.2
Энэтхэг	52.0	-	52.0
Польш	36.4	-	36.4
Австри	27.1	-	27.1
Герман	22.3	12.0	34.3
Кувейт	-	18.7	18.7
Люксенбург	-	0.5	0.5
Бельги	6.4	-	6.4
ХААХОУС	5.4	-	5.4
Беларус	3.5	-	3.5
Унгар	3.0	-	3.0
ЕСБХБ	2.0	0.5	2.5
НҮБ	-	1.9	1.9
Франц	1.5	-	1.5
ШХА	-	0.7	0.7
Нийт дүн	1,225.5	146.0	1,371.5

Эх үүсвэр: Сангийн яам

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2019 оны ашиглалтын 177.6 тэрбум төгрөг буюу 13.0 хувь нь төслийн нэгж болон зөвлөх үйлчилгээний зардалд, 1,072.9 тэрбум төгрөг буюу 78.2 хувь нь хөрөнгө оруулалтын зардалд, 121.0 тэрбум төгрөг буюу 8.8 хувь нь орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ дэмжих зорилгоор дамжуулан зээлдүүлэхэд зарцуулагдана.

8.2. Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим

Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тооцохдоо ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд тохирсон төсвийн алдагдлын хэмжээг харгалзах, шинээр эхлэх төслүүдийн хувьд зээлийн ерөнхий хэлэлцээр хийгдсэн, 2018 онд тусгайлсан зээлийн хэлэлцээрийг хийж эх үүсвэрийг баталгаажуулах боломжтой, нийгэм, эдийн засгийн үр ашигтай төслүүд байх, үргэлжилж буй төслүүдийн хувьд хэрэгжилтийн явцыг харгалзан сайн хэрэгжиж буй үр ашигтай төслүүдийг дэмжих, нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийн санхүүжилтийг түлхүү суулгах, 2017 болон 2018 онд дуусах ёстой боловч дуусаагүй, 2019 онд дуусах төлөвлөгөөтэй төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгах зарчим баримталсан.

8.3. Гадаад зээл, тусламжийн төслүүдийг санхүүжүүлэхэд тулгарч буй асуудал, түүний шийдэл

Гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилт нь төслийн бэлтгэл ажил, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт удаашрах, худалдан авалтын үйл ажиллагаанд маргаан гарах, зураг төслийг экспертизээр батлуулах, төрөл бүрийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авахад цаг алдах, төслийн онцлог, нарийн түвэгтэй байдал, тухайн гадаад түншийн

дотоод процедур, хоёр талын төрийн байгууллагын дотоод журмын дагуу гэрээ, хэлэлцээр байгуулж, хүчин төгөлдөр болсон хугацаа болон бодит барилгын улирлын уялдаа, мөн бусад олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байдаг. Дээрх шалтгаанаар 2018 онд зарим төслийн хэрэгжилт, гүйцэтгэл сайн, ашиглалт нь төсөвт тусгасан зардлын хязгаартаа хүрснээр санхүүжилт гаргах боломжгүй болсон байхад зарим төслийн хувьд хэрэгжилт хангалтгүй, батлагдсан зардлынхаа хязгаарт хүргэхгүй эх үүсвэрээ ашиглаж чадахгүй тохиолдлууд байсан. Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн багц дотор төсөл хооронд хэрэгжилтийн явц, гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлыг дахин хуваарилах замаар зохицуулалт хийж байгаа ч төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн тодотгол хийхгүйгээр зардал дахин хуваарилах боломжгүйтэй холбоотой хүндрэл, бэрхшээл маш их гарч, хөгжлийн түнш олон улсын байгууллага, улс орнуудаас гомдол, саналууд ирүүлж байсан.

2019 онд гадаад зээл, тусламжийн санхүүжилт болон гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын хариуцах санхүүжилтийн зардлыг нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад буюу Сангийн сайдын багцад суулгаж, улмаар санхүүжилтийг уян хатан, шуурхай шийдвэрлэх, төсвийг үр ашигтай ашиглах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр зээл, тусламжийн төслүүдийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлага зохион байгуулалтад өөрчлөлт орохгүй, тухайн төслийг хэрэгжүүлэгч яам, байгууллагын төслийн төлөвлөлт, худалдан авалт, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих чиг үүрэг хэвээр байж, зөвхөн төслийн санхүүжилт нь Сангийн сайдын багц дотор зардлаар бүртгэгдэнэ.

8.4. 2019 онд гадаадын зээл, тусламжийг нийгэм, эдийн засгийн үр ашигтай төслүүдэд дараах чиглэлээр ашиглана:

Гадаадын хөнгөлөлттэй зээлийн 111 эх үүсвэрийн хөрөнгөөр 91 төсөл, тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөр 41 төслийг:

- байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих,
- сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах,
- нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх,
- нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах болон
- бусад чиглэлээр санхүүжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр гадаад зээлийн хөрөнгөөр 254.46 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 34.69 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн **21**%-ийг эзэлж байгаа бөгөөд 2019 онд гадаад зээлийн 3, буцалтгүй тусламжийн 3 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 9, буцалтгүй тусламжийн 5 төсөл хэрэгжиж эхэлнэ.

Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх төслийг АНУ-ын Мянганы сорилтын сантай байгуулсан 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хоёр дахь компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж эхэлнэ. Төслийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг газрын доорх усны эх үүсвэрээс байгаль орчинд нөлөөлөхгүйгээр урт хугацаанд, тогтвортой байдлаар нэмэгдүүлэх, унд-ахуйн зорилгоор

ашиглахын тулд дэвшилтэт технологитой ус цэвэршүүлэх үйлдвэр барих, шинээр байгуулсан эх үүсвэрүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох шугам хоолой тавих, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлж дулааны цахилгаан станцуудын техникийн усны зориулалтаар эргүүлэн ашиглаж цэвэр усыг хэмнэх зэрэг бүтээн байгуулалт хийнэ.

Байгаль орчныг хамгаалах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2018-2021 оны хугацаанд Улаанбаатар хотод хоногт 250,000 м^3 бохир усыг цэвэрлэх хүчин чадал бүхий төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийг хэрэгжүүлж эхлэхээс гадна Баян-Өлгий аймгийн Өлгий, Говьсүмбэр аймгийн Чойр, Дорнод аймгийн Чойбалсан, Увс аймгийн Улаангом, Завхан аймгийн Улиастай сумдад цэвэрлэх байгууламж шинээр барих, өргөтгөл хийх ажлыг Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн амын өсөлт, барилгажилтын үр дүнд их хэмжээгээр үүсэж буй барилга болон барилга нураалтын хатуу хог хаягдлыг зөв зохистойгоор булж устгах, дахин боловсруулах үйлдвэрийг Улаанбаатар, Эрдэнэт хотуудад Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламж, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барина.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын дахин төлөвлөлтийг дэмжиж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн “1008 айлын түр суурьшуулах орон сууц” төслөөр түрээсийн болон түр суурьшуулах орон сууцны хорооллыг барих ажлыг эхлүүлэх, мөн “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2019 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд орон сууцны хорооллуудыг шинээр барих төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр 2019 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 173.95 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 53.33 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн **17**%-ийг эзэлж байгаа бөгөөд 2019 онд гадаад зээлийн 9 төсөл, буцалтгүй тусламжийн 4 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн хөрөнгөөр 3 төсөл хэрэгжиж эхэлнэ.

Азийн хөгжлийн банкны 50.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2018-2021 онд Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан суманд нийт 2 шинэ сургууль, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Дорноговь аймгийн Сайншанд сумдад нийт 8 шинэ цэцэрлэг барих, Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх дүүрэг, Говь-Алтай аймгийн Алтай суманд 8 сургуулийн өргөтгөл, Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт 16 цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ. Эдгээр ажлын үр дүнд сургуулийн 4,500, цэцэрлэгийн 5,500 хүүхдийн орон тоо нэмэгдэнэ.

Япон Улсын 2.4 тэрбум иенийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2021 онд ерөнхий боловсролын сургууль барих төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд шинэ сургууль барих, Баянзүрх дүүргийн 53 дугаар сургууль болон Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 300.0 сая юанийн ерөнхий боловсролын сургууль барих буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2020 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд нийт 5,720 хүүхдийн багтаамжтай 7 сургууль, Архангай аймгийн Цэцэрлэг суманд 120 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийг шинээр барих ажлыг эхлүүлнэ.

Эрүүл мэндийн чанар, үйлчилгээг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2013-2020 онд "Эрүүл мэндийн салбарын хөгжил 4-нэмэлт санхүүжилт" төслийн хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр Сонгинохайрхан дүүрэгт эрүүл мэндийн олон мэргэжлийн тусламжийг нэг цэгээс 157,000 оршин суугчдад үзүүлэх, 200 ортой амбулаторид хэвтүүлэн эмчлүүлэх хэсэгтэй жишиг нэгдсэн эмнэлэг байгуулна. Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны 18.2 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангаж, мэс засал, эхийн эрүүл мэндийн үйлчилгээг нэмж, сувилгааны загвар тусламж, үйлчилгээ, эмнэлгийн хог хаягдлын боловсруулалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг боловсронгуй болгоно.

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн 8.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2017-2019 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт түлэгдэлт, хөлдөлт, нөхөн сэргээх мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх, олон улсын чанар стандартад бүрэн нийцсэн, орчин үеийн оношилгоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон, 250 ортой Түлэнхийн төвийн барилгын цогцолбор барина.

Бүгд Найрамдах Солонгос Улсын 55.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2013-2019 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн 103 ортой, 15,468 м^2 талбайтай Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг барьж, өндөр хүчин чадалтай, орчин үеийн дэвшилтэт 233 нэр төрлийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж хэрэгсэл нийлүүлнэ. Мөн Монгол Улсад анх удаа эмнэлгийн зориулалттай цөмийн шугаман хурдасгуур буюу изотопын бэсрэг үйлдвэрийг байгуулна.

Нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх чиглэлээр 2019 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 513.08 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 14.99 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн **39**%-ийг эзэлж байгаа бөгөөд 2019 онд гадаад зээлийн 11 төсөл, буцалтгүй тусламжийн 1 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 9, буцалтгүй тусламжийн 1 төсөл хэрэгжиж эхэлнэ. Тухайлбал, импортоос 100% хараат газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах, нефть-химийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр жилд 1.5 сая тн дотоодын түүхий газрын тос боловсруулах хүчин чадал бүхий "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт эхлүүлнэ.

Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Архангай, Дундговь, Хэнтий, Төв, Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын дулааны станц барих төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж эхлэх ба Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төслийг үргэлжлүүлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

Мөн Улаанбаатар-Мандалговь хооронд 249 км цахилгаан дамжуулах шугам барих төсөл,

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр, Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэл төслийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

Орон нутгийн хүн амын хэрэглээний усан хангамжийг сайжруулах зорилгоор Тайшир-Алтайн 49 км усан хангамжийн хоолой татах төслийг Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлнэ.

Дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд 2019 онд Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудал болон 32.2 км хурдны зам болон нийт 323.4 км авто замын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. Тухайлбал, Баянхонгор-Байдрагийн гүүр, Тосонцэнгэл-Улиастай, Баруун бүсийн босоо тэнхлэгийн чиглэлийн авто замын ажлуудыг дуусгаж ашиглалтад оруулна. Гачууртын уулзвараас Налайх чиглэлийн 20.9км авто зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэх, Дархан – Алтанбулаг, Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлыг тус тус 2019 онд хийж эхэлнэ.

Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр 2019 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 188.39 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 13.89 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн **15**%-ийг эзэлж байгаа бөгөөд 2019 онд гадаад зээлийн 2, буцалтгүй тусламжийн 2 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 5, буцалтгүй тусламжийн 3 төсөл хэрэгжиж эхэлнэ.

Тус чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 350.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2018-2020 онд Замын-Үүд, Гашуун сухайт боомтуудыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ. Ингэснээр хилийн боомтуудад төрийн албан хаагчид, иргэд ажиллаж амьдрах таатай, эрүүл, аюулгүй орчин бүрдэж, орчин үеийн техник технологийн дэвшил ашиглан гаалийн лабораторийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.

Азийн хөгжлийн банкны 40.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад хүнсний ногооны тариалалт, усалгаатай газар тариаланг дэмжих төслийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд услалтын системийг шинээр барих, төрийн болон орон нутгийн өмчийн услалтын системийг сэргээн засварлах, үйлдвэрлэлд шинэ нэр төрлийн тарималын технологи нэвтрүүлэх, өвлийн хүлэмж байгуулах, хөгжүүлэх, хүнсний ногооны агуулах, борлуулалтын сүлжээ, сав баглаа боодлын үйлдвэр барих, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах үйл ажиллагаа хийгдэнэ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 78.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2018-2021 онд Баянхонгор, Архангай, Сүхбаатар, Ховд аймгуудад малын гоц халдварт өвчингүй тусгаарласан аж ахуй болон хоногт 200 бод, 1000 бог мал төхөөрөх, мах ангилж савлах үйлдвэр бүхий цогцолбор байгууламжийг барих, технологийн шинэчлэл хийх төсөл хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд мал аж ахуйг эдийн засгийн эргэлтэд улирлын хамааралгүй тогтмол оруулах, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, малчдын орлогыг тогтвортой өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, татварын орлогыг бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр ашиг гарна.

Дэлхийн банкны 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2016-2021 онд уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготой “Экспортыг дэмжих төсөл” хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлснээр гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах экспортын даатгалын тогтолцоо бүрдэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжирч, гадаад зах зээлд

нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн нэмэгдэж экспортын зах зээл тэлэх боломж бүрдэнэ.

Бусад чиглэлээр 2019 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 95.54 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 29.1 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн **9**%-ийг эзэлж байгаа бөгөөд 2019 онд гадаад зээлийн 4, буцалтгүй тусламжийн 3 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 5, буцалтгүй тусламжийн 6 төсөл хэрэгжиж эхэлнэ.

Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 146.4 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хороонд 2016-2019 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв" төслийг хэрэгжүүлж дуусгана. Тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх амбулатори, эмчилгээний хэсэг болон хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй байх бөгөөд нийт барилгын талбайн хэмжээ 14,792 м^2, 250 өвчтөн хүлээн авах боломжтой юм. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 135.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр олон улсын шаардлагад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон спортын тамирчдад зориулсан 3500 хүний суудалтай тусгай тоноглол бүхий спортын төвийг Буянт-Ухаа спорт цогцолборын хажууд барина.

Азийн хөгжлийн банкны 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2017-2020 онд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл" хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд хүрэх үйлчилгээг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Архангай, Хөвсгөл, Ховд аймгуудад 7 жишиг хөгжлийн төвийг байгуулна. Төслийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй нийгмийн саад бэрхшээлийг бууруулна.

Гамшгаас хамгаалах, сэргийлэх чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газарт 2019 онд Бүгд Найрамдах Польш Улс болон Бүгд Найрамдах Беларус Улсын нийт 18.5 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр гал түймэр унтраах, аврах, эрэн хайх зориулалтын 85 автомашин, шуурхай удирдлагын штаб 1, явуулын эмнэлэг 1-ийг нийлүүлнэ.

9. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

9.1. Засгийн газрын өрийн удирдлага

Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу Сангийн яам нь "Засгийн газрын өр"[8]-ийн үлдэгдлийг улирал тутам тооцон гаргаж, олон нийтэд мэдээлж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 22.7 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 74.4 хувьд хүрсэн бол 2018 оны II улирлын байдлаар 21.1 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр хүлээгдэж буй ДНБ-ний 58.9 хувьд хүрч эрс буураад байна. Засгийн газар 2018 онд дотоод үнэт цаас гаргаагүй бөгөөд Чингис, Дим сам бондуудын өрийг бүрэн төлж барагдуулсан нь Засгийн газрын өр буурахад голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын өр 2019 онд өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 55.3 хувьд хүрч, хүүгийн зардал 285.1 тэрбум төгрөгөөр буурна.

Хүснэгт № 24. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2017.12.31	2018.03.31	2018.06.30
I. Засгийн газрын дотоод өр	**4,230.1**	**3,296.4**	**2,712.5**
1.1 Үнэт цаас	3,461.9	2,706.0	2,112.5
1.2 Концесс	768.2	590.4	600.0
II. Засгийн газрын гадаад өр	**16,857.8**	**16,636.7**	**16,810.7**
2.1 Үнэт цаас	**7,701.6**	**7,288.2**	**7,142.2**
Чингис 0.5	308.8	-	-
Чингис 1.0	2,427.1	2,392.8	2,462.8
ДимСам	354.2	349.2	-
Мазаалай	1,213.6	1,196.4	1,231.4
Хуралдай	1,456.3	1,435.7	1,477.7
Гэрэгэ	1,941.7	1,914.2	1,970.3
2.2 Зээл	**9,156.2**	**9,348.5**	**9,668.5**
Хөнгөлөлттэй зээл	8,573.7	8,773.6	9,077.5
Арилжааны зээл	582.51	575.0	591.1
III. Засгийн газрын өрийн баталгаа	**1,663.7**	**1,549.6**	**1,560.1**
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	1,663.7	1,549.6	1,560.1
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	**22,751.6**	**21,482.7**	**21,083.4**
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	20,212.1	18,825.0	18,021.4
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	**85.0%**	**80.0%**	**80.0%**
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	**74.4%**	**61.5%**	**58.9%**

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг тухайн жилийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан харьцаа[9] 2018 онд 63.4 хувь, 2019 онд 55.3 хувь, 2020 онд 47.8 хувь, 2021 онд 41.0 хувьд тус тус хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан

[8] Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д "Засгийн газрын өр" гэж I) өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, II) хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг гэж заасан.

[9] Тус харьцаа нь Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөлөлд тусч батлагдсан болно.

Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангахаар байна.

График № 25. Төсвийн тусгай шаардлагын төсөөлөл



Засгийн газрын зүгээс төсөв санхүү, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг тууштай хэрэгжүүлэх замаар өрийн тогтвортой байдлыг бүрдүүлж, дунд хугацаанд өрийн үйлчилгээний зардлыг бууруулах, төсөвт учруулах ачааллыг жигдлэх бодлогыг барьж байна.

Үүний хүрээнд өндөр хүүтэй богино хугацаатай дотоод үнэт цаас гаргалтыг 2017 оны 10 дугаар сараас зогсоож, өмнө арилжаалсан ЗГҮЦ-ыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах арга хэмжээг авсан бөгөөд зөвхөн хүү багатай гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөлд түлхүү ашиглаж байна.

Засгийн газар 2018 оны 1 дүгээр сард Чингис бондын үлдэгдэл 127.2 сая ам.доллар, 2018 оны 6 дугаар сард Дим сам бондын үлдэгдэл 145.9 сая ам.долларын төлбөрийг бүрэн төлж барагдуулсан бөгөөд гадаад болон дотоод зээллэгийн төлбөрт 2018 оны 8 дугаар сарын байдлаар 2,270.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 639.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр, нийт 2,910.4 тэрбум төгрөгийг төлөөд байна.

Засгийн газрын зээллэгийн хүүгийн төлбөрт 2018 оны батлагдсан төсвийн хүрээнд 1,150.7 тэрбум төгрөг төлөгдөхөөр байгаа бол 2019 оны хүүгийн зардлыг 285.1 тэрбум төгрөгөөр бууруулж, 865.6 тэрбум төгрөг төлөхөөр тооцоолоо.

Өөрөөр хэлбэл 2018 онд өрийн удирдлагын хүрээнд авсан бодлогын арга хэмжээний үр дүнд Засгийн газрын өрийн гадаад, дотоод хүүгийн зардлыг 2016-2018 оны түвшнээс бууруулж төсөвт ирэх дарамтыг багасгасан.

График № 26. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/



Засгийн газар 2018 онд гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 1,708.1 тэрбум төгрөг, хөнгөлөлттэй гадаад зээлийн үндсэн төлбөрт 213.5 тэрбум төгрөг, арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн үндсэн төлбөрт 60.0 тэрбум төгрөг, нийт 2.6 их наяд төгрөгийн үндсэн төлбөрийг төлж барагдуулж байгаа бол 2019 онд Засгийн газрын он дамжсан урт хугацаат дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 222.1 тэрбум төгрөг, гадаад хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрт 310.4 тэрбум төгрөг, арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн үндсэн төлбөрт 541.4 тэрбум төгрөг, нийт 1.1 их наяд төгрөгийн үндсэн төлбөрийг төлөхөөр төлөвлөв.

График № 27. Үндсэн төлбөр /тэрбум төгрөг/



Засгийн газраас өрийн удирдлагын чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Өндөр хүүтэй ЗГҮЦ гаргалтыг хязгаарлах бодлогыг баримтална. Засгийн газрын дотоод үнэт цаасны бөөний арилжаанд арилжааны банкууд хүүгээр өрсөлдөн оролцдог бөгөөд хүүгийн түвшин 2014 оноос эрчимтэй нэмэгдэж 2017 онд 16-18 хувьд хүрсэн. 2012-2017 онд явагдсан нийт арилжааны 84.4 хувийг богино хугацаат үнэт цаас эзэлж, эргэн төлөлт нь төсөв болон төрийн сангийн мөнгөн хөрөнгөд дарамт үүсгэж байсан тул Засгийн газрын зүгээс өндөр хүүтэй, богино хугацаатай дотоод үнэт цаас арилжаалахыг зогсоож, 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсан. 2018 онд Засгийн газрын үнэт цаас гаргаагүй бөгөөд 1,708.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 435.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг төлж Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2018 оны жилийн эцэст 1.6 их наяд төгрөгт хүрч буурахаар байна.

График № 28. Дотоод үнэт цаасны үлдэгдэл

Өндөр хүүтэй Засгийн газрын үнэт цаас гаргалтыг хязгаарлаж, Засгийн газрын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, төсвийн улирлын шинж чанартай дутагдлыг санхүүжүүлэх чиглэлээр ЗГҮЦ арилжаалах шаардлагатай тохиолдолд олон нийтэд ил тод, нээлттэй зарчмыг баримтална.

Төсөв, санхүү, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг тууштай хэрэгжүүлнэ. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэх замаар өрийн тогтвортой байдлыг хангаж, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцааг ирэх жилүүдэд үе шаттай бууруулна. 2019 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 66.0 хувь, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 55.3 хувьд тус тус хүрэхээр байна.

Өрийн зохицуулалтын арга хэмжээг авна. Хуваарийн дагуу 2021 онд 500.0 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 онд 1.0 тэрбум ам.долларын Чингис бонд, 2023 онд 600.0 сая ам.долларын Хуралдай бонд, 2024 онд 800.0 сая ам.долларын Гэрэгэ бондын төлбөр төлөгдөхөөр байгаа нь төсөв болон гадаад валютын нөөцөд томоохон дарамтыг үүсгэхээр байна. Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй 2020-2024 онуудад төлөгдөх өндөр хүүтэй гадаад зээллэгийг зах зээлийн тохиромжтой нөхцөлд төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах боломжийг эрэлхийлнэ.

Өрийн баталгаа нэмж гаргахгүй. Засгийн газраас 2013-2016 онд гаргасан өрийн баталгааны үлдэгдэл 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,133.5 сая ам.доллар байгаа бөгөөд үүнээс Худалдаа Хөгжлийн банкны 500.0 сая ам.долларын бондод Засгийн газрын дотоод үнэт цаас барьцаалан баталгаа гаргасан. Засгийн газрын зүгээс баталгаанаас үүсэх болзошгүй өр төлбөрийг багасгах, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах зорилгын хүрээнд өрийн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд үүссэн баталгаанд тавих хяналтыг сайжруулна.

“Барих-шилжүүлэх” концессын гэрээг шинээр байгуулахгүй. Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолоор “барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулж улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр

үүсгэхийг хориглосон. “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүд Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд дарамт үүсгэж байгаа тул шинээр барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй. Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний гүйцэтгэлд тулгуурлан 2018 оны хагас жилийн байдлаар 600.0 тэрбум төгрөгийг Засгийн газрын өрд бүртгэсэн. Үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 1.7 их наяд төгрөгийн дүнтэй 22 гэрээний дагуу гүйцэтгэсэн концесийн төлбөрийн өр 587.6 тэрбум төгрөг байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 61.2 тэрбум төгрөгийн дүнтэй 13 гэрээний гүйцэтгэлээр 12.4 тэрбум төгрөгийн өрийг бүртгээд байна.

Хөнгөлөлттэй зээлийг дэд бүтэц, бүтээн байгуулалтын чиглэлд түлхүү ашиглана. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2019 онд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл, Гацууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүд хэрэгжинэ.

9.2. Болзошгүй Өр Төлбөр

Засгийн газрын баталгаа нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрөөр бүртгэгддэг.

Засгийн газрын өрийн баталгаа тус бүрээр авч үзвэл:

1. Самурай бонд - Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банк 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй, 30.0 тэрбум иенийн “Самурай” бондыг арилжаалсан. Гэрээний дагуу эргэн төлөгдөх хугацаа 2023 он бөгөөд 2019 онд 456.0 сая иенийн хүүгийн төлбөр төлөгдөнө.

2. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл - Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 162.0 сая ам.долларын зээлийн гэрээнд Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн хугацаа 8 жил, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил, 2017-2022 онуудад төлөгдөх хуваарьтай. 2019 онд 27.0 сая ам.долларын үндсэн төлбөр, 6.2 сая ам.долларын хүүгийн төлбөр төлөгдөнө.

3. Кредит свисс банкны зээл - Засгийн газрын 2014 оны 117 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны Кредит свисс банкнаас 5 жилийн хугацаатай, 300.0 сая ам.долларын зээлд Засгийн газрын баталгаа гаргасан. Гэрээний дагуу 2019 онд 129.6 сая ам.долларын үндсэн төлбөр, 6.0 сая ам.долларын хүүгийн төлбөр төлөгдөнө.

4. Боинг агаарын хөлөг худалдан авах төсөл -Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолын дагуу МИАТ /ТӨХК/-ийн Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авахад зориулан 121.4 сая ам.долларын 3 дэд хэсгээс бүрдэх баталгааг гаргасан. Үүнд: АНУ-ын Экспорт-Импорт банкнаас 77.4 сая ам.долларын дүнтэй, 10 жилийн хугацаатай зээл, ING CAPITAL LLC банкнаас 23.9 сая ам.долларын дүнтэй, 7 жилийн хугацаатай зээл, ING CAPITAL LLC банкнаас 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын зээл авсан. Гэрээнд заасан хуваарийн дагуу 2019 онд 11.6 сая ам.долларын үндсэн төлбөр, 1.1 сая ам.долларын хүүгийн төлбөр төлөгдөнө.

5. “Эрдэнэс Монгол” ХХК-ны АХБ-наас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл - Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор нийт 42.0 сая ам.долларын санхүүжилттэй төслийн зээлийн 85 хувьд

буюу АХБ-ны 15 жилийн хугацаатай 35.0 сая ам.долларын хөнгөлөлттэй, техник туслалцааны зээлд Засгийн газрын баталгаа гаргасан. Эргэн төлөлт 2019-2031 оны хооронд төлөгдөх хуваарьтай. 2019 онд 0.04 сая ам.долларын үндсэн төлбөр, 0.2 сая ам.долларын хүүгийн төлбөр төлөгдөнө. Эрдэнэс Монгол ХХК нь 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 35.0 ам.долларын зээлээс 7.7 сая ам.долларыг ашигласан байна.

6. Худалдаа Хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бонд – Засгийн газрын 2015 оны 163 дугаар тогтоолын дагуу ХХБ-ны олон улсын зах зээлд гаргасан 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын 9.375 хувийн хүүтэй бондод баталгаа гаргасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг “Засгийн газрын өрийн хязгаар”-т оруулахгүйгээр заасан тул тус баталгаа нь өрийн хязгаарын тооцоонд ордоггүй болно. Хуваарийн дагуу 2019 онд 23.4 сая ам.долларын хүүгийн төлбөр төлөгдөнө.

Товчилсон үгс

ОУВС-	Олон Улсын Валютын Сан
БНХАУ-	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
АНУ-	Америкийн Нэгдсэн Улс
БНЭУ-	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ГШХО-	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ИТХ-	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ-	Мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ЭМД-	Эрүүл мэндийн даатгал
ЗГҮЦ-	Засгийн газрын үнэт цаас
ДНБ-	Дотоодын нийт бүтээгдэхүүн
УБТЗ-	Улаанбаатар төмөр зам
БҮ-	Бараа үйлчилгээ
БСШУСЯ-	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ТАЗ-	Төрийн албаны зөвлөл
УХТЭ-	Улсын Хоёрдугаар төв эмнэлэг
АА-	Аж ахуй
ҮОМШӨ-	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин
НДШ-	Нийгмийн даатгалын шимтгэл
НДС-	Нийгмийн даатгалын сан
НӨАТ-	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЖДҮХС-	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ОН-	Орон нутаг
ХААХОУС-	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ШХА-	Швейцарын Хөгжлийн Агентлаг
ЕСБХБ-	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ХЧТА-	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
Ж.А-	Жирэмсэн болон амаржсан

Графикууд

График № 1. Эдийн засгийн өсөлт 4
График № 2. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар ... 5
График № 3. Гадаад худалдаа, 2019-2020 оны төсөөлөл, тэрбум ам.доллар 6
График № 4. Төлбөрийн тэнцэл, эхний хагас жилийн байдлаар, сая ам.доллар 6
График № 5. Төлбөрийн тэнцэл, 2019-2021 оны төсөөлөл, сая ам.доллар 7
График № 6. Хөгжиж буй орнуудын ханшийн хөдөлгөөн 7
График № 7. Инфляцын түвшин /өмнөх оны мөн үеэс/ 8
График № 8. Нэгдсэн төсвийн алдагдал 2012-2021 оноор 18
График № 9. Нийт орлого ба тусламжийн дүн 20
График № 10. Уул уурхайн салбарын орлого 21
График № 11. Эдийн засаг дахь татварын ачаалал 21
График № 12. Нэг хүнд ногдох ДНБ ба эдийн засаг дахь татварын ачаалал, улсаар 22
График № 13. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого болон өсөлт /уул уурхай, уул уурхайн бус салбараар/ 22
График № 14. Төгрөгийн болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүү, хувь 22
График № 15 . Эдийн засгийн бодит өсөлт, салбараар 23
График № 16. Хувь хүний орлогын албан татвар, тэрбум төгрөг 23
График № 17. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого 23
График № 18. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг 24
График № 19. Зэсийн баяжмалын экспорт 25
График № 20. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ 26
График № 21 .Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг 39
График № 22. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ /төгрөгөөр.. 39
График № 23: Улсын төсвөөс орон нутагт хуваарилсан хөрөнгө оруулалтын дүнг 2018-2019 оноор харуулав. 49
График №24.ОН-ын төсөвт шинээр хуваарилж буй шинэ хөрөнгө оруулалт 49
График № 25. Төсвийн тусгай шаардлагын төсөөлөл 58
График № 26. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/ 58
График № 27. Үндсэн төлбөр /тэрбум төгрөг/ 58
График № 28. Дотоод үнэт цаасны үлдэгдэл 59

Хүснэгтүүд

Хүснэгт № 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт 3
Хүснэгт № 2. Импортын бүтээгдэхүүн, төрлөөр /2017 оны гүйцэтгэл, 2018 оны ХБГ/, сая ам.доллар 6
Хүснэгт № 3. Нэгдсэн төсвийн нийт орлого 20
Хүснэгт № 4. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө 21
Хүснэгт № 5. Импортын голлох бүтээгдэхүүнүүд 24
Хүснэгт № 6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ, хувь 27
Хүснэгт № 7. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар, их наяд төгрөг/ 28
Хүснэгт № 8. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/ 28
Хүснэгт № 9. Тэтгэвэр, тэтгэмжийн зардлын өсөлт /тэрбум төгрөгөөр/ 29
Хүснэгт № 10. Хүүхдийн тооны өсөлтөөс нэмэгдэх урсгал зардал /тэрбум төгрөгөөр/ 31
Хүснэгт № 11. Тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгийн өөрчлөлт 34
Хүснэгт № 12. Орон тооны өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг/ 35
Хүснэгт № 13. Дотоод албан томилолтын тарифын өөрчлөлт /мян.төг/ 36
Хүснэгт № 14. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум.төг/ 37
Хүснэгт № 15 . Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/ 37
Хүснэгт № 16 . Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/ 38
Хүснэгт № 17. НДШ-ийн хувь хэмжээний өөрчлөлт 39
Хүснэгт № 18. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/ 40
Хүснэгт № 19. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол /мян хүн, тэрбум төгрөг/ 40
Хүснэгт № 20.Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мян хүн, тэрбум төгрөг/ 40
Хүснэгт № 21. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төг/ 41
Хүснэгт № 22. ЖДҮ-ийг дэмжих санхүүжилт /тэрбум төгрөг/ 44
Хүснэгт № 23. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2019 оны ашиглалт (тэрбум төгрөг) 51
Хүснэгт № 24. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/ 57

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1, 58.2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт:

“58.1.18. энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа нийслэлийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт ;”

2/ 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 19 дэх заалт:

“58.1.19. соёлын үйлчилгээ; ”

3/ 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:

“58.1.20. нийтийн биеийн тамир; ”

4/ 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 17 дахь заалт:

“58.2.17. энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа нийслэлийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт ;”

5/ 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 18 дахь заалт:

“58.2.18. соёлын үйлчилгээ; ”

6/ 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 19 дэх заалт:

“58.2.19. нийтийн биеийн тамир; ”

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь заалтын “58.1.14,” гэсний дараа “58.1.18, 58.1.19, 58.1.20” гэж, “58.2.13,” гэсний дараа “58.2.17, 58.2.18, 58.2.19” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“60.2.7. ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь;

4 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсгийн “2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.18 дахь заалтын дугаарлалтыг “58.1.21.” гэж, 58.2.17 дахь заалтын дугаарлалтыг “58.1.20” гэж тус тус өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар Улаанбаатар
сарын ... ны өдөр хот

ИРЭЭДҮЙН ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “2019 оны” гэснийг “2021 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар Улаанбаатар
сарын ... ны өдөр хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “2019 оны” гэснийг “2021 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар Улаанбаатар
сарын ... ны өдөр хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.4.1, 40.4.2 дахь заалтын “улсын төсөв,” гэсний дараа “орон нутгийн төсөв,” гэж, 40.4.4 дэх хэсгийн “ дээд сургууль” гэсний дараа “коллеж, техникийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“40.2.Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар Улаанбаатар
сарын ... ны өдөр хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын төсвийн болон” гэсний дараа “орон нутгийн төсвийн хөрөнгө,” гэж, 2 дахь хэсгийн “улсын” гэсний дараа “болон орон нутгийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны .... дугаар Улаанбаатар
сарын ... ны өдөр хот

Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тухай

1 дүгээр зүйл. **“**Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 1 дүгээр хэсгийн 4, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны .. дугаар Улаанбаатар
сарын...-ны өдөр Дугаар ... хот

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.19 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын төсвөөс орон нутгийн төсөвт хуваарилагдаж байгаа хөрөнгө оруулалтын зардлаас нэн тэргүүнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөсүгэй:

1/ сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг, соёлын төв, спорт заалны их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэх;

2/ Аймаг, сумын төвийн шинэчлэл, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн төсөл арга хэмжээнд зарцуулах;

3/ орон нутгийн төсөвт байгууллагууд болон Засаг даргын тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж, албан хэрэгцээний автомашин худалдан авах;

Хоёр. Орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс, газрын харилцаа, кадастрын байгууллагын байрлаж байгаа барилга байгууламжийн ашиглалтын тогтмол зардлыг орон нутагт хариуцуулж шаардагдах зардлыг улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлж байгаатай холбогдуулан орон нутгийн өмчийн арчлалт, хамгаалалтыг сайжруулах, байр ашиглалтын зардал хэмнэх боломжийг эрэлхийлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

Гурав. Орон нутаг дахь соёл, нийтийн биеийн тамирын чиг үүргийг хэрэгжүүлэх зардлыг улсын төсвөөс аймаг, нийслэлд бүрэн шилжүүлж байгааатай холбогдуулан орон нутгийн музей, номын сан, соёлын төв, театр, спорт залны ашиглалтыг сайжруулах, үр ашигтай, хэмнэлттэй ажиллах;

Дөрөв. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг өрх, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, устгахад бүрэн зарцуулахаар орон нутгийн суурь зарлагад тооцон шилжүүлж байгаатай холбогдуулан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тарифыг бодитой тогтоох, хот тохижилтын албыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллах нөхцөл боломжоор хангах;

Тав. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг 2019 оноос эхлэн тухайн хайгуулын талбай байршиж байгаа аймгийн орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс шилжүүлж байгаатай холбогдуулан шинэ хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмблэх замаар хөрөнгийг оновчтой үр дүнтэй төлөвлөж зарцуулах, гүйцэтгэлийн хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

Зургаа. Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь, газрын тосны тусгай зөвшөөрлийн орлогын 30 хувийг нүүрс болон газрын тос олборлож байгаа тухайн аймагт улсын төсвөөс шилжүүлж байгаа тул хуваарилсан хөрөнгийг агаарын бохирдолыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаанд үр дүнтэй зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Долоо. Орон нутгийн захиргааны байгууллагуудын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бичиг хэргийн зардлыг тухайн байгууллагын бодит хэрэгцээнд нь нийцүүлэн тооцож суурь зарлагад тусгаж байгаа тул төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг одоо байгаа түвшнээс нэмэгдүүлж ажиллахаар тооцон үр дүнгийн гэрээнд тусган хяналт тавьж ажиллах;

Найм. Баяр наадам тэмдэглэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, тусламж тэтгэмж олгох, албан томилолтоор ажиллах зэрэг урьдчилан төлөвлөх боломжтой зардлуудыг төсөвтөө тусгаж батлах, цаашид ийм төрлийн зардлуудыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхгүй байх, төсвийн сахилга батыг чанд баримтлан ажиллах;

Ес. Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх зорилгоор байнгын давтамжтай олгогддог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг улсын төсвөөс нэгдсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөж шаардагдах хөрөнгийг төвлөрүүлж байгаатай холбогдуулан халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өр үүсгэхгүй ажиллах;

Арав. Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулж, байр ашиглалтын зардлын бүртгэл хяналтыг сайжруулах зорилгоор сумдын санхүүгийн албанаас ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, сумын эмнэлэгт нягтлан бодогч нарыг шилжүүлж байгаатай холбогдуулан сумын санхүүгийн албаны ажлын ачаалал, уялдаа холбоог дахин нягталж орон тоо, чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүй байхаар зохион байгуулж ажиллах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийн талаар

Засгийн газраас 2019 онд хэрэгжүүлэх төсвийн бодлогын хүрээнд төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр зарим зохицуулалтыг хийхээр төлөвлөж үр дүнг нь Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд тусгаад байна.

А. Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутагт хариуцуулна.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүүхэд хамгаалал болон газрын харилцаа гэсэн чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн засаг дарга нар байдаг бөгөөд орон нутгийн засаг захиргаа эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс шилжүүлэн авч захиран зарцуулдаг. Сургууль, цэцэрлэг, сумын эмнэлгийн барилга байгууламж нь тухайн аймаг, нийслэл, орон нутгийн өмч байдаг боловч улсын хэмжээнд нийт 925 цэцэрлэг, 696 сургууль, 289 сум, тосгоны эмнэлгийн ашиглалтын зардлыг төвлөрсөн байдлаар БСШУСЯ болон ЭМЯ-ны төсөвт тусган төлөвлөж байгаа нь оновчгүй, үр ашиг, үр дүн муутай байна.

Энэ нь орон нутгийн засаг захиргааны зүгээс өөрийн өмч хөрөнгөө зөв зохистой, үр ашигтай удирдах, ашиглах, хамгаалах боломж, бүтээлч санаачилгыг төрүүлэхгүй байх, дээрээс хуваарилсан төсвийг хэмнэх хүсэлгүй байгаа нь үр ашиггүй хөрөнгө оруулалт, урсгал болон их засварын зардлыг сүүлийн жилүүдэд эрс нэмэгдүүлж байна.

Иймээс орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллага, газар зохион байгуулалтын албаны байр ашиглалтын зардал */халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түрээс, урсгал засвар үйлчилгээг/*-ыг орон нутагт хариуцуулан нийт 138.1 тэрбум төгрөгийн зардлыг тухайн орон нутгийн суурь зардалд улсын төсвөөс шилжүүлэхээр тооцоод байна. Ингэснээр орон нутгийн засаг захиргаа буюу өмчийн эзэн нь өмчийнхөө ашиглалтыг бүрэн хариуцдаг тогтолцоонд шилжиж өмчийн ашиглалт, хамгаалалт сайжрах, өр авлага үүсгэхгүй ажиллах давуу талтай юм.

Дээр дурдсан үндэслэлээр Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь заалтад орон нутгийн суурь зардлын бүрэлдэхүүнд нэмэлт оруулах, 58 дугаар зүйлийн 58.1, 58.2 дахь хэсэгт нийслэл болон аймгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нэмэлт оруулах зохицуулалт хийнэ. Түүнчлэн

Боловсролын тухай хуулийн 39, 40 дүгээр зүйлүүдэд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн байр ашиглалтын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зорилгоор холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулна.

Б. Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга дэргэдээ соёлын болон нийтийн биеийн тамирын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, санхүүжилтээ тусгай зориулалтын шилжүүлгээр авдаг. Ихэнх улс оронд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээс бусад соёл, спортын чиг үүргийг орон нутгийн засаг захиргаа бүрэн бие даан хэрэгжүүлж байна. Иймд орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал (тогтмол болон хувьсах)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, шаардагдах 40.5 тэрбум төгрөгийг орон нутгийн суурь зарлагад нэмж тусгахаар тооцсон Соёл, урлаг, спортын чиг үүргийг орон нутагт шилжүүлснээр тухайн орон нутгийн онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой, үр дүнтэй үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах боломж бүрдэнэ.

Дээрх үндэслэлээр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1, 58.2 дахь хэсэгт заасан аймаг, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт орон нутгийн соёл, нийтийн биеийн тамирыг нэмж оруулах ба мөн Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт соёлын чиг үүргийг улсын төсвөөс гадна орон нутгийн төсөв хариуцахаар тусгасан.

В. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 2019 оноос эхлэн орон нутагт шилжүүлнэ.

Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр тус салбарын нийгмийн хариуцлага нэмэгдэж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх шаардлага бий болохын зэрэгцээ уул уурхайн салбараас бий болсон орлогоос тухайн орон нутагт нь ахиу хөрөнгө хуваарилах шаардлага мөн бий болж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.7 дах заалтад “ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр”-ийн орлогыг Улсын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүнд тусгасан. Энэхүү эх үүсвэрийн 50 хувийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д заасны дагуу аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах хуулийн зохицуулалттай бөгөөд энэ нь 2020 оноос эхлэн мөрдөгдөнө.

Хуулийн хэрэгжилтийг нэг жилээр наашлуулж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувийг 2019 онд, үлдэх 50 хувийг 2020 онд буюу нийтдээ 100 хувь тухайн хайгуулын талбай оршиж байгаа орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалтыг хийнэ. Харин ашигт

малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг тухайн олборлолт явагдаж байгаа орон нутгийн төсөвт 2020 оноос эхлэн шилжүүлнэ.

Энэхүү зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д өөрчлөлт оруулах байдлаар хийх ба үүнтэй уялдуулан мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсгийг хүчингүй болгохоор тооцов .

Г. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсвийн хэрэгжилтийг хойшлуулна.

Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд тавигдсан шаардлагын дагуу Засгийн газрын өрийг бууруулж, Монголбанкны балансын алдагдлыг багасгах зорилгоор УИХ-аас 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр хойшлуулсан.

Засгийн газраас Олон Улсын Валютын Сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанкийг төсвийн шинж чанартай төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх үйл ажиллагаанаас бүрэн гаргах, ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэн авах үүргийг хүлээсэн. Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу одоо хэрэгжиж байгаа тогтолцооны хүрээнд үүссэн хуримтлагдсан алдагдлыг хүлээн зөвшөөрөхөөс сэргийлэн Монголбанкны эзэмшиж байгаа ипотекийн зээлээр баталгаажсан бондыг Монголбанкинд хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн. Монголбанкны эзэмшилд байгаа ипотекийн зээлээр баталгаажсан бондын үлдэгдэл 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2 их наяд 302.2 тэрбум төгрөг байгаа бол тус банкнаас банкуудад олгосон зээлийн үлдэгдэл 531.1 тэрбум төгрөг байна. Өөрөөр хэлбэл эдгээр хөрөнгийг Ирээдүйн тэтгэврийн нөөц санд шилжүүлсэнээр энэ хэмжээгээр Монголбанкны хуримтлагдсан алдагдлыг нэмэгдүүлэхээр байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор Ирээдүйн тэтгэврийн нөөц санд хөрөнгө шилжүүлэх Улсын Их Хурлын 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болгож, уг хөрөнгийг Монголбанкинд буцаан шилжүүлэхийг Засгийн газарт, өөрийн тайлан тэнцэлдээ бүртгэж авахыг Монголбанкинд тус тус даалгасан ба уг хөрөнгийг цаашид гадаад, дотоодын зах зээлд борлуулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газар, Монголбанкинд даалгасан.

Иймд Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн хуулийн хэрэгжилтийг 2 жилээр хойшлуулах ба энэ зорилгоор Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн 9.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 71.5 дахь хэсэг болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 34.1 дэх хэсэгт заасан хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Д. УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалтыг хүчигүй болгоно.

Засгийн газраас ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах зорилгоор “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2019 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолыг батлан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд төсвийн сахилга батыг чангатгах, эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг төсвийн оновчтой бодлого хэрэгжүүлсний үр дүнд төсвийн орлого нэмэгдэж, алдагдал, өрийн хэмжээ төлөвлөж байснаас хурдацтай буурч байна. Эдийн засагт өсөлт гарч, төсвийн үндсэн үзүүлэлт сайжирч байгаа тул олон улсын хөгжлийн түншлэгч байгууллагуудтай удаа дараа хэлцэл хийж тохирсны эцэст иргэдийн орлогын баталгааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно.

Иймд 2019 оны төсөвт цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг тусгаж байгаатай холбогдуулан УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дэх *хэсгийн “4/ төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх; 5/төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;”* гэснийг хүчингүй болгохоор тусгалаа.

Е. Бусад

Улсын хэмжээнд 85 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн 12, хувийн 3 буюу нийт 15 политехник коллеж, 70 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байна.

Төрийн өмчийн 12 политехник коллеж нь техникийн боловсролын сургалтыг сонгон суралцаж байгаа зөвхөн насанд хүрэгчдээс өнгөрсөн жилүүдэд 450,0-650,0 төгрөгийн сургалтын төлбөр авч өөрийн үйл ажиллагааны зарим орлогыг бүрдүүлж, сургалтын орчноо сайжруулах, багшийн мэргэжил дээшлүүлэлт, судалгаа шинжилгээ, инновацийн туршилт үйлдвэрлэлд зарцуулж, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд зарцуулдаг. Гэвч Боловсролын тухай хуульд энэхүү политехникийн коллеж өөрийн үйл ажиллагаагаар орлого бүрдүүлэхийг эрхийг нээж өгөөгүй байна.

Иймд политехник коллежид техникийн боловсролын сургалтаас сургалтын төлбөр авах эрхийг бий болгох зорилгоор Боловсролын тухай хуулийн 40.4.4-д зохих нэмэлтийг оруулахаар тусгалаа.

Түүнчлэн 2019 онд орон нутгийн төсөвт шилжүүлж байгаа орлого болон зарлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд чиглэл, зөвлөмж өгөх зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

--000--

3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Ц.НЯМДОРЖ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад "Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах" гэж тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах бөгөөд нийгмийн даатгалын сангийн зардлыг дараахь үндэслэлээр нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэж заасны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2019 онд нэмэгдүүлэхээр төлөвлөсөн;

2.Нийгмийн даатгалын сангуудаас олгох дундаж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ болон тэтгэмж авагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор сангуудын зардал нэмэгдсэн;

3.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолоор төрийн зарим албан тушаалын цалинг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардал нэмэгдсэн.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын

сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Нийгмийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид зарцуулах төсвийн эрх, хэмжээг, Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төслийг баталснаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2019 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

--- oOo ---

<u>ТӨСӨЛ</u>

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ...ны өдөр Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд**	**1,603,341.0**
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	656,723.2
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	591,200.3
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	185,249.1
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	91.9
	1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	97,172.6
	1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	2,968.2
	1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,303.8
	1.8 Бусад орлого	68,631.9
2	**Сангийн сайд**	**605,492.8**
	2.1 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	605,492.8
	Нийт орлого	**2,208,833.8**

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд**	**2,068,539.6**
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	1,859,862.1
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	114,154.6
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	32,881.4
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	36,802.3
	1.5 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	84.1
	1.6 Үйл ажиллагааны урсгал зардал	24,755.1
	Нийт зарлага	**2,068,539.6**

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат / нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 100,000.0 сая төгрөгөөр баталсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсөвт орлого 1,603.3 тэрбум төгрөг, зарлага 2,068.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Энэ нь 2018 онтой харьцуулахад орлого 301.9 тэрбум төгрөг, зарлага 260.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Хүснэгт № 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2017 Гүйц	2018 төсөв	2019 Төсөл
САНГУУДЫН ОРЛОГО	**1,544.0**	**1,301.4**	**1,603.3**
1 Шимтгэлийн орлого	1,432.2	1,240.9	1,534.7
2 Бусад орлого	111.8	60.5	68.6
САНГУУДЫН ЗАРЛАГА	**1,890.9**	**1,808.3**	**2,068.5**
1. Тэтгэврийн даатгалын сан	1,417.3	1,619.6	1,859.9
2. Тэтгэмжийн даатгалын сан	100.2	102.4	114.1
3. ҮОМШӨ-ний даатгалын сан	29.4	31.7	32.9
4. Ажилгүйдлийн даатгалын сан	34.6	35.4	36.8
5. Эрүүл мэндийн даатгалын сан	288.0	0.0	0.0
6. Бусад зарлага	0.2	0.1	0.01
7. Ажиллагааны зардал	21.4	19.0	24.7
Улсын төсвөөс олгох татаас	**570.2**	**609.8**	**605.5**

1. Нийгмийн даатгалын сангийн орлого

Ирэх 2019 онд 46.9 мянган аж ахуйн нэгж байгууллагын 878.8 мянга гаруй ажилтан албан журмын даатгалд хамрагдахаар байгаа нь 2018 оноос 21.4 мянган хүнээр нэмэгдэхээр байна. Харин албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 320.0 гаруй мянган иргэдийн 64.8 хувь буюу 207.2 орчим мянган хүн сайн дурын даатгалд хамрагдахаар тооцлоо.

Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалд хамрагдах даатгуулагчдын хүрээг нэмэгдүүлэх, боломжит бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар 2019 онд нийгмийн даатгалын санд төвлөрөх шимтгэлийн орлого 1,534.7 тэрбум төгрөг, хадгаламж болон үнэт цаасны хүүгийн орлого 68.6 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Харин цэргийн албан хаагчдын тэтгэвэр, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийг төр хариуцахаар заасан болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөн зорилгоор улсын төсвөөс 605.5 тэрбум төгрөг олгохоор тооцлоо.

УИХ-аар батлагдсан Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг аажмаар буюу 3 жилийн хугацаанд ажил олгогч болон даатгуулагч тус бүр 2.5 пунктээр, нийт 5.0 пунктээр нэмэгдүүлэхээр баталсантай холбоотойгоор тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 2019 онд 70.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Хүснэгт №2 . НДШ-ийн хувь хэмжээний өөрчлөлт

Үзүүлэлт	Одоо мөрдөгдөж байгаа хувь хэмжээ			2019 он +1.0%			Нэмэгдэх хувь /тухайн жилд/
	Даатгуу-лагч	Ажил олгогч	Нийт	Даатгуу-лагч	Ажил олгогч	Нийт	
Тэтгэвэр	8.0	8.0	16.0	8.5	8.5	17.0	1.0
Тэтгэмж	0.8	1.0	1.8	0.8	1.0	1.8	-
Ажилгүйдэл	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4	-
Эрүүл мэнд	2.0	2.0	4.0	2.0	2.0	4.0	-
ҮОМШӨ		0.8-2.8	0.8-2.8		0.8-2.8	0.8-2.8	
Нийт дүн	**11.0**	**12.0-14.0**	**23.0-25.0**	**11.5**	**12.5-14.5**	**24.0-26.0**	**1.0**

2. Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зардал 2,068.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 онтой харьцуулахад 260.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Улсын Их Хурлаар 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 2019 оноос хэрэгжиж эхлэхээр шийдвэрлэсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд нь нийгмийн даатгалын сангийн зарлагыг 2019 онд 81.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үр дагавартай байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд алдагдал нь байнга нэмэгдэж байгаа тэтгэврийн даатгалын сангийн зарлага болон сангийн алдагдлыг нөхөх зорилготой улсын төсвөөс олгох татаасыг их хэмжээгээр нэмэгдүүлэхээр байгаа тул дээрх хуулиудын хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулж 2020 оноос хэрэгжиж эхлэхээр тооцож холбогдох хуулийн төслийг боловсруулаа.

2.1. Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 1,859.9 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,258.3 тэрбум төгрөгөөр тооцлоо. Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 76.0 хувийг өндөр насны тэтгэвэр, 13.0 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 7.0 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2019 онд нийт 439.9 мянган хүний тэтгэвэрт 1,858.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2018 онтой харьцуулахад 240.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

График № 1 .Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 16 дугаар тогтоолоор бүх тэтгэврийн хэмжээг 27.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээ 251.0 мянган төгрөгөөс 280.0 мянган төгрөгт хүрч 11.6 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 216.0 мянган төгрөгөөс 243.0 мянган төгрөгт хүрч 12.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График№ 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ,төгрөг



Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2019 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч байгаа эрэгтэй (60 нас) 10.8 мянга, эмэгтэй (55 нас) 16.6 мянган хүн байна. Дээрх судалгаанд үндэслэн шинээр тэтгэвэр тогтоолгох 45.9 мянган хүн, харин тэтгэвэр нь зогсох 22.8 мянга хүн, цэвэр өсөлтийг 23.1 мянган хүн байхаар тооцлоо.

Улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан цэргийн тэтгэвэрт гарах иргэдийн тоо 2019 онд 733 хүнээр нэмэгдэж нийт 18.8 мянган хүн, харин 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нийт 55.8 мянган иргэн тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаар байна.

Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээг 600.9 тэрбум төгрөг байгаагаас цэргийн болон 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 366.1 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх зорилгоор 235.5 тэрбум төгрөг олгохоор төсөвлөлөө.

Улсын төсвөөс 2017-2019 онд тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх зорилгоор нийт 791.3 тэрбум төгрөг олгоод байна.

Хүснэгт № 3. Улсын төсөв, НДС-ийн өглөг, авлагын талаар /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2017	2018	2019
1. Улсын төсвийн татаас	587.3	609.8	601.6
Үүнээс:			
1.1. Цэргийн тэтгэвэр	*103.8*	*107.9*	*130.5*
1.2.1995 оноос өмнөх	*227.0*	*202.6*	*235.6*
1.3.НДС-н алдагдалд	***256.5***	***299.3***	***235.5***

Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцож нийт 119.5 тэрбум төгрөг тусгалаа. Ингэснээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах 421.5 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх юм.

Хүснэгт №4. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

	Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
			2018 он	2019 он	
	НИЙТ	**421.5**	**343.5**	**388.6**	**119.5**
1	**Нийгмийн даатгалын тэтгэвэр**	**403.4**	**295.1**	**318.7**	**114.4**
1.1	*-Өндөр насны тэтгэвэр*	*307.0*	*351.8*	*375.4*	87.0

1.2	*-Тахир дутуугийн тэтгэвэр*	*75.3*	*262.8*	*286.4*	21.4
1.3	*-Тэжээгчээ алдсаны тэтгэвэр*	*21.1*	*269.2*	*292.8*	6.0
2	**Цэргийн алба хаасны тэтгэвэр**	**18.0**	**576.0**	**599.6**	**5.1**

2.2.Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сан 2019 онд 133.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 116.2 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар тооцлоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар (сайн дурын даатгуулагчид 70 хувь) олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

Хүснэгт№5 . Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мян хүн, тэрбум төгрөг/

	Тэтгэмж	2018 он		2019 он төсөл		Өөрчлөлт	
		Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	131.7	17.2	133.0	18.7	1.3	1.5
2	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	60.1	71.7	60.7	86.6	0.6	14.9
3	Оршуулгын тэтгэмж	13.4	13.4	13.4	13.4	0.0	0.0
	Нийт дүн	**190.5**	**101.9**	**207.1**	**118.7**	**1.9**	**16.4**

Тэтгэмжийн даатгалын сан 2015 онд 8.3 тэрбум төгрөг, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2 пунктээр нэмэгдүүлснээр 2017 онд 12.6 тэрбум, 2018 онд 9.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж сангийн үйл ажиллагаа тогтворжиж 2019 онд 17.7 тэрбум төгрөгийн ашигтай байх тооцоотой байна.

2.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (ҮОМШӨ)-ий даатгалын сан

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд 2019 онд 168.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд нийт 55.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 5.6 мянган иргэнд нийт 29.8 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

2.4. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 2019 онд 43.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 37.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Тус сангаас 2019 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 21.3 мянган иргэнд 36.6 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “2019 оны” гэснийг “2020 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн “2019 оны” гэснийг “2020 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар

Улсын Их Хурлаар 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 2019 оноос хэрэгжиж эхлэхээр шийдвэрлэсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд нь нийгмийн даатгалын сангийн зарлагыг 2019 онд 81.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үр дагавартай байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд алдагдал нь байнга нэмэгдэж байгаа тэтгэврийн даатгалын сангийн зарлага болон сангийн алдагдлыг нөхөх зорилготой улсын төсвөөс олгох татаасыг их хэмжээгээр нэмэгдүүлэхээр байгаа тул дээрх хуулиудын хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулж 2020 оноос хэрэгжиж эхлэхээр тооцож Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

-o0o-

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалтад "Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв" гэж Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас батлагдсан төсвийг, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ." гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад "Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах" гэж, мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ"-г эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцна гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулна.

2.Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллага байгуулж, даатгуулагч төвтэй тогтолцоо бий болгох замаар даатгуулагчид чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг хүргэх зорилт Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нэгдүгээрт, эрүүл мэндийн салбарт зориулсан нөөцийг хангалттай хэмжээнд нэмэгдүүлэх; хоёрдугаарт, хувь хүн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад өөрөөсөө төлдөг шууд төлбөрийн хэмжээг багасгах, эрүүл мэндийн тусламж авахад саад болж байгаа санхүүгийн дарамтыг арилгах; гуравдугаарт, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг илүү үр ашигтай, тэгш болгох шаардлагатай байна.

Мөн хүн амын өсөлтөөс үүдэлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өргөжилт, эрэлт хэрэгцээ болон эмчилгээ үйлчилгээ, эмийн үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төрийн болон төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох зардлын хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 2 бүлэг, 5 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Эрүүл мэндийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрхийн хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төслийг баталснаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2019 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хууль тогтоомж боловсруулах болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

--- oOo ---

<u>ТӨСӨЛ</u>

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ...ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Эрүүл мэндийн сайд**	**407,667.3**
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	100,615.0
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	122,486.6
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	44,502.3
	1.4 Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	83,885.0
	1.5 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	16,845.7
	1.6 Бусад орлого	39,332.7
Нийт орлого		**407,667.3**

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	**Эрүүл мэндийн сайд**	**407,667.3**
	1.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох	222,287.9
	1.2 Төрийн өмчийн аж ахуйн тооцоот эмнэлгүүдэд олгох	22,266.1
	1.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгох	8,707.3
	1.4 Хувийн эмнэлэг, эмийн санд олгох	148,710.0
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	5,422.4
	1.6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	33.6
	1.7 Бусад	240.0
Нийт зарлага		**407,667.3**

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын сан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу шимтгэлийн хөрөнгөөр тусламж, үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай худалдан авах гэрээ байгуулж, тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2019 онд 407.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 оны орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 31.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогоос 39.3 тэрбум төгрөг төвлөрөхөөр тооцсон.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 05 дугаар тогтоол (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цагт 1904 төгрөг 76 мөнгө буюу сард 320 000 төгрөг)-д нийцүүлбэл:

а. аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар;

б. хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 3200 төгрөгөөр (жилийн 38,400 төгрөг), гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 6400 төгрөгөөр (жилийн 76,800 төгрөг) буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувь байхаар тус тус тооцлоо. Эдгээрээс 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтны шимтгэлийг төр хариуцан төлж байна.

Хүснэгт №2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага /сая төгрөгөөр/

		2018 төсөв	2019 төсөл	Зөрүү
		. 1 .	. 2 .	. 2 - 1 .
	ОРЛОГО	**376,011.9**	**407,667.3**	**31,655.4**
1.	Ажил олгогч аж ахуй нэгжээс төлөх шимтгэл	97,695.4	100,615.0	2,919.6
2.	Даатгуулагчаас төлөх шимтгэл	119,572.2	122,486.6	2,914.4
3.	Төсөвт газраас төлөх шимтгэл	36,192.0	44,502.3	8,310.4
4.	Төр даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	67,723.8	83,885.0	16,161.1
5.	Бусад даатгуулагчаас төлөх	15,501.2	16,845.7	1,344.5
6.	Бусад орлого	39,327.3	39,332.7	5.4
	ЗАРЛАГА	**341,330.5**	**407,667.3**	**66,336.7**
1.	Улсын эмнэлгүүдэд олгох	214,507.9	222,287.9	7,780.0
2.	Сум, тосгоны эмнэлгүүдэд олгох		8,707.3	8,707.3
3.	Төрийн өмчит аж ахуйн тооцоот эмнэлгүүдэд олгох		22,266.1	22,266.1
4.	Эмийн сан, хувийн эмнэлэгт олгох	122,531.2	148,710.0	26,178.8
5.	Ажиллагааны зардалд зарцуулсан	4,017.9	5,422.4	1,404.6
6.	Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	33.6	33.6	0.0
7.	НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	240.0	240.0	0.0
	АШИГ, АЛДАГДАЛ	**34,681.4**	**0.0**	**-34,681.4**

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2019 оны төсвийн төслийг эрүүл мэндийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн 1,611 эрүүл мэндийн байгууллага, эмийн сан (улсын төв, тусгай мэргэжлийн төв, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв зэрэг 54 эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, орон нутгийн уламжлалт анагаах ухааны төв 6, сум дундын 36 эмнэлэг, хувийн хэвшлийн 191 эмнэлэг, рашаан сувилал 55, эмийн сан 911, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 327, элэгний В, С вирусийг тодорхойлох лаборатори 25)-гийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээг худалдан авахаар тооцон 407.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 оны төлөвлөгөөнөөс 66.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын өмчийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор баталсан хувьсах зардлын хэмжээ, оношийн бүлэг, өртгийн жин, эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлт зэргийг үндэслэн төрийн өмчийн эмнэлгүүдээс худалдан авах тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2019 онд 222.3 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2018 оны төлөвлөснөөс 7.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

а) Төрийн өмчийн эмнэлгийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1 дэх хэсгийн дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг олгож байна.

Төрийн өмчийн эмнэлгүүдийн ачаалал ихсэж уртасгасан цагаар ажиллах, тоног төхөөрөмж нэмэгдэх, ор болон өргөтгөл байшин, барилга ашиглалтад орохтой холбоотой зардлууд нэмэгдсэн. Зардлыг тооцохдоо урд оны гүйцэтгэл, төрийн өмчийн эмнэлгүүд болон ЭМДЕГ-аас ирсэн санал, тооцоо судалгааг үндэслэн боловсруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Улсын хэмжээнд 2018-2019 онд ашиглах эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай" А/234 дүгээр тушаалаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын ор болон хүчин чадал нь нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт мөн нэмэгдэж байна.

б) Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн хэрэгслийн үнийн зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8 дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн хэрэгслийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. 2018 оны 6 дугаар сарын 25-ны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Журам, жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 11 дүгээр тогтоолоор хэрэгслийн нэр төрлийг шинэчилсэн.

Өмнөх оны гүйцэтгэл, энэ оны төлөвлөгөөнд үндэслэн уг зардлыг 2019 онд 38.4 тэрбум төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь 2018 оны төлөвлөгөөнөөс 4.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас төрийн өмчит аж ахуйн тооцоот эмнэлгүүдэд олгох зардлын төсвийн талаар:

Энэ зардалд улсын хоёрдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв болон Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа түшиц эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчдын зардлыг 22.3 тэрбум төгрөгөөр тусгав.

3. Эрүүл мэндийн даатгалын сангаас сум, тосгоны эмнэлэг, эмийн сан, хувийн хэвшлийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

Хувийн хэвшлийн эмнэлэгт олгох эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийн талаар**:**

1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн хэвшлийн 6388 ор бүхий 191 эмнэлгийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234 дугаар тушаалаар баталсан орны тоог үндэслэн 2019 онд 49.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ,

гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ”-г эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцна гэж заасан. Иймд 2019 онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 15.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2-т “Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах...”, 3.1.3-т "Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ", 3.3.20-д “Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулан...” гэж тус тус заасан байна. Энэ дагуу даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний зардалд нийт 13.8 тэрбум төгрөг, В, С вирусийг тоолох шинжилгээ, вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг 8.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 32.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

4. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 10 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн батлаж 233 ерөнхий нэршлийн 827 худалдааны нэрийн эмэнд 20-80 хувийн хөнгөлөлт үзүүлэхээр заасан. Энэ дагуу эрүүл мэндийн даатгалтай гэрээ бүхий эмийн сангуудаас 2019 оны төсвийн төслийн санал мөн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс эмийн сангийн саналыг авч боловсруулсан. ЭМДЕГ-ын тооцоогоор энэ оны төсөв зайлшгүй шаардлагатай эмийн нийт эрэлтийн 50 хувийг хамарч байгаа бол 2019 онд 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 34.0 тэрбум болгосноор нийт эрэлтийн 60 хувийг хамрахаар тооцож төсөвлөсөн.

5. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт №1

/сая төгрөг/

	2019 төсөл							
	НЭГДСЭН ТӨСӨВ		УЛСЫН ТӨСӨВ			Орон нутаг	НДС	ЭМДС
			НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаад зээл, тусламжаас санхүүжих			
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**11,067,000.0**		**8,694,095.7**	**8,548,095.7**	**146,000.0**	**2,849,630.6**	**2,208,833.8**	**407,667.3**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**322,000.0**		**322,000.0**	**322,000.0**				
ИРЭЭДҮЙН ӨВ САН	**1,068,520.0**		**1,068,520.0**	**1,068,520.0**				
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**9,676,480.0**	**27.4%**	**7,303,575.7**	**7,157,575.7**	**146,000.0**	**2,849,630.6**	**2,208,833.8**	**407,667.3**
1. Татварын орлого	**8,585,770.0**		**5,754,690.0**	**5,754,690.0**	**0.0**	**1,133,800.0**	**1,603,341.0**	**407,667.3**
1.1. Орлогын албан татвар	2,016,000.0		1,240,000.0	1,240,000.0	0.0	776,000.0	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	776,000.0		0.0	0.0	0.0	776,000.0	0.0	0.0
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,240,000.0		1,240,000.0	1,240,000.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0		0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын орлого	1,697,280.0		0.0	0.0	0.0	0.0	1,603,341.0	407,667.3
1.3. Хөрөнгийн албан татвар	138,170.0		0.0	0.0	0.0	138,170.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,321,100.0		2,321,100.0	2,321,100.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	837,800.0		837,800.0	837,800.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	12,200.0		12,200.0	12,200.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	743,020.0		743,020.0	743,020.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	820,200.0		600,570.0	600,570.0	0.0	219,630.0	0.0	0.0
2. Татварын бус орлого	**1,090,710.0**		**1,548,885.7**	**1,402,885.7**	**146,000.0**	**1,715,830.6**	**605,492.8**	**0.0**
2.1. Нийтлэг татварын бус орлого	944,130.0		840,159.5	840,159.5	0.0	103,970.5	0.0	0.0
2.2. Хөрөнгийн орлого	580.0		0.0	0.0	0.0	580.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	146,000.0		146,000.0	0.0	146,000.0	0.0	0.0	0.0
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0		562,726.2	562,726.2	0.0	1,611,280.2	605,492.8	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**11,589,760.8**	**32.8%**	**9,357,150.7**	**7,985,650.7**	**1,371,500.0**	**2,849,630.6**	**2,068,539.6**	**407,667.3**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**8,230,816.5**		**6,679,013.8**	**6,501,454.5**	**177,559.4**	**2,168,823.2**	**2,068,539.6**	**407,667.3**
1. Бараа, үйлчилгээний зардал	**3,941,666.0**		**2,454,721.5**	**2,277,162.1**	**177,559.4**	**1,687,362.4**	**24,007.5**	**5,326.0**
1.1. Цалин, хөлс	2,215,239.3		1,208,867.6	1,208,867.6	0.0	987,923.7	16,703.6	1,744.4
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0		103,568.5	103,568.5	0.0	124,058.6	1,906.3	218.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,726,426.6		1,142,285.4	964,726.0	177,559.4	575,380.1	5,397.6	3,363.6
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**865,585.5**		**865,585.5**	**865,585.5**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**3,423,565.0**		**3,358,706.8**	**3,358,706.8**	**0.0**	**481,460.8**	**2,044,532.1**	**402,341.3**
3.1. Татаас	261,837.7		722,074.0	722,074.0	0.0	91,712.2	0.0	53,544.3
3.2. Урсгал шилжүүлэг	3,161,727.4		2,636,632.9	2,636,632.9	0.0	389,748.6	2,044,532.1	348,797.0
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**3,214,839.0**		**2,534,031.5**	**1,461,090.9**	**1,072,940.6**	**680,807.4**	**0.0**	**0.0**
1. Барилга байгууламж	2,008,962.9		1,969,771.9	1,159,912.6	809,859.3	39,191.0	0.0	0.0
2. Их засвар	122,005.1		122,005.1	104,136.4	17,868.7	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	308,911.7		308,911.7	98,201.0	210,710.7	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	754,079.6		112,463.1	77,961.1	34,502.0	641,616.4	0.0	0.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	20,879.7		20,879.7	20,879.7	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**144,105.4**		**144,105.4**	**23,105.4**	**121,000.0**	**0.0**	**0.0**	**0.0**
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	23,105.4		23,105.4	23,105.4	0.0	0.0	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	121,000.0		121,000.0	0.0	121,000.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	**-1,913,280.8**	**-5.4%**	**-2,053,575.0**	**-828,075.0**	**-1,225,500.0**	**0.0**	**140,294.2**	**0.0**

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт №1

/сая төгрөг/

	2019 төсөл						
	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ			Орон нутаг	НДС	ЭМДС
		НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаад зээл, тусламжаас санхүүжих			
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**1,913,280.8**	**2,053,575.0**	**828,075.0**	**1,225,500.0**	**0.0**	**-140,294.2**	**0.0**
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	**-0.1**	**140,294.1**	**590,294.1**	**-450,000.0**	**0.0**	**-140,294.2**	**0.0**
2. ЗГ-ын үнэт цаас	**252,156.6**	**252,156.6**	**252,156.6**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
2.1. Урт хугацаат	252,156.6	252,156.6	252,156.6	0.0	0.0	0.0	0.0
2.1.1. Дотоод	252,156.6	252,156.6	252,156.6	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.1. Шинээр гаргах	474,256.6	474,256.6	474,256.6				
2.1.1.2. Үндсэн төлбөр	-222,100.0	-222,100.0	-222,100.0				
2.2. Богино хугацаат	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1. Дотоод	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.1. Шинээр гаргах	493,959.0	493,959.0	493,959.0				
2.2.1.2. Үндсэн төлбөр	-493,959.0	-493,959.0	-493,959.0				
3. ЗГ-ын зээл	**1,289,124.3**	**1,289,124.3**	**-386,375.7**	**1,675,500.0**	**0.0**	**0.0**	**0.0**
3.1. Дотоод	465,424.3	465,424.3	465,424.3	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Авлага	465,424.3	465,424.3	465,424.3	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.1. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	465,424.3	465,424.3	465,424.3				
3.2. Гадаад	823,700.0	823,700.0	-851,800.0	1,675,500.0	0.0	0.0	0.0
3.2.1. Төслийн зээл	373,700.0	373,700.0	-851,800.0	1,225,500.0	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр авах	1,225,500.0	1,225,500.0		1,225,500.0			
3.2.1.2. Үндсэн төлбөр	-851,800.0	-851,800.0	-851,800.0				
3.2.2. Хөтөлбөрийн зээл	450,000.0	450,000.0	0.0	450,000.0	0.0	0.0	0.0
3.2.2.1. Шинээр авах	450,000.0	450,000.0		450,000.0			
3.2.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0		0.0		0.0	0.0
4. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	**50,000.0**	**50,000.0**	**50,000.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
5. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	**322,000.0**	**322,000.0**	**322,000.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
6. Өмч хувьчлал	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
7. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	**35,331,340.1**						

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ - ДНБ-д харьцуулсан

Хавсралт №2

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ЭМДС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**31.32**	**24.61**	**6.25**	**1.15**	**8.07**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**0.91**	**0.91**	**0.00**	**0.00**	**0.00**
ИРЭЭДҮЙН ӨВ САН	**3.02**	**3.02**	**0.00**	**0.00**	**0.00**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**27.39**	**20.67**	**6.25**	**1.15**	**8.07**
1. Татварын орлого	**24.30**	**16.29**	**4.54**	**1.15**	**3.21**
1.1. Орлогын албан татвар	5.71	3.51	0.00	0.00	2.20
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2.20	0.00	0.00	0.00	2.20
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	3.51	3.51	0.00	0.00	0.00
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.00	0.00	0.00	0.00	0.00
1.2. Нийгмийн даатгалын орлого	4.80	0.00	4.54	1.15	0.00
1.3. Хөрөнгийн албан татвар	0.39	0.00	0.00	0.00	0.39
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	6.57	6.57	0.00	0.00	0.00
1.5. Онцгой албан татвар	2.37	2.37	0.00	0.00	0.00
1.6. Тусгай зориулалтын орлого	0.03	0.03	0.00	0.00	0.00
1.7. Гаалийн албан татвар	2.10	2.10	0.00	0.00	0.00
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2.32	1.70	0.00	0.00	0.62
2. Татварын бус орлого	**3.09**	**4.38**	**1.71**	**0.00**	**4.86**
2.1. Нийтлэг татварын бус орлого	2.67	2.38	0.00	0.00	0.29
2.2. Хөрөнгийн орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2.3. Тусламжийн орлого	0.41	0.41	0.00	0.00	0.00
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	1.59	1.71	0.00	4.56
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**32.80**	**26.48**	**5.85**	**1.15**	**8.07**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**23.30**	**18.90**	**5.85**	**1.15**	**6.14**
1. Бараа, үйлчилгээний зардал	**11.16**	**6.95**	**0.07**	**0.02**	**4.78**
1.1. Цалин, хөлс	6.27	3.42	0.05	0.00	2.80
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.00	0.29	0.01	0.00	0.35
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	4.89	3.23	0.02	0.01	1.63
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**2.45**	**2.45**	**0.00**	**0.00**	**0.00**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**9.69**	**9.51**	**5.79**	**1.14**	**1.36**
3.1. Татаас	0.74	2.04	0.00	0.15	0.26
3.2. Урсгал шилжүүлэг	8.95	7.46	5.79	0.99	1.10
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**9.10**	**7.17**	**0.00**	**0.00**	**1.93**
1. Барилга байгууламж	5.69	5.58	0.00	0.00	0.11
2. Их засвар	0.35	0.35	0.00	0.00	0.00
3. Тоног төхөөрөмж	0.87	0.87	0.00	0.00	0.00
4. Бусад хөрөнгө	2.13	0.32	0.00	0.00	1.82
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.06	0.06	0.00	0.00	0.00
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**0.41**	**0.41**	**0.00**	**0.00**	**0.00**
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	0.07	0.07	0.00	0.00	0.00
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.34	0.34	0.00	0.00	0.00
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	**-5.42**	**-5.81**	**0.40**	**0.00**	**0.00**
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	**35,331,340.1**	**35,331,340.1**	**35,331,340.1**	**35,331,340.1**	**35,331,340.1**

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт №3

/сая төгрөг/

	2011	2012	2013	2014	2015	2016	2017		2018	2019	Зөрүү
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Төл	Гүйц	Бат	Төсөл	
	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.7.	.8.	.9.	.10.	.10-9.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,468,198.0**	**4,975,828.4**	**5,986,925.2**	**6,316,522.6**	**5,983,397.7**	**5,835,043.8**	**7,112,872.2**	**7,958,264.6**	**7,862,896.0**	**11,067,000.0**	**3,204,104.0**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**241,019.9**	**94,656.5**	**46,858.6**	**39,913.8**	**2,333.7**	**0.0**	**242,417.9**	**325,680.2**	**122,747.2**	**322,000.0**	**199,252.8**
ИРЭЭДҮЙН ӨВ САН	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**333,345.1**	**357,722.8**	**508,744.3**	**1,068,520.0**	**559,775.7**
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,227,178.1**	**4,881,171.9**	**5,940,066.7**	**6,276,608.8**	**5,981,064.0**	**5,835,043.8**	**6,537,109.3**	**7,274,861.6**	**7,231,404.5**	**9,676,480.0**	**2,445,075.5**
1. Татварын орлого	**3,668,307.8**	**4,203,321.5**	**5,072,793.3**	**5,157,024.5**	**5,118,979.4**	**4,950,950.2**	**5,661,334.0**	**6,315,131.9**	**6,268,947.4**	**8,585,770.0**	**2,316,822.6**
1.1. Орлогын албан татвар	833,738.9	871,401.5	1,109,204.9	1,101,030.2	1,170,831.3	1,043,368.7	1,330,784.2	1,613,192.8	1,407,878.4	2,016,000.0	608,121.6
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	232,257.3	347,019.7	449,045.9	479,793.2	482,334.5	523,410.0	602,109.6	651,047.9	716,481.1	776,000.0	59,518.9
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	545,631.1	524,325.9	660,159.0	621,237.0	688,496.8	519,958.7	728,674.7	962,144.9	691,397.3	1,240,000.0	548,602.7
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	55,850.6	55.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	473,351.3	674,240.2	874,229.2	917,589.8	1,018,152.9	1,109,757.4	1,248,513.0	1,321,375.2	1,431,052.6	1,697,280.0	266,227.4
1.3. Хөрөнгийн албан татвар	17,152.2	21,929.9	43,975.4	50,109.4	86,610.1	104,659.9	98,617.3	131,129.6	111,202.3	138,170.0	26,967.7
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,114,382.5	1,296,450.9	1,435,091.6	1,371,725.4	1,049,588.7	1,140,721.4	1,448,504.9	1,618,492.1	1,517,318.4	2,321,100.0	803,781.6
1.5. Онцгой албан татвар	293,967.0	312,384.2	449,410.3	454,390.3	592,323.6	630,124.8	511,577.7	519,721.5	684,315.0	837,800.0	153,485.0
1.6. Тусгай зориулалтын орлого	26,379.5	33,977.5	36,688.4	39,862.8	11,791.8	10,767.4	11,941.1	12,386.6	12,057.2	12,200.0	142.8
1.7. Гаалийн албан татвар	337,422.6	327,369.8	381,427.0	355,328.9	320,594.9	328,490.6	489,784.0	512,351.2	536,906.7	743,020.0	206,113.3
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	571,913.8	665,567.4	742,766.6	866,987.9	869,086.2	583,060.0	521,611.7	586,482.8	568,216.8	820,200.0	251,983.2
2. Татварын бус орлого	**558,870.3**	**677,850.4**	**867,273.4**	**1,119,584.3**	**862,084.7**	**884,093.5**	**875,775.3**	**959,729.8**	**962,457.1**	**1,090,710.0**	**128,252.9**
2.1. Нийтлэг татварын бус орлого	545,366.5	642,742.4	860,560.9	1,094,468.1	753,507.1	805,424.9	799,687.6	896,708.4	851,977.6	944,130.0	92,152.4
2.2. Хөрөнгийн орлого	11,962.0	10,426.4	6,712.5	25,116.3	55,137.9	1,487.3	355.0	1,187.9	479.5	580.0	100.5
2.3. Тусламжийн орлого	1,541.8	24,681.7	0.0	0.0	53,439.6	77,181.3	75,732.7	61,833.5	110,000.0	146,000.0	36,000.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	**4,997,039.9**	**6,017,800.5**	**6,164,685.3**	**7,144,568.0**	**7,137,973.9**	**9,495,332.9**	**9,154,514.9**	**9,017,318.6**	**9,651,530.4**	**11,589,760.8**	**1,938,230.4**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**3,236,402.9**	**4,428,111.6**	**4,552,606.6**	**5,293,361.6**	**5,718,373.8**	**6,613,809.1**	**7,001,594.2**	**7,043,161.7**	**7,455,852.8**	**8,230,816.5**	**774,963.7**
1. Бараа, үйлчилгээний зардал	**1,504,504.7**	**2,052,438.6**	**2,391,174.1**	**2,652,480.8**	**2,801,673.1**	**3,133,289.2**	**3,089,141.7**	**3,141,432.3**	**3,257,508.2**	**3,941,666.0**	**684,157.8**
1.1. Цалин, хөлс	802,464.7	1,197,164.8	1,401,530.8	1,586,419.5	1,709,772.9	1,746,794.8	1,766,831.7	1,800,434.6	1,797,090.0	2,215,239.3	418,149.3
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	702,039.9	855,273.8	989,643.3	1,066,061.3	1,091,900.2	1,386,494.4	1,322,310.0	1,340,997.7	1,460,418.1	1,726,426.6	266,008.5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	**37,321.0**	**125,913.4**	**270,442.1**	**500,351.2**	**731,055.1**	**986,099.8**	**1,156,688.1**	**1,156,465.1**	**1,150,740.0**	**865,585.5**	**-285,154.5**
3. Татаас ба урсгал шилжүүлэг	**1,694,577.3**	**2,249,759.6**	**1,890,990.3**	**2,140,529.6**	**2,185,645.6**	**2,494,420.0**	**2,755,764.3**	**2,745,264.2**	**3,047,604.6**	**3,423,565.0**	**375,960.4**
3.1. Татаас	122,880.7	127,027.7	175,838.7	167,195.4	101,482.0	229,325.3	199,271.9	260,619.2	233,851.7	261,837.7	27,985.9
3.2. Урсгал шилжүүлэг	1,571,696.6	2,122,731.9	1,715,151.6	1,973,334.2	2,084,163.5	2,265,094.8	2,556,492.4	2,484,645.0	2,813,752.9	3,161,727.4	347,974.5
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**1,280,919.6**	**1,525,357.6**	**1,490,741.7**	**1,771,069.2**	**1,396,704.6**	**2,360,210.2**	**1,813,524.9**	**1,658,140.7**	**1,928,523.4**	**3,214,839.0**	**1,286,315.5**
1. Барилга байгууламж	1,031,382.4	1,267,212.3	1,253,958.7	1,505,934.2	614,548.4	1,576,950.9	1,041,164.1	1,121,662.4	1,049,796.4	2,008,962.9	959,166.5
2. Их засвар	50,138.8	53,480.4	88,079.0	91,874.8	110,773.2	129,004.7	77,939.7	66,992.7	72,209.6	122,005.1	49,795.5
3. Тоног төхөөрөмж	160,003.4	138,150.4	103,003.3	142,233.0	73,837.4	0.0	99,658.7	0.0	292,585.2	308,911.7	16,326.5
4. Бусад хөрөнгө	8,812.8	7,280.6	12,626.7	12,836.1	136,065.3	401,482.3	558,451.3	469,485.7	482,752.4	754,079.6	271,327.1
5. Стратегийн нөөц хөрөнгө	30,582.1	59,233.8	33,073.9	18,191.1	27,829.7	0.0	36,311.2	0.0	31,179.7	20,879.7	-10,300.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	433,650.6	252,772.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗӨЭЛ	**479,717.4**	**64,331.4**	**121,337.0**	**80,137.1**	**22,895.4**	**521,313.6**	**339,395.8**	**316,016.2**	**267,154.2**	**144,105.4**	**-123,048.8**
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	475,667.5	11,543.0	104,701.5	10,715.4	-17,588.9	487,553.2	145,806.2	200,817.3	145,931.5	23,105.4	-122,826.2
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	4,049.8	52,788.4	16,635.5	69,421.7	40,484.3	33,760.4	193,589.6	115,198.9	121,222.7	121,000.0	-222.7
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	**-769,861.8**	**-1,136,628.6**	**-224,618.7**	**-867,959.1**	**-1,156,909.8**	**-3,660,289.1**	**-2,617,405.6**	**-1,742,456.9**	**-2,420,125.9**	**-1,913,280.8**	**506,845.1**
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**769,861.8**	**1,136,628.6**	**224,618.7**	**867,959.1**	**1,156,909.8**	**3,660,289.1**	**2,617,405.6**	**1,742,456.9**	**2,420,125.9**	**1,913,280.8**	**-506,845.1**
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	**-218,199.3**	**-1,702,895.0**	**-960,995.9**	**144,034.6**	**-43,861.0**	**-112,351.4**	**0.0**	**-1,013,222.2**	**0.0**	**-0.1**	**-0.1**
2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	
3. ЗГ-ын үнэт цаас	**318,245.8**	**2,587,791.7**	**1,039,436.9**	**1,050,847.8**	**681,425.7**	**3,332,685.0**	**-36,665.3**	**206,613.0**	**-422,620.5**	**252,156.6**	**674,777.1**
2.1. Урт хугацаат	318,245.8	1,913,883.9	983,486.1	1,051,821.4	681,799.6	3,332,756.2	-36,665.3	206,925.8	-422,620.5	252,156.6	674,777.1
2.1.1. Дотоод	318,245.8	-174,266.1	983,486.1	1,051,821.4	366,870.5	2,311,511.2	-2,035,197.4	-2,305,397.6	256,721.2	252,156.6	-4,564.7
2.1.1.1. Шинээр гаргах	353,245.8	13,669.4	1,091,586.1	1,527,906.6	1,359,201.8	3,754,214.2	1,752,305.8	1,759,934.2	2,389,693.9	474,256.6	-1,915,437.3
2.1.1.2. Үндсэн төлбөр	-35,000.0	-187,935.5	-108,100.0	-476,085.2	-992,331.3	-1,300,415.2	-2,787,503.2	-3,065,331.8	-2,132,972.7	-222,100.0	1,910,872.7
2.1.1.3. Худалдаж авах	0.0	0.0	0.0	0.0	0.0	-142,287.8	-1,000,000.0	-1,000,000.0	0.0	0.0	0.0
2.1.2. Гадаад	0.0	2,088,150.0	0.0	0.0	314,929.1	1,021,245.0	1,998,532.2	2,512,323.4	-679,341.7	0.0	679,341.7
2.1.2.1. Шинээр гаргах	0.0	2,088,150.0	0.0	0.0	314,929.1	1,021,245.0	3,968,532.2	3,463,141.0	1,000,800.0	0.0	-1,000,800.0
2.1.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-1,970,000.0	-950,817.6	-1,680,141.7	0.0	1,680,141.7
2.2. Богино хугацаат	0.0	673,907.8	55,950.8	-973.6	-373.9	-71.2	0.0	-312.8	0.0	0.0	0.0
2.2.1. Дотоод	0.0	673,907.8	55,950.8	-973.6	-373.9	-71.2	0.0	-312.8	0.0	0.0	0.0
2.2.1.1. Шинээр гаргах	0.0	867,959.4	1,506,269.4	897,900.3	1,077,570.7	282,754.4	1,366,455.4	1,366,168.8	419,711.4	493,959.0	74,247.6
2.2.1.2. Үндсэн төлбөр	0.0	-194,051.6	-1,450,318.6	-898,873.9	-1,077,944.6	-282,825.5	-1,366,455.4	-1,366,481.5	-419,711.4	-493,959.0	-74,247.6
4. ЗГ-ын зээл	**194,517.8**	**182,588.4**	**222,717.8**	**142,650.6**	**572,240.8**	**1,485,977.3**	**1,907,909.4**	**1,794,729.6**	**2,519,278.9**	**1,289,124.3**	**-1,230,154.6**
3.1. Дотоод	-4,791.5	-3,426.4	-3,753.0	-109,945.8	188,261.5	271,534.0	-293,126.5	-269,616.6	408,744.3	465,424.3	56,680.0
3.1.1. Зээл	-4,791.5	-3,426.4	-3,753.0	-109,945.8	-5,254.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.1. Шинээр гаргах	0.0	228,000.0	0.0	0.0	0.0	200,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.2. Үндсэн төлбөр	-4,791.5	-231,426.4	-3,753.0	-109,945.8	-5,254.7	-200,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Авлага	0.0	0.0	0.0	0.0	-240,134.4	18,761.7	173,345.1	196,855.0	408,744.3	465,424.3	56,680.0
3.1.2.1. Шинээр үүсгэх	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0	0.0	0.0	-240,134.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.3. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0	18,761.7	173,345.1	196,855.0	408,744.3	465,424.3	56,680.0
3.1.3. Төсвөөс эргэн төлөгдөх	0.0	0.0	0.0	0.0	433,650.6	252,772.3	-466,471.6	-466,471.6	0.0	0.0	0.0
3.1.3.1. Авах	0.0	0.0	0.0	0.0	433,650.6	252,772.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.3.2. Төлөх	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-466,471.6	-466,471.6	0.0	0.0	0.0
3.2. Гадаад	199,309.3	186,014.8	226,470.8	252,596.5	383,979.2	1,214,443.3	2,201,035.9	2,064,346.2	2,110,534.6	823,700.0	-1,286,834.6
3.2.1. Төслийн зээл	161,081.5	155,064.0	226,470.8	252,596.5	184,753.2	626,939.6	710,884.9	586,241.6	576,091.1	373,700.0	-202,391.1
3.2.1.1. Шинээр авах	233,253.7	240,744.6	321,102.0	369,029.5	305,867.9	762,554.3	878,585.2	751,487.3	835,900.0	1,225,500.0	389,600.0
3.2.1.2. Үндсэн төлбөр	-72,172.2	-85,680.5	-94,631.2	-116,433.1	-121,114.6	-135,614.7	-167,700.3	-165,245.7	-259,808.9	-851,800.0	-591,991.1
3.2.2. Хөтөлбөрийн зээл	0.0	30,950.8	0.0	0.0	199,226.0	587,503.7	1,490,151.0	1,478,104.7	1,534,443.5	450,000.0	-1,084,443.5
3.2.2.1. Шинээр авах	0.0	30,950.8	0.0	0.0	199,226.0	587,503.7	1,490,151.0	1,478,104.7	1,534,443.5	450,000.0	-1,084,443.5
3.2.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. Урьдчилгаа төлбөр	**461,469.0**	**63,194.7**	**-76,540.2**	**-469,573.8**	**-52,895.6**	**-46,021.9**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
6. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**160,000.0**	**160,000.0**	**100,000.0**	**50,000.0**	**-50,000.0**
7. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**572,106.5**	**572,106.5**	**122,747.2**	**322,000.0**	**199,252.8**
8. ЗГ-ын хөрөнгө оруулалт	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**-1,000,000.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**
9. Өмч хувьчлал	**13,828.4**	**5,948.9**	**0.0**	**0.0**	**0.0**	**0.0**	**14,055.0**	**22,230.0**	**100,720.3**	**0.0**	**-100,720.3**
8. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	**10,829,689.6**	**13,944,238.1**	**17,550,173.3**	**21,937,159.4**	**23,166,779.1**	**23,886,409.5**	**27,438,000.0**	**27,167,034.7**	**30,387,000.0**	**35,331,340.1**	**4,944,340.1**

/ДНБ-д эзлэх хувь/

	2011	2012	2013	2014	2015	2016	2017		2018	2019
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Төл	Гүйц	Бат	Төсөл
	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.7.	.8.	.9.	.10.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**41.3**	**35.7**	**34.1**	**28.8**	**25.8**	**24.4**	**25.9**	**29.3**	**25.9**	**31.3**
